

ЭДИЙН ЗАСАГ

Монгол Улсын өр аюулын харанга дэлдэж байна
Хуримтлал үгүй өрхийн төсөв


БИЗНЕС

Тогтвортой байгаа ч туйлдаж магадгүй

БАНК САНХҮҮ

Шаардлагатай хөрөнгө оруулалтыг зогсоож
болохгүй

Алт дилерийн хэрэг буюу ИХ ӨР-2



B. Saravj

Дэлхийн эдийн засгийн замын зураг
бүтэн жилийн турш тантай хамт

Дэлхий 2016

Дэлхий нийтийн ирээдүйн урьдчилсан таамаг

The Economist's Таны ирэх
жилийн хөтөч

The Economist сэтгүүлийн жилийн “THE WORLD IN 2016” дугаарыг Монгол дахь албан ёсны тусгай зөвшөөрөлтэйгээр “**Mongolian Economy**” сэтгүүл монгол хэлээр эрхлэн гаргах гэж байна. Энэхүү дугаарт дэлхийн 2016 оны эдийн засаг, санхүү, бизнесийн хөгжлийн талаарх нийтлэл орохоос гадна манай редакцийн дотооддоо бэлтгэсэн Монгол Улсын эдийн засгийн ирэх оны хөгжлийг таамагласан нийтлэлүүд ч орох болно.

2016.01 сард танд хүрнэ



Утас 94092904, 94092905, 70115476, 70115477

www.marketing@mongolianeconomy.mn

www.info@mongolianeconomy.mn

MONGOLIAN
ECONOMY

MONGOLIAN
ECONOMY

IV-Р УЛИРЛЫН ЗАХИАЛГА ЭХЭЛЛЭЭ



УТАС: 70115476, 94092904

Үүсгэн байгуулагч, Эрхлэгч:

Д.БЭХБАЯР / 9999-4248

Үүсгэн байгуулагч, Орлогч эрхлэгч:

И.ОТГОНЖАРГАЛ / 8800-6228

Сэтгүүлийн редактор:

Б.ҮРИЙНТУЯА

Англи хэлний редактор:

О.ТҮВШИН

ВЭБ РЕДАКТОР:

Б.ЭНХЦЭЦЭГ

Сэтгүүлчид:

А.БҮРЭНЖАРГАЛ

Г.ОРХОН

Ц.ЭЛБЭГСАЙХАН

Дизайнер:

Б.СЭР-ОД

Орчуулагч:

Б.ЭНХМӨНХ

Маркетингийн менежер:

Д.БАРИАНЖАВ / 9409 2904/

Э.ЗОРИГТ /9409 2905/

ХАЯГ

Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг.

I хороо, Энхтайвны өргөн чөлөө.

Экспресс таур. 1101 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан,

ш/ х-2762

WWW.MONGOLIANECONOMY.MN

INFO@MONGOLIANECONOMY.MN

Утас/Факс: 976 - 7011 5476

"Улаанбаатар Принт" ХХК-д хэвлэв

WWW.UBPRINT.MN

Борлуулах цэгүүд:

"Интер ном"

"Цэцэг төв"

"Минж плаза"

"Алтантүлхүүр" номын дэлгүүр

"Номин" супермаркетиin бүх салбар

"Макс" супермаркетиin бүх салбар

"Фреско" супермаркет

BTSI супермаркет

"Аз орчлон" номын дэлгүүр

"Билэг" их дэлгүүрийн номын тасаг

"Гранд Плаза" дахь супермаркет

"Мир" номын дэлгүүрийн

"GRAND PLAZA"

"METRO MALL"

"Sky" супермаркет

"Улаанбаатар" их дэлгүүр

"Мах mall" дэх салбарууд

**4-Р УЛИРЛЫН
ЗАХИАЛГА
ЭХЭЛЛЭЭ**



ЭДИЙН ЗАСАГ

- 8 АЛДАГДЛЫГ ТОДОТГОНО
- 9 ХУРИМТЛАЛ ҮГҮЙ ӨРХИЙН ТӨСӨВ
- 11 МАНГАС, БААТАР, ГҮНЖ ГУРАВ
- 16 АСЕМ-ЫН АРГА
ХЭМЖЭЭГ ДЭЭД ЗЭРГЭЭР "АШИГЛАХ" ЁСТОЙ
- 19 АЛТ ДИЛЕРИЙН ХЭРЭГ-2 БУЮУ ИХ ӨР-2
- 22 Г.ЗАНДАНШАТАР: МОНГОЛ УЛСЫН ӨР АЮУЛЫН ХАРАНГА
ДЭЛДЭЖ БАЙНА
- 26 ГАДААД ӨРИЙН ДАРАМТАД ОРЖ БАЙСАН
ХОЁР ОРНЫ ЖИШЭЭ
- 27 БИАТРИС ДИ МАУРО: МОНГОЛ ДАРААГИЙН ГРЕК
ГЭЖ ХЭЛЭХГҮЙ Ч ӨРТӨМГИЙ БАЙНА
- 29 ӨРИЙН ХАВХНААС ӨНДИЙХ БОЛОМЖ

БИЗНЕС

- 30 ТОГВОРТОЙ БАЙГАА
Ч ТУЙЛДАЖ МАГАДГҮЙ
- 33 БҮРХЭГ ИРЭЭДҮЙН БҮҮДГЭР ТААМАГ
- 34 ЭРЭЛТ ДАГАЖ ХУВЬСАХ ҮЛ ХӨДЛӨХ
- 34 ЗАХ ЗЭЭЛ ЮУ ХҮСЭЖ БАЙНА
ТҮҮНИЙГ ҮЙЛДВЭРЛЭНЭ

БАНК САНХҮҮ

- 38 ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ
ЗОГСООЖ БОЛОХГҮЙ
- 41 САЙН ЗАСАГЛАЛТАЙ "БАЯНГОЛ" ХК
- 42 Э.УРАНБИЛЭГ: ТЭТГЭВРИЙН САНГИЙН
СУЛ ТАЛЫГ НӨХНӨ



Хамтын ажиллагаа



Хятад, Орос, Монгол гурван улсын эдийн засгийн коридор байгуулах ажлын хүрээнд Монгол Улсад үйлдвэрлэл эрхлэх ажилд Хятадын тал дэмжлэг үзүүлэх гэнэ. Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат тус улсад айлчлах үеэр зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр, БНХАУ-тай хил залгаа аймгуудад мах боловсруулах үйлдвэрүүд байгуулахад Хятадын тал хөрөнгө оруулалт хийх, боловсруулсан бүтээгдэхүүнээ БНХАУ-д экспортлоход дэмжлэг үзүүлж хамтран ажиллах талаар хэлэлцжээ. Мөн хил дамнансан эдийн засгийн чөлөөт бүс байгуулах ажлын эрчимжүүлэхээр хоёр тал ажлын хэсэг гарган ажиллуулахаар болсон байна.

Ипотек




Өнгөрсөн наймдугаар сарын байдлаар 1106 зээлдэгч 60.9 тэрбум төгрөгийн ипотекийн зээл авчээ. Ингэснээр зээлийн нийт үлдэгдэл 3.2 их наяд төгрөгт хүрчээ. Харин нийт 73 мянга 949 хүн одоогоор ипотекийн зээлтэй байгаа юм. Түүнчлэн ипотекийн зээлийн нийт үлдэгдлийн 74.5 хувь нь найман хувийн хүүтэй зээл эзэлж буй аж.

Нийт үлдэгдлийн 23.5 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээс олгосон зээл бүрдүүлж байгаа талаар Монголбанкнаас мэдээллээ. Ипотекийн зээлийн үлдэгдлийн 68.3 хувь буюу дийлэнх нь 16-20 жил, 18.9 хувь нь 11-15 жил, 10.7 хувь нь 6-10 жил, 2.1 хувь

нь 1-5 жилийн хугацаатай байна. Үүнээс гадна уг зээлийн эргэн төлөлтийг харвал хугацаа хэтрэлт нэмэгдсээр байгааг албаныхан хэллээ. Хугацаа хэтэрсэн зээлийн нийт ипотекийн зээлийн үлдэгдэл эзлэх хувь сүүлийн гурван сар дараалан өсч, 2.5 хувьд хүрчээ.

Автозам



“Аглагийн хийд хүртэлх 6.2 км хатуу хучилттай автозам”-ийн төсөл хэрэгжихээр болжээ. Энэхүү ажилд “Хансуун зам” ХХК концессийн гэрээний дагуу хамтран ажиллахаар болсон байна. Цаашлаад гэрээ байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад даалгажээ. “Аглагийн хийд хүртэлх 6.2 км хатуу хучилттай авто зам төсөл”-ийн барилгын ажлыг концесс эзэмшигч энэ оны арванхоёрдугаар сарын 15-ны дотор багтаан хийж, төсөлд оруулсан хөрөнгө оруулалтаа ирэх оны улсын төсвөөс нөхөж авахаар гэрээний төсөлд тусгажээ.

Худалдаа



“Монгол-Хятадын үйлдвэрлэгч, худалдаалагчдын экспо” үзэсгэлэн яармагийг ирэх сарын 23-27-нд ӨМӨЗО-ны Хөх хотод хамтран зохион байгуулахаар болжээ. Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат есдүгээр сарын 17-нд БНХАУ-ын Худалдааны Дэд сайд Гао Яньтайтай Бээжин хотноо уулзсан.

Талууд үзэсгэлэн яармагт Хятадын

талаас 49 мянган ам метр талбай бүхий 70 сая юанийн санхүүжилт гаргаж, хоёр улсын үйлдвэрлэгч, худалдааны компаниудын арван мянга гаруй төлөөлөгчийг оролцуулахаар төлөвлөж байна. Цаашид үзэсгэлэн яармагийг хоёр жилд нэг удаа ээлжлэн зохион байгуулахаар төлөвлөж байгаа аж. Энэхүү экспог тогтмол зохион байгуулснаар Монгол Улсын үйлдвэрлэгчид бүтээгдэхүүн, үйлчилгээгээ Хятадын зах зээлд гаргах өргөн боломж нээгдэнэ гэж үзжээ.

Төсөв



Монгол Улс “Нээлттэй төсвийн судалгаа”-нд 2006 оноос хамрагдаж ирсэн бөгөөд энэ жил тав дахь удаагаа оролцжээ. Судалгаагаар Засгийн газрын төсвийн ил тод байдал хангалтгүй хэвээр байна гэсэн байна. Тухайлбал, авбал зохих нийт 100 онооноос 2006 онд 18, 2008 онд 36, 2010 онд 60 оноо авч байжээ. Харин 2012 онд 51 оноо авснаар өмнөх удаагийн амжилтаасаа ухарсан бол 2015 онд ахиц гарсангүй 51 оноотой хэвээр байгаа аж.

Судалгааны хүрээнд төсвийн ил тод байдлыг үнэлэхээс гадна төсвийн үйл явц дахь олон нийтийн оролцоо болон төсвийн хяналтын түвшинг мөн тодорхойлдог байна.

Сайжирсан үзүүлэлтүүдээс харахад Засгийн газар 2012 оноос хойш батлагдсан төсвийн иргэдэд зориулсан төсвийг нийтэлсэн, мөн жилийн эцсийн тайлангийн иж бүрэн байдлыг сайжруулсан зэрэг ахиц дэвшил гаргасан аж. Гэвч хагас жилийн тойм боловсруулаагүй, 2014 оны гүйцэтгэх засаглалын төсвийн төслийг бүрэн эхээр нь нийтлээгүй зэрэг ухралт гарсан байна. ■

ДЭЛХИЙД



Австралийн Ерөнхий сайд огцров

2013 оны есдүгээр сард албан үүргээ хүлээн авсан Тони Абботт, Австралийн Либерал намын 54-44 гэсэн харьцаатай саналаар албан тушаалаасаа огцорлоо. Түүний оронд Либерал намын тэргүүн асан, Харилцаа холбооны сайд Малколм Тернбулл Ерөнхий сайдын албан тушаалд томилогдов. Тони Абботтыг сүүлийн жилүүдэд сонгогдсон Ерөнхий сайдуудаас хамгийн консерватив үзэлтэй гэдэг байсан бол Тернбуллыг дундыг баримталсан үзэлтэй гэж дүгнэж байгаа аж. Австралийн Засгийн газар томоохон халаа сэлгээ хийх магадлал өндөр байна. Есдүгээр сарын санал хураалттай ижил санал хураалтыг өнгөрсөн хоёрдугаар сард явуулсан ч Абботт цөөхөн саналын илүүгээр албан тушаалдаа үлдэж байжээ. Уг санал хураалтаас хойшхи зургаан сарын хугацаанд Ерөнхий сайд асан Засгийн газрынхаа нэр төрийг сэргээх зорилт тавьж байсан ч дээрх хугацаанд нөхцөл байдал сайжраагүй гэсэн дүгнэлтийг санал асуулгаар харуулжээ. Хэдийгээр Тернбуллын хувьд нэр хүнд өндөр байгаа ч түүнийг дэмжигчдийн дийлэнх нь Хөдөлмөрийн намыг дэмжигчид аж.


Их Британийн Хөдөлмөрийн намын шинэ тэргүүн



Социалист зүүний үзэлтэн Жереми Корбин Нэгдсэн Вант улсын

Хөдөлмөрийн намын тэргүүнээр сонсогдлоо. Өнгөрсөн тавдугаар сард болсон сонгуулиар Лейборист нам хүнд ялагдал амссанаар намын тэргүүн Эд Миллибанд албан үүргээ хүлээлгэж өгсөн юм. Намын шинэ тэргүүн илүү зүүнийг баримтлагч байх уу эсвэл төвийг баримтлагч байх эсэхэд намынхан хуваагдмал байр суурьтай байсан аж. Корбин 59.5 хувийн саналтайгаар итгэл төгс ялалт байгуулсан бөгөөд түүнийг сонгосон нь сонгогчид өнөөгийн улс төрийн уур амьсгалаас залхсан гэдгийг батлах тусгал болж байна. Тэрбээр 1983 оноос хойш парламентад суусан ч саяхныг хүртэл гол тоглогч биш байв. Корбиний намын удирдлагад хүрсэн замналыг АНУ-ын уламжлалт зарчмыг эсэргүүцэгч, социалист мөн 2016 оны АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Берни Сандерсын замналтай адилтгаж байгаа аж. Сөрөг хүчний шинэ тэргүүний мөрийн хөтөлбөрт хатуу бодлогыг халах, Британийн дайны оролцоог багасгах, хөрөнгтнүүдэд татвар нэмэгдүүлэх, татвараас зайлсхийх асуудлыг цэгцлэх түүнчлэн төмөр зам зэрэг зарим салбарыг буцаан улсын өмч болгох асуудал багтаж байгаа юм. Мөн Их Британийн ЕХ-оос гарах асуудалд Корбин өөрийн байр сууриа ойрын хугацаанд мэдэгдэх таамагтай байгаа аж.

Энэтхэгийн алт



Энэтхэг улс жилд ойролцоогоор нэг мянга гаруй тонн алт импортолдог бөгөөд дэлхийн алтны хамгийн том хэрэглэгч юм. Энэтхэгийн сайд нар Энэтхэгийн алт олборлолтыг эрчимжүүлэх төлөвлөгөөтэй байгаа төдийгүй Карнатака мужийн Колар хотын ойролцоо 3.6 тэрбум ам.доллартай тэнцэхүйц алт олборлох боломжтой гэж үзэж байна. Ирэх саруудад ойролцоогоор 80 гаруй уурхайг дуудлага худалдаанд оруулна

хэмээн тус улсын Уул уурхайн яамны Нарийн бичгийн дарга хэлсэн аж. Энэтхэгийн Засгийн газар хувийн алтны хэрэглээг бууруулах оролдлого хийж байгаа ч тус улсад алтны эрэлт хэрэгцээ өндөр хэвээр байна. Колар хот нь Их Британийн Энэтхэг дахь колончиллын үеэс эхлэлтэй уул уурхайн арвин түүхтэй. Тухайн үед олборлогдсон ихэнх алт Их Британийн нэгдсэн вант улс руу тээвэрлэгддэг байсан бол 1956 онд тусгаар тогтносон Энэтхэг улс уг уурхайг улсын өмчид авчээ. Энэтхэгийн Засгийн газар алтны эрэлт хэрэгцээ өндөр байгаатай холбоотойгоор улсын алтны уурхайнуудыг сэргээж байгаа аж.



АНУ-ын бодлогын хүү өөрчлөгдсөнгүй

АНУ-ын Төвбанкны есдүгээр сарын уулзалтаар Төвбанкны бодлогын хүүгийн хэмжээ тэгээс 0.0025 хувь хэвээр үлдэнэ гэж мэдэгдлээ. Тус улсын Төвбанк хамгийн сүүлд 2006 оны зургаадугаар сард хүүгийн хэмжээгээ нэмж байсан бөгөөд энэ нь дэлхийн эдийн засгийн хямралаас өмнө юм. Олон хүмүүс бараг 10 жилийн турш өөрчлөгдөөгүй хүүгийн хэмжээг есдүгээр сард нэмнэ гэж бодож байсан ч тэг хувьтай хүүгийн хэмжээ дор хаяж дахин нэг сар хэвээр үлдэх нь. Төвбанк өөрсдийн шийдвэрийг олон улсын сул байдалтай холбож тайлбарлаж буй бөгөөд гадаад хөгжлийг ажиглаж байна гэжээ. Энэ нь тэдний инфляцийн болон нийт өсөлтийн талаарх гутранги байдлыг илтгэж байгаа юм. Ингэснээр Холбооны нээлттэй зах зээлийн хорооны 15 гишүүний дөрөв нь хүүгийн өсөлт 2015 онд өөрчлөгдөхгүй гэдэгт итгэлтэй байна гэсэн бөгөөд 2018 он хүртэл АНУ зорилтот хоёр хувийн инфляцийн хэмжээнд хүрэхгүй гэж таамаглаж байна. Хэдийгээр эдийн засагт ахиц гарсан ч үл хөдлөх хөрөнгийн салбар болон цалин хөлсний асуудал зэрэг нь Төвбанкны зөвлөлийг бодлогын хүүг нэмэх талаар эргэлзэхэд хүргэж байна. ■

Алдагдлыг тодотгоно

Г.Орхон

Монгол Улсын төсвийн алдагдал оны эцсээр бараг нэг их наяд төгрөгт хүрнэ гэж Олон улсын валютын сан, Дэлхийн банкны судлаачид таамаглажээ. Энэ оны эхний найман сарын байдлаар төсвийн алдагдал 769 тэрбум төгрөгөөр хэмжигдэв. Өнгөрсөн долдугаар сард 630 гаруй тэрбум төгрөгийн алдагдал хүлээгээд байсан улсын төсөв ганцхан сарын дотор 130 гаруй тэрбум төгрөгөөр нэмэгдээд байгаа нь энэ. Үүнд гадаадын хөрөнгө оруулалт буурсан болон бараа, ажил үйлчилгээний зардал голлон нөлөөлжээ.

УИХ энэ оны төсвийг батлахдаа 400 гаруй тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар баталсан. Тэгэхээр өдгөө алдагдал төлөвлөснөөс 300 гаруй тэрбум төгрөгөөр хэтрээд байна. Эдийн засагчдын зарим нь эрх баригчид төсөв батлахдаа олон нийтэд таалагдах үүднээс үндэслэл, судалгаа багатай


“харалган” төсөв баталдаг гэдэг. Нэг үгээр, заавал дахин тодотгол хийх төсөв баталж ирлээ. Монгол Улсын төсөв 2013, 2014 онд жил дараалан нэг их наяд төгрөгийн алдагдал хүлээсэн. Үүнээс үүдэн төсөвтөө их наядар нь тодотгол хийж байж. Энэ удаа ч мөн ингэх шаардлага үүсээд байна. Энэ оны төсвийг анх батлах үед эдийн засагчдын зүгээс төсвийн орлого 900 орчим сая төгрөгөөр дутаж магадгүйг хэлж байсан. Монгол дээд сургуулийн захирал, эдийн засагч Н.Дашзэвэг “Төсвийн орлого, зарлагыг хэт өндөр тооцсон. Ойролцоогоор 500 тэрбумаас нэг их наяд төгрөгөөр орлого тасалдахаар харагдаж байгаа” хэмээн хэлж.

Товчхондоо, УИХ тодотгол хийх нэрийдлээр нэлээд хариуцлагагүй төсөв баталж ирлээ. Үүнийг эдийн засагчид төсвийн прогнозоо сайн

хийж чадахгүй байгаатай холбон үздэг. Сүүлийн жилүүдэд төсвийн алдагдлыг тодотгол хийгээд засчихдаг гэсэн сэтгэхүйтэй ажиллаа гэж холбогдох байгууллагуынхныг шүүмжлэх хүн олон. Тодотгол хийх нь эдийн засагт буруу зүйл аж. Эдийн засгийн судалгаа, шинжилгээний хүрээлэнгийн захирал, дэд профессор Б.Түвшинтөгс “Төсвийг байнга тодотгоод байвал буруу жишиг тогтоно. Аль болох тодотгол хийхгүй байхаар төсвөө батлах ёстой. Харамсалтай нь, сүүлийн жилүүдэд өндөр хүлээлттэйгээр төсвөө баталдаг болсон. Дараа нь түүндээ хүрэхгүй болоод ирэхээр тодотгол хийдэг зуршил бий болж байна. Монгол Улсын төсөв гурван жил тутам өсөлттэй гардаг. Сүүлийн 10 жилийг эргээд харахад улсын төсөв гурван жил тутам нугарсан байдаг” гэсэн.

Ямартай ч энэ оны төсөвт мөн л

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл /Жил бүрийн эхний 8 сарын байдлаар/ тэрбум.төг



тодотгол хийх нь тодорхой болоод байна. Гэвч он дуустал төсвийн орлого нэмэгдэж шалихгүй учир орлогодоо тааруулж зардлаа бууруулах шаардлага зүй ёсоор тулгарсныг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогт онцолсон. Тэрбээр “Өнөөдрийн тасалдал хоёр гаруй хувьтай тэнцэж байгаа бөгөөд энэ байдлаараа явбал оны эцэст гурван хувь хүрнэ гэсэн тооцоолол байна. Тиймээс төсөвт тодотгол хийхээр бэлдэж байна. Удахгүй Засгийн газарт танилцуулна” гэв. Төсвийн тухай хуульд зааснаар төсвийн алдагдал гурван хувиас хэтэрвэл тодотгол хийх нөхцөл бүрдсэн гэж үздэг.

Сангийн яамны зүгээс эхний ээлжинд хэрэгжүүлж эхлээгүй төсөл, арга хэмжээ хийгээд энэ ондоо дуусах боломжгүй ажлуудын санхүүжилтийг зогсоох арга хэмжээ авах гэнэ. Үүний дараа шаардлагагүй зардлыг хасна. Тухайлбал,

гадаад, дотоод томилолт, бичиг хэрэг, байр зэрэг хасч болох зардлыг танахаар бэлдэж байгаа аж. Харин экспортын гол түүхий эд болох зэсийн үнэ төсөвт тооцоолсноос нэлээд унаж байгаа. Энэ орлогыг ямар байдлаар нөхөх тухайд Х.Ганцогт орлогыг шууд нөхөх боломжгүйг дуулгасан. Сангийн яамны зүгээс нэгэнт орлого орж ирэхгүй байгаа учир түүндээ тааруулж бүсээ чангалах арга хэмжээ авах гэж байна.

Яамныхан эртнээс төсвийн алдагдал нэмэгдэх хандлагатай, орлого бүрэлдэхгүй байгааг дуулгаж байсан. Засгийн газрын зүгээс өнгөрсөн хугацаанд зардлыг танах арга хэмжээ авч байна гэсэн ч бодит байдал дээр хангалттай танаж чадсангүй. Үүнийг өнөөгийн тодотгол хийхэд хүрээд буй төсвийн алдагдал харуулж байна. Он дуустал гуравхан сарын хугацаа үлдсэн бөгөөд эл хугацаанд зардлаа хангалттай хэмжээгээр бууруулж чадахгүй, мөн

орлогоо огцом нэмэгдүүлж чадахгүй нь ойлгомжтой. Харин энэ хугацаанд орж ирэх гаднын санхүүжилт, зээл тусламжын тухайд зөвхөн Азийн хөгжлийн банкнаас хэдэн төгрөг орж ирэх сурагтай. Тус банкнаас эдийн засгийн хүндрэлтэй холбоотойгоор 150 сая ам.долларын санхүүжилт олгох хэлэлцээр хийгдэж байгаа. Үүнээс өөр нэн яаралтай орж ирэх эх үүсвэр байхгүйг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга хэлсэн.

Урд хормойгоороо хойд хормойгоо нөхнө гэгчээр УИХ баталсан төсвөө эргэн тодотгодог, ингэх байдалд хүрдэг, ийм л тогтолцоо сүүлийн хэдэн жилд бий боллоо. Энэ жил дахин алдагдлыг тодотгох нь. Ирэх жилийн төсвийг сарын дараа буюу арваннэгдүгээр сарын 15 гэхэд баталсан байх ёстой. Гэхдээ хуульд заасан эцсийн хугацаа эл өдөр болохоос тус хугацаанаас өмнө улсын төсөв баталж болохгүй гэсэн үг биш аж. ■

ӨРХИЙН ТӨСӨВ

Хуримтлал үгүй өрхийн төсөв

Г.Баатар

“Өрхийн төсөв” буланг уншигч танд хүргэж байна. Иргэн Д.Эрдэнэ болон Х.Энхтүвшин нарын гэр бүлийн төсөв сардаа хэчнээн төгрөг байдаг хийгээд төсвийн “жинлүүр” дээрх зарлага, орлогын тухайн аль нь илүү хүнд буйг харуулахыг зорилгоо.

Өрөөс зугтдаг "Сангийн сайд"



БЗД-ийн VI хорооны /226 байрны 9 тоот/ иргэн Д.Эрдэнэгийнх ам бүл дөрвүүлээ. Эрдэнэ өөрөө 80 нас золгож яваа бөгөөд түүний хань 75 настай Г.Налай эдний гэр бүлийн "Сангийн сайд". Энэ хоёр бүүрай ач, зээ хоёртойгоо амьдардаг. Ач хүү нь "Талх чихэр" ХХК-д ажилладаг бол зээ хүү нь оюутан. Эрдэнэ, Налай гуай хоёр сардаа нийлээд 780 мянган төгрөгийн тэтгэвэр авдаг. Үүн дээр нэмээд эдний өрхийн төсөвт сар бүр зургаан хүүхдээс нь 500 мянган төгрөгийн "хөрөнгө оруулалт" орж ирдэг. Ийнхүү "Сангийн сайд"-ын гарт нийт нэг сая 280 мянган мянган төгрөг очдог аж. Үүнийг сарын хэрэглэндээ хэрхэн зарцуулж хүргэх нь Налай эмээгийн үүрэг бас эрх. Ач хүү нь ажилд ороод удаагүй байгаа тул цалин гэж шалихгүй. "Энэ хоёр өөрөө өөрийгөө болгосон болоод л явдаг. Би ч энэ хэдээсээ илүүчилж чадахгүй юм

даа" хэмээн Налай гуай ярилаа.

Эдний байрны мөнгө нь СӨХ, интернэттэйгээ нийлээд сардаа 130 гаруй мянган төгрөг болдог аж. Хоол унданд сардаа нэг сая төгрөг зарцуулдаг бөгөөд махаа сардаа хоёр удаа бөөнөөр нь худалдаж авдаг. Энэ дөрөв сард нийт 100 гаруй мянган төгрөгийн мах иддэг гэлээ. Хүнсний болон ахуйн хэрэглэний бусад зүйлээ цувуулж авдаг аж. Налай гуай "Байрны мөнгө нэмэгдээд байх юм. Өө эм тарианы мөнгөө мартчихаж. Одоо тэрийгээ тооцдоггүй ч юм даа. Энэ муу бие жаахан өвчин ээрэхээр өнөөх хэдэн хүүхэд маань тал талаас тав, арван төгрөг илүүчилдэг юм. Тэрнээс илүү яах вэ дээ. Бас л тусдаа амьдрал авч яваа улсууд" хэмээв. Хоёр хөгшин эм тариандаа сар бүр 60 орчим мянган төгрөг зарцуулдаг. Эмээ ходоодны, өвөө даралтны эм байнга уудаг. Дээрээс нь

өвчин намдаах эм гээд худалдаж авах шаардлагатай нь өнөөх төсвөөс нь давчихдаг болохоор нэн шаардлагатай хэдийгээ л авдаг аж. Мөн хоёулаа гар утас хэрэглэдэг тул сардаа 50 орчим мянган төгрөгийг нэгжид зарцуулдаг. Ингээд бодохоор хөдөөний хөгшчүүлтэй харьцуулахад энэ хоёрын зарлага овоо байгаа биз.

За тэгээд нүүр гарын саван, угаалгын нунтаг тэргүүтэй ахуйн хэрэглээний зүйлсэд багагүй мөнгө зарцуулдгийг Налай гуай ярьсан. Тэрбээр дөрвөн кг угаалгын нунтгийг 22 мянган төгрөгөөр худалдаж авдаг ч энэ нь сар хүрэхгүй дуусдаг гэлээ. Ахуйн хэрэглээний барааны үнэ ялангуяа, импортын барааны үнэ нэмэгдэж буйг өрхийн эзэгтэй онцолсон. Налай эмээ “Хүмүүсийн хамгийн их хэрэглэдэг элсэн чихэр, будааны үнэ улам л нэмэгдээд байх юм. Одоо ч цагаан будаагүй хоол гэж алга. Юмны үнэ нэмэгдчихээр энэ хэдэн төгрөг чинь тогтохгүй юм байна шүү дээ. Энэ жил ногооны үнэ харьцангуй өндөр байна. Би нэг кг төмс 1500-2000 төгрөгөөр авч байна. Хэдэн төгрөг татууг нь бодоод зах гаръя гэхээр хөл өвдөөд болдоггүй. Гэрийнхээ ойр дэлгүүрээс л ногоо юухнаа цуглуулах юм” хэмээлээ.

Налай гуайг энэ өрхийн чамгүй гамтай “Сангийн сайд” гэдгийг Эрдэнээ өвөө хэлсэн. Өмнө жилүүдэд сардаа 100-200 мянган төгрөг “цааш” хийчихдэг байжээ. Харин өнөөдөр хуримтлал бий болгох нь байтугай өрхийн төсвөө арай гэж хүргэж, сарын хэрэглээгээ дөнгөн данган авч байгаа аж. Настай хүмүүс болохоор хөдөө, гадаанаас хүмүүс гэнэт ирж төлөвлөөгүй зарлага нэлээд гардаг байна.

Энэ үед сайдын тооцоо алдагдаж сарын сүүлээр огт мөнгөгүй болох үе энүүхэнд. Налай эмээ арга мухардахаараа хүүхдүүд рүүгээ утас цохидог аж. Учир нь өр, зээл тавихыг үздэггүй “Сангийн сайд” аж. Тэрбээр “Тэтгэврийн бид чинь зээл авахаар эргэж төлөх гэж бөөн юм болно. Өртэй үхвэл хүүхдүүдэд хэцүү юм болно” гэх. Хүний амьдрал эрээнтэй бараантай гэдэгчлэн зарим өрхийг бодвол эднийх боломжийн орлоготой ч зарлага нь түүндээ таарчихдаг. Хамгийн өндөр зардал нь мах болон байрны мөнгө.

Түмний зээрдийг тордон байж төсвөө бүрдүүлдэг “Сайд”



Өрхийн санхүүг ихэвчлэн гэрийн эзэгтэй нар барьдаг. Харин СХД-ийн 28-р хорооны иргэн Х.Энхтүвшин өрхийнхөө төсвийг бүрдүүлж бас захиран, зарцуулдаг гэрийн эзэн. Эднийх ам бүл тавуул. Эхнэр нь гурван настай хүүхдээ харж гэртээ суудаг. Хоёр хүү нь дунд сургуулийн жилийн сурагч. Өдгөө 37 нас хүрч яваа Энхтүвшин өөрөө гутал засварын жижиг газар ажиллуулдаг бөгөөд сард 500-700 мянган төгрөг олдог.

Тэрбээр өдөржин түмний зээрдийг арчиж, тордон байж 20-30 мянган төгрөг олно. Түүнийг ар гэрт нь дөрвөн ам хүлээж буй тул олсон орлогоороо өрхийн хэрэглээгээ дөнгөн данган хүргэнэ. Тэрбээр өдрийн орлогынхоо 30 хувиар нь материалаа худалдаж авна. Цэвэр орлого нь 10 гаруй мянган төгрөг болно. Энхтүвшингийн хувьд хамгийн том зарлага ажлын байрны түрээс. Хааш хаашаа найман ам метр хүрэхтэй үгүйтэй байраа сарын 80 мянган төгрөгөөр түрээсэлж, амьдралаа зогоож явна. Халаалт байхгүй тул өвөлдөө цахилгаан халаагуур залгаж суудаг.

Сарын төсвөө голдуу хоол хүнс, тог цахилгаан, хүүхдүүдийнхээ хичээлийн хэрэгсэлд зарцуулдаг. Гэр хороололд амьдардаг тул цахилгааны мөнгө сардаа 10-20 мянган төгрөг болно. Гурилаа ихэвчлэн 25 кг-аар нь худалдаж авдаг

ч бусад хүнсээ цувуулж авна. Энэ нь тухайн өдрийн орлогоороо авна гэсэн үг. Учир нь нэг доор бөөн орлого орж ирэх нь тун ховор. Гурван хүүхдийн мөнгө гэж улсаас сардаа 60 мянган төгрөгийн тэтгэмж авдаг нь эдний өрхийн амьдралд их дэм болдгийг Энхтүвшин ярилаа. Хоёр хүүгийнх нь сургууль гэрээсээ холгүй тул хичээлдээ алхаад явчихна.

Автобус унааны мөнгө гэж Энхтүвшин л хэрэглэнэ үү гэхээс энэ тал дээр зарлага гаргах өөр хүн эднийд алга аж. Түүний эхнэр хүүхэд төрүүлэхээсээ өмнө цайны газарт угаагч, үйлчлэгч гээд олдсон ажлыг голохгүй хийдэг байж. Энэ нь өрхийн төсөвт багагүй дэм болдог байсан нь тодорхой. Харин одоо Энхтүвшин ганцаараа зүтгэж явна. Эднийх голдуу гурилтай, ногоотой шөл зэрэг монгол хоолоо иднэ. Тэрбээр “Хөдөлмөрлөж байгаа болохоор ямар ч байсан хүүхдүүддээ ногоо идүүлчихээд байгаа юм. Юмны үнэ их өсч байна. Ингэхээр иргэд бид хэрэглээгээ танаж, хумьчихаад байна шүү дээ. Үнийн удирдлага гэж алга” гэлээ. Өнөөдөр түүний санааг зовоож буй хамгийн том асуудал түлээ, нүүрсээ бэлтгэх. Хахир өвөл хаяанд ирлээ.

Энэ хоёр өрхийн төсвийн жинлүүр дээрх зарлага, орлогоосоо давна уу гэхээс орлого нь дийлэх нь үлгэр болж. Хуримтлал гэж алга. Налай эмээ зээл авах тухай боддоггүй нь нэг талаар сайн. Нөгөө талаас, түүний зургаан хүүхэд өөрсдийн амьдралынхаа хажуугаар хоёр хөгшин рүү өнгийх үедээ өнгийж явна. Гэвч халаас нь хоосорсон үед гар сарвайх хүнгүй нэгэн нь банк, санхүүгийн байгууллагаас зээл авч байна. Улсын эдийн засгийн байдал хүндэрч буйг илтгэн банкны зээлийн 100 төгрөг тутмын 14 хувь нь чанаргүй, хугацаа хэтэрсэн учраас чанаргүй зээл 865 тэрбум төгрөгт хүрснийг Үндэсний статистикийн хорооны наймдугаар сарын тайланд бичжээ.

Энхтүвшингийн хувьд олсноосоо бага зарлага гаргахыг эрмэлздэг нэгэн. Гэвч өнөөдөр эхнэр, хүүхдээ өлсгөхгүйн тулд олсноо зараад л таарч байна. Хоёр өрхийн “Сангийн сайд” нарын адил бусад өрх бүсээ чангалах бодлого барьж байгаа нь тодорхой. Гэвч чангалсан ч чангаагаад байхад тэд хэрхэх билээ. ■

Мангас, баатар, гүнж гурав

Э.Зоригт

Дуудах нэр нь төр, дуурсах алдар нь популизм хэмээх аймшигт хар мангас Монгол хэмээх улсын уул уурхай гэгч нэгэн хот айлыг түйвээж голомтыг нь самраад өөрийн гэсэн хаант засаглалыг тогтоожээ. Мангасын эрхшээлд орсон иргэд нь зовохын дээдээр зовж, жаргал гээчийг умартсан аж. Тиймээс зовлонг гэтэлгэхийн тулд хот айлынхандаа ухаантай гэгддэг хэдэн нөхөд олны нүд, чихнээс далдуур нууцхан хуралдахаар болжээ. Тэд хурлынхаа нэрийг сайн цагийн эхэнд ч, муу цагийн эцэст ч олонтаа болж байсан “Discover Mongolia” хэмээн нэрийдээд, уриа, лоозонгоо “Популизмгүй уул уурхай” гээд мангасыг дарах арга ухааныг сэмхэн хэлэлцжээ.

Мангас дээр нэмэх нь өөр мангас

Уул уурхайнхан жаргал үзэхээ байсан нь ганцхан популизм гэх мангасаас болсон биш юм байж. Эдийн засгийн байдал зөвхөн энд төдийгүй даян дэлхийд сайнгүй байгаа аж. Ойрын хугацаанд сайжрах төлөв ч харагдахгүй байгаа гэнэ. Монгол Улсын уул уурхайн бараг бүхий л бүтээгдэхүүн Хятадын худалдан авалтаас шууд хамаардаг. Гэтэл тус улсын эдийн засгийн өсөлтийн удаашрал Монголын экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох нүүрс, зэсийн үнийг зургаан

жилийн өмнөхөөс бага түвшинд хүргээд байгаа нь мангас дээр нэмэх нь мангас болжээ. Үүнийг тоогоор батал гэвэл Зүүн Азийн хөгжиж байгаа орнуудын эдийн засаг өнгөрсөн онд 6.9 хувийн өсөлттэй байсан бол энэ болон ирэх жил бага зэрэг саарч 6.7 хувьтай байх төлөвтэй. Хятадын хувьд өнгөрсөн оны 7.4 хувийн өсөлттэй нь харьцуулахад ирэх хоёр жилд долоон хувь болохоор байгааг Дэлхийн банкны “Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн байдал” судалгаанд дурьджээ. Хөгжиж буй Азийн эдийн засгийн өсөлт хэдхэн пунктээр буурч буй боловч энэ сааралттай холбоотой буурсаар байгаа эрдэс түүхий эдийн үнээс хамааралтай Монгол зэрэг хэдэн жижиг орны хувьд өсөлтийн хувь бүр ч доогуур байхаар байгаа аж.

Цагаан морьтой ханхүү юу эсвэл нойрсож буй гүнж үү

Мангас байгаа юм чинь түүнийг дарах баатар байж л таарна. Гэхдээ хэн гэдэг нь үл мэдэгдэнэ. Зарим нь гадаадын хөрөнгө оруулагч хэмээх цагаан морьтой баатар ханхүүг хүлээгээд байх шиг. Гэтэл тэр нь цагаан морьтой ханхүү юу эсвэл нойрсон буй гүнж үү гэдэг нь тун эргэлзээтэй. Гэхдээ л мангасыг дарах баатар бидэнд яах аргагүй хэрэгтэй нь үнэн.



2009 оноос хойш ойролцоогоор хоёр их наяд ам.долларын хөрөнгө оруулалт “emerging market” гэгддэг хөгжиж буй орнуудад хийгдсэн ч ганцхан жилийн дотор үүний 50 хувь нь буцан гарчээ. Энэ нь хөрөнгө оруулагчид хямралын үед өндөр өгөөжтэй, эрсдэлтэй зах зээлээс татгалзаж, бага өгөөжтэй ч эрсдэлгүй зах зээлийг сонгох болсонтой холбоотой хэмээн “Хан инвестмент менежмент” компанийн Монгол дахь захирал С.Нарантөгөлдөр хэлсэн. Харин Монголын хувьд арай доогуур зэрэглэлийн буюу “Frontier market” гэж үнэлэгддэг байна. Тэрбээр “Монгол дахь төслүүдэд гадаадын хөрөнгө оруулагч татахад тулгарч буй хүндрэлүүд” сэдвээр илтгэл тавьсан юм.

Түүний илтгэлдээ дурьдсанаар макро эдийн засгийн дээрх хүчин зүйлээс гадна хөрөнгө оруулагчдыг үргээдэг гол шалтгаан нь улс төр, хууль эрх зүйн тогтворгүй орчин болон цаашид тогтвортой байна гэсэн баталгаа үгүй явдал аж. Тухайлбал, 2013 онд баталсан “Хөрөнгө оруулалтын тухай хууль”-ийг сурталчлахдаа уг хуульд өөрчлөлт оруулахын тулд УИХ-ын гуравны хоёрын дэмжлэгийг авах зохицуулалттай хэмээн тогтвортой байдлын баталгаа өгч байсан ч уг заалтыг Үндсэн хуультай зөрчилдсөн гэх шалтгаанаар хассан нь дээрх хичээл зүтгэлийг үнэгүйдүүлжээ. Түүнчлэн гадаадын хөрөнгө оруулагчид тодорхой асуудлын улмаас хил давах эрхгүй болж хөл хоригддог асуудал хөрөнгө оруулагчдыг Монгол руу хандахад бодитой саад болдог хэмээсэн юм. Ингээд харахаар гадаадын хөрөнгө оруулагч нь биднийг аврах баатар гэхээсээ илүү Монголын уул уурхайг эзэгнэсэн популизм хэмээх мангасыг даран сөнөөх баатар эрийг мөн л хүлээж байгаа нойрсож буй гүнж гэлтэй.

Жинхэнэ баатар

Дайны хажуугаар дажин гардаг нь жам. Тэр дажинг эртхэн тооцохгүй бол уул уурхайг зайдагласан нөгөө мангас Монголыг тэр чигээр нь залгих аюултайг хуран цугласан олны дундаас нэгэн мэргэн ард хэллээ. Багш, судлаач гэх

тодотголтой М.Дагва “Эрдэс баялгийн үнийн супер цикл, бизнесийн болон улс төрийн сонгуулийн гэх гурван мөчлөг манайд байна. Тэр тусмаа сонгуулийн синдром, эрдэс баялгийн үнийн уналт, бизнесийн болзошгүй нөхцөл байдал өөр хоорондоо эвгүй давхцвал тэр үед Монголын ард түмнээс ямар араншин гарахыг төсөөлөхөд бэрх” гэв. Дөрвөн жилдээ улстөрчдийн дунд тохиолддог архаг хууч мэдрэлийн “өвчин” болох сонгуулийн үеэр тэдний хөлд хий орж, ялсныхаа дараа төрийн эрхийг гартаа оруулах гэсэн хэнээрхлийн улмаас эдийн засаг элгээрээ хэвтэх дөхсөн олон жишээ бий. Тухайлбал, алдарт 21 мянган төгрөг, урт нэртэй хууль, гэнэтийн ашгийн татвар гэх мэт. Гэхдээ энэ бол мөчлөгүүд давхцаж болох 20-30 тохиолдлоос ердөө цөөхөн хэд нь аж. М.Дагва “Бусад тохиолдлыг нь хэн ч бодож үзээгүй юм шиг санагдаж байна. Эдийн засгийн эрх чөлөөг боогдуулсан. Баялгаас хангалттай хүртсэнгүй гэдэг популизм их хийж байгаа энэ үед эдгээр мөчлөг өөр хоорондоо таарвал юу болохыг төсөөлөхөд бэрх. Гэтэл манайхан аятайхан болохоор татвараа нэмээд хуулиа чангална. Муудахаар бүх юм аа тавьж туучих гээд татвараа хасаад л, хуулиа өөрчилнө. Ингээд байхаар хэн ч бидэнд итгэхгүй. Дээрээс нь бид маш хурдтай явж байж донсолгоо таарангууд тойрч гарах уран жолоодлого хийдэг. Өндөр хурдтай явж байхдаа жолоогоо огцом эргүүлбэл осол болно шүү дээ. Тиймээс бидэнд уран жолоодлого хэрэггүй. Харин ямар ч үед бат бөх байх хууль эрх зүйн орчин, бусад мөчлөгийг сөрсөн бодлого хэрэгтэй” гэв. Харин тэр бодлогыг гаргадаг Эрдэс баялгийн засаглалын болон судалгааны багийг эртхэн бүрдүүлэх хэрэгтэй. Тэгж чадвал тэд мангасыг дарах арга ухааныг сүвэгчлээд зогсохгүй ирээдүйд сэрэх өөр нэгэн мангасыг унтаан дунд нь нам дарах ухааныг олох жинхэнэ баатар юм. Тэр үед л бидний нөгөө хүсэн хүлээж, ирээч, сэрээч хэмээн өдөр шөнөгүй даллаж буй гаднын хөрөнгө оруулалт гэх гүнж сэрэх нь дамжиггүй ээ. ■

МАКРО

Өнөө ба ирээдүй

Ц.Элбэгсайхан

Макро эдийн засгийн суурь үзүүлэлтүүдэд эерэг өөрчлөлт ажиглагдах боллоо. Өнгөрсөн оны наймдугаар сард 13.7 хувь байсан жилийн инфляци өнгөрсөн наймдугаар сард 6.6 хувь болж буураад байна. Мөнгөний нийлүүлэлт энэ оны наймдугаар сарын эцэст өмнөх сарынхаас 102.4

тэрбум төгрөгөөр буюу 1.04 хувиар өсч, өмнөх оны мөн үеийнхээс 171.6 тэрбум төгрөгөөр буюу 1.7 хувиар буурч 9964.4 тэрбум төгрөгт хүрчээ. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 774.4 тэрбум төгрөг болж өмнөх сараас 15.4 тэрбум төгрөгөөр буюу 2.03 хувиар өссөн байна.

Өнгөрсөн долоодугаар сарын байдлаар гадаад валютын албан нөөц 1.71 тэрбум ам.доллар болж өмнөх сараас 1.28 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 26.52 хувиар тус тус өсчээ. Эдийн засгийн гадаад тэнцвэрийг харуулдаг үндсэн үзүүлэлтүүдийн нэг болох урсгал дансны алдагдлын хэмжээ ДНБ-ий 27



Фотог: Б.Бямба-Очир

хувьд хүрч байсан бол энэ оны эхний хагас жилд 6.4 хувь болж буураад байна. Гадаад худалдаа, төлбөрийн тэнцэл ашигтай гарах болж эдийн засгийн макро орчин дахь “цоорхой” нөхөгдлөө. Хэдийгээр гадаадын хөрөнгө оруулалт дорвитой өсөөгүй ч илүүдэл хэрэглээгээ бууруулсан.

2011 онд 4.6 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт хийгдэхэд импортын хэрэглээ дагаад нэмэгдэж гадаад худалдааны алдагдал бараг тав дахин өссөн байна. Улмаар 2012, 2013 онд энэ тоо долоо болж нэмэгджээ. Гадаадын хөрөнгө оруулалт багассаар байсан ч импортоо бууруулахгүй байсан нь валютын нөөц шавхагдах шалтгаан болж байв. Харин Төвбанк мөнгөний бодлогоо хатууруулсан үеэс импорт багасч гадаад худалдааны алдагдал буурч ирсэн юм.

Тэгвэл төгрөгийн ханшид гарч буй өөрчлөлтийг макроэдийн засгийн суурь үзүүлэлтүүдтэй холбоотой гэхээсээ илүүтэй улирлын чанартай хэлбэлзэл гэж Сангийн дэд сайд С.Пүрэв тайлбарлаж байна. Жил бүрийн найман сард ханш сулрах дарамт ихэсч, эдийн засгийн идэвхжил нэмэгддэг. Валютын эрэлт, нийлүүлэлтийн одоогийн ханшийг харахад эрэлт, нийлүүлэлт зэрэг буурсан байгаа аж.

Валютын ханшид үзүүлж буй эрэлт талын хүчин зүйлсэд гарсан өөрчлөлтийн тухайд импорт 30 орчим хувиар буурсан, төсөв, мөнгөний хумих бодлого болон иргэд, хувийн хэвشلүүд хэрэглээгээ бууруулсан, эдийн засгийн идэвхжил саарсан зэрэг нь ханшийг

тогтворжуулах, валютын эрэлтийг бууруулах нөлөө үзүүлж байна. Түүнчлэн инфляцийн түвшин өндөр байх тусам төгрөгийн худалдан авах чадвар муудаж ханш унаж эхэлдэг. Төсөв, мөнгөний хатуу бодлогоос хамаарч инфляцийн түвшин энэ жил харьцангуй бага байгаа нь валютын эрэлт буурах шалтгааны нэг аж.

Хэдийгээр макроэдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд тогтворжих хандлагатай байгаа ч эдийн засгийн хүндрэл бүрэн арилаагүй, чадавх ерөнхийдөө сул хэвээр байна. Тухайлбал, энэ оны эхний долоо сарын төсвийн гүйцэтгэл төлөвлөсөн хэмжээнээс зөрүүтэй гарсан. Төсвийн алдагдал их байгаа нь урсгал дансыг алдагдалтай гарахад нөлөөлж байгаа бөгөөд ам.долларын эрэлт бий болгож буйг Монголбанкны эдийн засагчид сануулж буй. Ялангуяа төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын төслүүд удааширч, зогсонги байгаа нь үүнд их үүрэг гүйцэтгэж байгаа аж. Нийт хадгаламж наймдугаар сарын байдлаар 7.2 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс 7.03 хувиар өссөн боловч төгрөгийн хадгаламж 5.07 их наяд төгрөг болж өмнөх сараас 1.5, өмнөх оны мөн үеийнхээс 6.8 хувиар тус тус буурчээ.

Иймээс төсвийн орлогын бүрдүүлэлттэй уялдан зарлага, санхүүжилтийг бууруулах, үргүй зардлыг багасгах замаар төсвийн хумих бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээ Засгийн газар мэдэгдээд байгаа. Мөн Засгийн газарт өрийн удирдлагын тухай хуулиар олон улсын зах зээлээс дотоодын банк, санхүүгийн

байгууллагуудтай хамтран нэг тэрбум гаруй ам.долларын хөрөнгө босгох боломж бий. Энэ зорилгоор эхний ээлжинд Азийн хөгжлийн банкнаас 150 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл авахаар төлөвлөж буй.

Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт хагас жилийн байдлаар гурван хувьтай байна. Нэгдүгээр улиралд энэ тоо 4.4 хувь байсан. Азийн хөгжлийн банкны таамаглаж байгаагаар оны төгсгөлд энэ тоо улам буурна. Харин Төвбанкны төсөөллөөр энэ жил эдийн засаг таван хувь орчим өснө гэж хүлээж буй.

Хамгийн чухал нь хэд ч байсан эдийн засгийн өсөлтийг бүрдүүлэх гол салбар нь хөдөө аж ахуй. Гадаад зах зээл дээр уул уурхайн түүхий эдийн ханшийн уналт үргэлжилсээр байгаа нь өнгөрсөн жилүүдэд эдийн засгийн өсөлтийг тэтгэж байсан салбар дорвитой өсөлт үзүүлэх найдлага төрүүлэхгүй байна. Нүүрс 22, төмрийн хүдэр 19 хувиар экспортын хэмжээ буурч, зэсийн баяжмал 10, газрын тос 16, алт 35 хувиар өссөн боловч ам.доллараар илэрхийлсэн нийт экспортын дүн өнгөрсөн оны мөн үеийнхээс 9.1 хувиар буурчээ. Ялангуяа гол худалдан авагч БНХАУ-ын баримталж буй эдийн засгийн бодлогоос хамаараад ойрын хугацаанд түүхий эдийн үнэ өсөх зураглал буухгүй байна.


Дотоод хүчин зүйл талаас эдийн засагт хүчтэй нөлөө үзүүлэх том төслүүд хөдөлгөөнд орохгүй байсаар. Оюутолгойн гүний уурхайн төлөвлөгөөг талууд тохиролцооноос хойш багагүй хугацаа өнгөрсөн ч нааштай өөрчлөлт ажиглагдахгүй байсаар намартай залгалаа. Засгийн газрыг ойрын хугацаанд бондын эргэн төлөлт хийх бас нэг “дарамт” хүлээж буй. Мухардлаас гарах зам нь тодорхой. Хөрөнгө оруулалт татах.

Оюутолгой төслийн хоёр дахь шатны санхүүжилт амжилттай хийгдвэл түүнийг даган хөрөнгө оруулалт өснө гэсэн хүлээлт бий. Гэвч нэгэнт зах зээл нь уналттай байгаа салбарт 2011 оны адил их хэмжээний хөрөнгө оруулалт хийх магадлал хэр өндөр бол гэдгийг салбарынхан олон талт байр сууриас тайлбарлаж байгаа. Иймд бусад салбарын эдийн засагт үүрэлцэх ачааг тэнцүүлэх шаардлага байсаар. ■

Ядуурлын шугамтай ойролцоо хэрэглээтэй нэг хүний сарын хүнсний хэрэглээ




Нэг хүнд сард ноогдох хэрэглээний бүтэц




Хүнс	104624	52778	<i>/Төгрөг/</i>
Хувцас	16125	4110	
Бусад	16607	2231	
Тээвэр холбоо	10868	6973	
Халаалт	52092	18019	
Боловсрол	40058	9089	
Эрүүл Мэнд	70918	17815	
Нийт	311291	111015	

Нэг хүнд сард ноогдох хэрэглээний бүтэц
өрхийн тооны тэнцүү 10 бүлгээр 2014 он


Хамгийн бага хэрэглээтэй бүлэг



Дундаж бүлэг



Хамгийн чинээлэг бүлэг



ЯДУУРЛЫН ХАМРАЛТЫН ХҮРЭЭ, хувиар, 2014 он




21.6

100 хүн тутмын 22 нь зайлшгүй шаардлагатай хүнсний болон хүнсний бус хэрэгцээг хангах чадваргүй байна.

Ядуурлын хамралтын хүрээ нь наад захын хэрэгцээг хангах хэрэглээний доод хэмжээг илэрхийлэх хэмжигдэхүүн болох ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн амын эзлэх хувийг харуулна.

- Баруун 26.0
- Хангай 25.3
- Төв 22.2
- Зүүн 31.4
- Улаанбаатар 16.4



ЯДУУРЛЫН ШУГАМ, 2010-2014 он


	Төг			
Ядуурлын шугам	2010	2011	2012	2014
Ядуурлын шугам	92 072	99 729	118 490	146 650

Ядуурлын шугам = 1 хүн хоногт 2100 ккалори хүнсний бүтээгдэхүүн хэрэглэх зардал + Хүнсний бус дундаж хэрэглээ



Ядуу бус

Ядуурлын шугам 146 650Т



ЯДУУРЛЫН ГҮНЗГИЙРЭЛТ, хувиар, 2014 он

Ядуурлын гүнзгийрэлт нь ядуучуудын хэрэглээ ядуурлын шугамаас хэр зэрэг доогуур байгааг харуулна.

Улсын дундаж	5.2
Хот	4.9
Хөдөө	5.8
Бүс	
Баруун	5.3
Хангай	5.4
Төв	5.5
Зүүн	8.6
Улаанбаатар	4.5

Ядуу хүн амын хэрэглээний дундаж түвшин 2014 онд улсын дунджаар ядуурлын шугамаас 5.2 хувь буюу 7690 төгрөгөөр доогуур байна.

Хүн амын амьжиргааны доод түвшин, бүс нутгаар

Бүс нутгаар	Хамрагдах аймаг	Амьжиргааны доод түвшин
Баруун Бүс	Баян-Өлгий Говь-Алтай Завхан Ховд	164200
Хангайн Бүс	Архангай Баянхонгор Булган Өвөрхангай Хөвсгөл Орхон	167200
Төвийн Бүс	Говьсүмбэр Дундговь Дорноговь Өмнөговь Дархан-Уул Сэлэнгэ	164300
Зүүн Бүс	Дорнод Сүхбаатар Хэнтий	160800
Улаанбаатар	Улаанбаатар	185400

АСЕМ-ЫН арга хэмжээг дээд зэргээр “ашиглах” ёстой

Г.Түшээ

Монгол Улс ирэх онд Ази, Европын дээд хэмжээний уулзалтыг /АСЕМ/ эх орондоо зохион байгуулна. 2016 он АСЕМ-ын гишүүн орнуудын хувьд чухал жил. Учир нь тус байгууллагын 20 жилийн ой ирэх жил тохиох төдийгүй зохион байгуулагч орны үүрэг өндөрсөж буйг албаныхан онцолж буй. Уг уулзалтын бэлтгэл ажлыг хэрхэн базааж буй талаар АСЕМ-ын бэлтгэл ажлын албаны ахлах албан тушаалтан, Швейцарь улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Л.Оргилтой ярилцлаа.

-АСЕМ-ын уулзалтыг зохион байгуулах ажлын бэлтгэл хэр явж байна вэ. Өнгөрсөн есдүгээр сард ажлын хэсгийнхэн хэд хэдэн удаа шуурхай хуралдлаа. Гарсан гол шийдвэрүүд юу байв?

-Ерөнхийлөгчийн зарлигаар АСЕМ-ын уулзалтын бэлтгэл ажлыг хангах, чиг үүргээр удирдан зохион байгуулах Үндэсний зөвлөл байгуулагдсан. Тус зөвлөлд төрийн яам, агентлагуудын удирдлага болон бэлтгэлд түлхүү үүрэгтэй оролцож буй Зочид буудлуудын холбоо тэргүүтэй хэд хэдэн байгууллагаас төлөөллүүд орж байгаа. Зургаан ажлын хэсэг тогтмол хуралдаж чиглэл чиглэлийнхээ асуудлыг ярилцан шаардлагатай зүйлсээ Үндэсний зөвлөлдөө оруулан шийдвэр гаргуулах зарчмаар ажиллаж байна. Тухайлбал, өдгөө сонгоод буй 40 гаруй зочид буудлыг засч сайжруулах, тэдгээрт ажиллаж буй хүмүүсийг олон улсын сургалтад хамруулах ажлыг хийж байгаа. Бэлтгэл ажилд 150 орчим тэрбум төгрөг шаардлагатай гэх тооцоог гаргасан бөгөөд үүнийг

Засгийн газраар оруулсан. Одоо шийдэх шатандаа явж байна.

Үүнээс гадна олон сэтгүүлч ирэх төлөвтэй байна. Өнгөрсөн онд болсон Миланы хурлаар 800 орчим сэтгүүлч ирнэ гэж тооцоолж байтал 1000 гаруй сэтгүүлч ирсэн. Тэд АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтыг сурвалжлахаар ирнэ. Гэхдээ уг уулзалт Монголд болох тул манай улсын талаарх сурталчилгаа, мэдээллийг дэлхий дахинд давхар хүргэнэ гэсэн үг. Тэгэхээр энэ чиглэлээр хийх ажил нэлээд байна. Эхний ээлжинд бид гадны хэвлэл мэдээллийнхэнд Монголын тухай ойлголт өгөх ёстой. Ер нь олон улсын нэр хүндтэй хэвлэл мэдээллийн байгууллагуудын сэтгүүлчдийг АСЕМ-ын хурлын өмнө Монголд авч ирж бэлтгэл ажил хийгээд эх оронтойгоо танилцуулах зэргээр урьдчилж мэдээлэл өгнө. Энэ нь өмнөх жилүүдийн туршлагаас харахад хурлыг сурвалжлуулахад илүү дөхөм болгож өгдөг.

Мөн АСЕМ-ын вэбсайт ашиглалтад ороод бэлтгэл ажил болон уулзалттай холбоотой мэдээллийг тусгай баг хариуцан англи, монгол хэлээр түгээж байна. Уулзалтын хэвлэл мэдээлэл, сурталчилгааны асуудал хариуцсан ажлын хэсэг өнгөрсөн сарын 10-нд хуралдсан. Бид уг уулзалтын хэвлэл мэдээллийнхний төвийг хоёр газар нэгдсэн журмаар байрлуулаа гэж байгаа. Хурал болох “Шангри Ла” зочид буудал болон 53 орны төрийн тэргүүдийн зангиагүй уулзалт болох “Скай Ресорт”-д хэвлэлийнхэнд тусгай бүс гаргаж өгөхөөр төлөвлөж байна.

Хоттой холбоотой олон асуудал байгаа. Зочид, төлөөлөгчдийн байрлах буудлуудаас хурал болох төв рүү явах зам, зөрлөгийг сайжруулах ажлууд

эхнээсээ хийгдэж байна. Иргэд ажигласан байх. Энхтайвны гүүрний зүүн талд төмөр зам доогуур явах туслах зам барьж байна.

-Өдгөө шаардагдаж буй хөрөнгийг та бүхэн ямар арга, хэлбэрээр санхүүжүүлж байна вэ?

-Зочид буудлуудад олгох мөнгийг Хөгжлийн банкаас санхүүжүүлэх Засгийн газрын тогтоол гарсан. Бусад ажлын зардлыг янз бүрээр шийдэж байна. Мэдээж маш их хэмжээний хөрөнгө шаардагдаж байгаа ч аль болох төсөвт дарамт багатайгаар, төр, хувийн хэвшлийн түншлэл болон бусад орны тусламжийн зарчмаар шийдэхийг эрмэлзэж байна. Жишээ нь, орчуулагчдыг бэлтгэх ажлын зардлыг Европын холбоо зуун хувь өөр дээрээ авч байгаа. АСЕМ-ын уулзалтыг анх удаа зохион байгуулж байгаа орон мэдээж өөрийн боломжоор л зочдоо хүлээн авна. Заавал өндөр тансаг байх албагүй. Гэхдээ зохион байгуулагч орны хувьд зочломтгой, зан заншлаа даган зочдоо аль болох тухтай, тохитой хүлээн авахыг бодно. Хоёр талын шугамаар тусалж дэмжье гэсэн орнууд байна.

-Бэлтгэл ажилд Европын холбооны зүгээс дэмжлэг үзүүлэхээр болсон. Яг ямар хэлбэрээр тусламж үзүүлэх юм бэ?

-1996 онд АСЕМ гэдэг яриа хэлэлцээний энэ тавцанг Европын холбоо анх санаачилсан бөгөөд өдгөө 20 жил болж байна. Тус холбоо нь үүсгэн байгуулагчийн хувьд хуралд идэвхтэй оролцдог. Өнгөрсөн долдугаар сарын эхээр Европын холбооны томоохон бүрэлдэхүүн манай улсад ирээд явлаа. Зохион байгуулалт, хурлаас гарах бичиг баримт, орчуулагч



Фотог: Б.Бямба-Очир

зэрэг хэд хэдэн чиглэлээр ярилцаж, санал бодлоо солилцоод явсан. Уг уулзалтын хүрээнд Европын холбооны зүгээс орчуулагч бэлтгэхэд туслалцаа үзүүлэхээр болсон бөгөөд Англи хэлний синхрон орчуулгын маш өндөр түвшний, мэргэжлийн бэлтгэлд хамруулах зургаан орчуулагчийг сонгож авсан. Тэднийг тун удахгүй дөрвөөс таван сарын хугацаанд түргэвчилсэн шахуу програмаар сургалтад хамруулна. Манайхан зөвхөн зочид буудал, байр тэргүүтэй хэдхэн зүйлийг яриад байна. Үүнээс гадна хурлын агуулга, баримт бичиг их чухал. Бид зохион байгуулагч орны хувьд уг уулзалтын хүрээнд болох хоёр хурлаас гарах баримт бичгийг боловсруулна. Тухайлбал, даргын мэдэгдэл гэдэгт тухайн хурал дээр юу ярьсан, улс орнууд ямар байр суурьтай байв, ямар асуудлыг хэлэлцэж ямар дүгнэлтэд хүрэв гэдгийг хурлын даргын мэдэгдэлд тусгах ёстой. Өмнө жил Миланаас гарсан мэдэгдэл бол 40-өөд зүйл ангитай байсан бөгөөд дэлхийн тулгамдсан гол асуудлуудыг оруулсан. Мөн бид ирэх жил тохиох АСЕМ-ын 20 жилийг тэмдэглэх баяр ёслолын арга хэмжээнүүд, нөгөө талаас агуулгын хувьд бэлтгэл хийнэ.

-АСЕМ-ын уулзалтаар онцлох сэдэв юу байх бол?

-Яг юу ярихаа 53 улсын тэргүүнүүд хамтарч сууж байж шийднэ. Ирэх арваннэгдүгээр сард Люксембургт АСЕМ-ын Гадаад хэргийн сайд нарын хурал болно. Энэ хурлаар юу ярилцах талаар тодорхой шийд гарах байх. Анх бол Ази, Европ хоёр тивийн хамтын ажиллагааг улс төр, бизнес, нийгэм соёл гэх гурван баганад тулгуурлан энэ яриа хэлцээрийг албан бусаар хөгжүүлж гэж байсан. АСЕМ бол АПЕК-ийг бодоход их өргөн цар хүрээтэй асуудлыг хөнддөг. Ер нь одоогийн олон улсын харилцааг харахаар албан ёсоор гэрээ хэлэлцээр явдаг байгууллага, талбарууд хангалттай байх шиг байгаа юм.

Дэлхийн худалдааны байгууллага, Олон улсын валютын сан, Дэлхийн банк гэх мэт. Эдгээрийн гэрээ, хэлэлцээрийн талбар их албархуу. Гэтэл нэг талаараа яриа хэлэлцээр хэтэрхий албархуу байхаар асуудал шийдэх нь удаан байдаг аж. Тэгэхээр АСЕМ аль болохоор албан бусаар асуудлыг шийдэх үүднээс бүх талыг оролцуулж,

гарцаа олдог энэ зүг рүү явж байна л даа. АСЕМ нь энэ утгаараа их ач холбогдолтой. Энэ 20 жилийн ойттой холбогдуулж бид өнгөрсөн 20 жилийг дүгнэж, цаашдын АСЕМ-ын яриа хэлэлцээр ямар хэлбэрээр, хэрхэн үргэлжлэхийг тодорхойлно. Улаанбаатарын тунхаглал гэдэг баримт бичгийн төслийг боловсруулах, бүх талын саналыг тусгах ажлыг бид хийх болж байгаа юм. Европын холбоо энэ бичиг баримт боловсруулах ажил дээр санаа оноогоо солилцоод явж байна.

Мөн АСЕМ-ын идэвхтэй гишүүдийн нэг Хятад улс хуралдааны арга барилыг боловсронгуй болгох байр суурь баримталдаг орон. Тэгэхээр хоёр талын чиглэлээр тусламж үзүүлэх саналаа солилцоод явж байна. Жишээ нь, Улаанбаатар хотын зам, гүүр, барилгын ажилд Хятадын компаниуд оролцож байна. Он гараад АСЕМ-тай холбоотой хэд хэдэн уулзалт болно. Эдгээр уулзалтын зохион байгуулалтын ажилд Ази, Европын фонд /ASEF/ гэх байгууллага мэргэжлийн туслалцаа үзүүлэх гэж байгаа.

-АСЕМ дахь Монгол Улсын байр суурийг та хэрхэн харж байна вэ?

-АСЕМ-ын хүрээнд ярьж байгаа гол асуудал АСЕМ-ын ирээдүй, цаашид энэ яриа хэлэлцээний талбар ямар хэлбэрээр яаж явах юм бэ гэсэн том асуудал тулгарч байгаа юм. Тэгэхээр анхны зарчим нь АСЕМ хэлэлцээний байгууллага биш. Энэ бол хамгийн түрүүн Ази, Европын хамтын ажиллагааны асуудлаар бүх салбарын асуудлууд, дэлхийд нүүрлээд буй уур амьсгалын өөрчлөлт, ус, гамшиг зэрэг нь Ази, Европын хамтын ажиллагаанд яаж холбогдох юм, үүнийг ямар өнцгөөс яаж шийдвэрлэх зэрэг асуудалд албан бусаар санал солилцдог талбар. 20 жил санал солилцоод явлаа. Цаашид тодорхой үр дүнгүүд гаргадаг болвол ямар вэ гэх саналыг зарим орны зүгээс дэвшүүлж байна.

Үүнд Монгол Улс энэ байгууллагыг яриа, хэлэлцээр, санал солилцдог талбар гэдгээр нь үргэлжүүлэх нь зүйтэй гэх байр суурьтай байгаа. Гэхдээ ингэж ярилцах явцдаа тодорхой зорилгод хүрэхийг эрмэлзэж байя. Бид бол харьцангуй хойно, 2008 онд элссэн. 20 жилийн хугацаанд Ази, Европын хоорондын харилцаа, эдийн засаг,

худалдаа хамаагүй нэмэгдсэн. Энэ нь үнэндээ АСЕМ-ын ололт. Цаашдын зорилт бол яаж үүнийг үр дүнтэй байлгах вэ. Манай байр суурь ийм л байгаа.

-Тус уулзалтын манай улсад өгөх өгөөжийг та аль өнцгөөс нь харж байна вэ?

-Маш олон өнцгөөс харж байна. Ази тив дэлхийн худалдаа, санхүүгийн бас нэгэн гол төв болчихлоо. Европ зөвхөн Азиас гадна бусад тив, улстай харилцдаг том гүрэн. Жишээ нь, Өмнөд Америк, Африкт ядуурал том асуудал. Европ-Африк, Европ-Латин Америкын хооронд ядуурлыг гол төлөв ярьдаг. Тэгвэл Азид ядуурал харьцангуй гайгүй. Эдийн засгийн хувьчлалын түвшингээр гайгүй дүнтэй явж байгаа. Тэгэхээр энд хөгжлийн асуудал голдуу яригддаг. Монгол Ази, Европын дээд хэмжээний уулзалтыг зохион байгуулна гэдэг бол энэ хоёр том тивийн харилцаанд оруулж байгаа манай хамгийн тодорхой хувь нэмэр. Түүхээсээ авч үзэхэд Монгол хоёр тивийн бодит гүүр байсан орон. Одоогийн нөхцөлд төмөр зам, агаарын замаар дээрх тивийн гүүр нь болж байна. Бодитоос гадна, түүхийн, оюун санааны, эдийн засгийн хатуу холбоос нь мөн.

Энэ удаагийн уулзалт цаашид холбоог сайжруулахад чухал төдийгүй өнөөгийн бодит холбоосууд болох төмөр зам, агаарын зам зэргийг хоёр тивийн эдийн засаг, бизнесийнхэнд илүү мэдрүүлж өгөх, бололцоогоо нээж өгөх талаасаа ач холбогдолтой. Дэлхийн 53 орны тэргүүнүүдийг Монголд анх удаа авч ирэх гэж байна.

Энэ нь Монголын тухай давхар сурталчилгаа болж байгаа юм. Монголыг дэлхийн тавцанд дахин нэг өнцгөөс таниулах боломж бидэнд ирлээ. Дэлхий өнөөдөр биднийг уул уурхай, Чингис хаан, түүх гэдгээр харж, таньж байна.

Одоо бол дэлхийн өөр хөгжил гэдэг өнцгөөс харуулах боломж байна. Дэлхийн хөгжилд өөрийн үүрэгтэй, хувь нэмрээ оруулж яваа улс орон гэдгээ харуулах боломж. Бид өөрсдийгөө ингэж харуулахад АСЕМ-ын арга хэмжээг дээд зэргээр "ашиглах" ёстой. Боломжийг сайн ашиглаж чадвал аялал жуулчлалыг хөгжүүлэх том боломж гэж харж байна. ■

Монгол Улс өнөөдрийн байдлаар 21 орчим тэрбум ам.долларын өртэй байна. Бүрэн бус тооцоогоор шүү. Энэ жилээс өрөө төлж эхлэх учиртай. Өр төлөх хуваариар бол энэ жилийг оролцуулаад ирэх гурван жилд таван 5,5 тэрбум орчим ам.долларын зээл төлөхөөр байна.

Харин засагт өрийг яаж ямар эх үүсвэрээс хэрхэн төлөх талаарх ямар ч бодлого, шийдвэр алга гэж эдийн засагч, судлаачид үзэж байна. Өрийн судалгаагаар дагнаж, судалж, тодорхой асуудлууд дэвшүүлээд байгаа эдийн засагч, судлаачдын нийтлэлээр энэхүү дугаарынхаа онцлох сэдвийг хөндөж байна. Тэд Монгол Улсын өрийн хэмжээг тодорхой болгож, өр зээлийг хэрхэн төлөх талаар олон нийтэд үнэн зөвөөр тайлагнахыг шаардаж байгаа юм.

Манай өр олон улсын байгууллагуудын анхаарлын төвд

орж, өрийн хямралд орж болзошгүй орнуудыг хэдийнэ тэргүүлээд эхэлсэн билээ. Дэлхий Монголын Засгийн газрыг өр зээлээ хэрхэн зохицуулахыг харж, холбогдох байгууллагууд анхааруулга, сануулга өгөөд байгаа бол манай төр өрд огтхон ч санаа зовсон шинжгүй сандал ширээгээ, албан тушаалын хэрүүлээ хийгээд сууж байна. Юун өр гэсэн шинжтэйгээр Ерөнхий сайд Ч.Сайханбилэг төрийн албан хаагчдын цалин хөлсийг л тавихад анхаарч бусад зардлыг, төслийг царцаах, хумих үүрэг даалгаврыг Сангийн сайддаа өглөө. Өр зээлийн эргэн төлөлтийн хугацаа дэргэд тулаад ирлээ. Энэ жил 960-аад сая ам.доллар төлөх ёстой. Энэ мөнгө засагт байгаа юу. Энэмэтчилэн өрийн харанга дэлдээд эхэлсэн цаг дор манай сэтгүүл өрийн асуудлыг дахин хөндөж тавьж байна.



ӨР

Алт дилерийн хэрэг-2 буюу их өр-2

Г.Занданшатар /Судлаач/

УИХ-ын гишүүн, Гадаад харилцааны сайд асан Г.Занданшатар дэлхийд алдартай Стэнфордын сургуульд олон улсын харилцаа, улс төрийн шинжлэх ухааны зочин судлаачаар хоёр жил шахам хугацаанд ажилласан. Түүний үндсэн мэргэжил эдийн засагч. Тэрбээр Их, дээд сургуульд багш, ХААН банк, Монголбанкинд ажиллаж байсан банк, санхүү, эдийн засгийн салбарын түршлагатай мэргэжилтэн. Г.Занданшатар эх орондоо ирснээс хойш улс төр, эдийн засгийн тулгамдсан асуудлуудаар нэлээд ул суурьтай судалсан, баримт бүхий нийтлэлүүдийг бичээд байгаа билээ. Тэрбээр манай сэтгүүлд энэ дугаараас эхлэн өөрийн буланг хөтлөн явуулах гэж байна. Ингээд энэ удаа түүний Монгол Улсын өрийн асуудлаарх нийтлэлийг нь толилуулж байна.

"Монголын Улсын өр ДНБ-ий 180 хувьд хүрлээ"

Алт дилерийн хэрэг -1

Монгол Улсын Төв банк 100 сая ам.долларын алдагдлыг банк хоорондын арбитражийн гүйлгээ буюу дилерийн арилжааны үр дүнд хүлээж байсан нь одоогоос 24 жилийн өмнө буюу тэртээ 1991 он. Ардчилалтай нас чацуу. Тэрхүү алдагдлын төлбөрт улсын нөөцийн 4.4 тонн алтаар төлбөр хийсэн болохоор түүхэнд алт дилерийн хэрэг хэмээгдэн үлдсэн юм. Энэхүү алт дилерийн луйвар тухайн үеийн хар захын ханшаар есөн тэрбум төгрөг болсон байж. Энэ бол Монгол Улсын түүхэн дэх анхны аймшигт том луйвар байлаа. Чухам энэ үеэс Монголд хариуцлагын засаглал хямарч, эдийн засгийн шимэгчид бий болж эхэлсэн юм.

Шинээр их өр үүссэн нь

Олон Улсын Валютын Сангийн өрийн тогтвортой байдлын судалгаанд (<https://www.imf.org/external/pubs/ft/dsa/pdf/2015/dsacr15109.pdf>) Монгол Улс (ликвидность liquidity) гүйлгээний чадваргүй болж болзошгүй улс бөгөөд өрийн талаархи тоо мэдээлэл нь бүрэн бус байна гэжээ. Чингис бонд 1.5 тэрбум ам.доллар, Самурай бонд 30 тэрбум иен, МИАТ-ын онгоц авсан өр гээд өнөөдөр Монгол Улсын нийт өр 21.6 тэрбум ам.долларт хүрчээ. Манай улсын нийт гадаад өр ДНБ-ий 180 хувьд хүрч байна. Засгийн газрын шууд өр 3556 тэрбум ам.доллар, Монголбанкны өглөг 1876 тэрбум ам.доллар, Банк хадгаламжийн байгууллагын өглөг 3352, аж ахуйн нэгж хоорондын зээллэг 10533 тэрбум ам.долларт хүрлээ. Манай улсын гадаад өр анх 2002 онд нэг их наяд төгрөг байсан бол 2014 онд 14 их наяд төгрөгт хүрч, даруй 14 дахин өссөн. Бодит байдал дээр Монгол Улсын өрийн үлдэгдэл өрийн тааз 58.5 хувийг аль хэдийнэ давжээ.

Алт дилерийн хэрэг-2

Энэ их гадаад, дотоод өрийн дунд "Үнэ тогтворжуулах хөтөлбөр" нэрээр цөөхөн компаниудад тараасан дөрвөн их наяд орчим төгрөг, 888 төсөл нэрээр өгсөн зээлийн өр яваа. Энэ бүхнийг л шинэ үеийн "Алт дилерийн хэрэг-2" гэж нэрлэхэд хүрч байна. Хамгийн гайхалтай нь, Улсын төсөв, Хөгжлийн банкны зээл, Монголбанкны зээл гэсэн хөрөнгө оруулалтын гурван төсөвтэй болчихоод байна. Энэ их мөнгийг Засгийн газрын төсөв тайланд оруулахгүй, тусад нь нууцлаад байгаагийн шалтгаан, шаардлага юу вэ?

Монгол Улсын энэ их өр зээл, их хэмжээний зарлага, зарцуулалтыг бодит эдийн засагт эргэж өгөөжөө өгөх төслүүд рүү хийсэн бол манай эдийн засаг өнөөдрийнх шиг хямрахгүй. Экспортыг дэмжиж, импортыг орлох төслүүдэд зарцуулсан бол төгрөгийн ханш доройтож, ам.доллар 2000 төгрөгт хүрэхгүй байсан. Өнөө жил Монгол Улс 996 сая ам.долларын гадаад өр төлөх үүрэгтэй бол 2016, 2017 онд нийт дөрвөн тэрбум гаруй ам.доллар төлөх ёстой. Тэртээх 24 жилийн өмнөх алт дилерийн хэргийн өрийг социализмын үлдэгдэл 4.4 тонн алттай байсан тулдаа төлж. Одоо харин бид юугаараа төлөх вэ? Засгийн үр ашиггүй зарлагаа эрс танаж, татварыг нэмэгдүүлэх, дахиж зээл авах яг ямар бодлого баримталж байна вэ?

Энэ л сүүдэр дагуулсан их өрийн талаар дэлгэрэнгүй тайлбарлахыг Ерөнхий сайд Ч.Сайханбилэг, Монголбанкны Ерөнхийлөгч Н.Золжаргал нараас ард түмэн шаардах эрхтэй. Шаардах түүхэн шаардлага ч байна.

Шилэн дансны хэрэг

Ийм л үед нүүр улайхгүй, айж ичих зүйлгүй байхын төлөө нөгөө алдарт шилэн данс гэгчийг уг нь бүтээсэн шүү дээ. Гэтэл тэр олон Чингис бонд болон бусад их өр хоёрын олон тэрбумын ашиглалт, зарцуулалт шилний цаанаас мэт тунгалаг харагдах нь бүү хэл хөндлөнгийн хяналт, аудит ч одоо хэр нь хийгдсэнгүй. Эсрэгээрээ тодорхой бус тэдгээр зарцуулалттай холбоотой хэргээ Өршөөлийн хуульд хамруулахаар зохион байгуулсан байж болзошгүй гэж эгэл жирийн ард түмэн хардах эрхтэй. Тэрбайтугай, яам тамгын газрууд улс өрөнд ороогүй юм шиг тансаглаж, төсвийн мөнгөөр хэрхэн зугаалж, цацалж байгааг нийгмийн сүлжээгээр "@Цогоо гуай"-н түгээх шилэн дансны аудит илтгэж байна. Олон тэрбум төгрөгийн баримтуудыг твиттерээс олж хараад, хямгадахыг Бид Засгийн газраас шаардах эрхтэй.

Шилэн дансны судалгаагаар 200 орчим тэрбумын сэжигтэй гүйлгээ, төсвийн мөнгийг зориулалтын бусаар зарцуулсан, элдэв тэтгэлэг, урамшуулал нэрийн дор асар их хэмжээний мөнгийг үргүй зарцуулсан ноцтой баримтууд нийгмийн сүлжээнд дэлгэгдсэн бөгөөд цаашид ч энэ төрлийн

баримт сэлтүүд гарч ирсээр байгаа нь олны анхаарлын төвд ороод байна.

Аймаг, нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчдийн урамшууллууд, Засаг дарга нарын наадам, зугаа цэнгээний зардлууд, агентлаг, ТӨҮҮГ-уудын гадаад зугаалгуудад их хэмжээний мөнгийг зарцуулсан байдал нь шууд гэмт хэргийн шинж чанартай байгаа аж. Сайдууд болон яамдуудын гадаад дотоодын зөвлөх үйлчилгээний хөлс хэмээх зардал зарим тохиолдолд нэг тэрбум төгрөг хүрч байгаад иргэдэд хардлага төрүүлж байгаа бөгөөд ач холбогдол нь тодорхойгүй зөвлөгөө судалгаа, сургалтууд, хүлээн авалт, зочны зардал гэх мэт зүйлсийн зардал хэт өндөр байна.

Засгийн газрын өрийн тооцоо судалгаа үнэн бодитой байж чадаж байна уу?

Олон улсын өрийн судалгааны байгууллагын мэдээллээр Монгол Улс дампуурах магадлалтай 14 улсын эхний наймдугаарт жагссан. Авлигаар алдартай Мозамбикийн өмнө шүү. Хариуцлагагүйн зуд, гантай тариалангийн ургац алдалт, засаглалын хямрал, фракцуудын зөрчил, дотоодын зодоон зөрчил гэсэн вируст халдвар биднийг яг хаашаа чирч байна вэ? Мичин жилийн зуд руу юу, өрийн хямрал руу юу? Болзошгүй аюулаас урьдчилан сэргийлж эрсдлийг бодитой тооцож ажиллах бодлого төлөвлөгөө байна уу?

Жинхэнэ бодит байдалд Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 58.5 хувийг давсан байгаа тухай дээр дурдсан. Чухамдаа өрийн таазийг хэтэрч хууль зөрччихсөн. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2015 оны нэгдүгээр сарын 20-нд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь хэмжээг 2015 оны төсвийн жилд 58.3 хувиас, 2016 оны төсвийн жилд 55.0, 2017 оны төсвийн жилд 50.0, 2018 оны төсвийн жилээс эхлэн 40.0 хувиас тус тус хэтрүүлэхгүй байхаар хуульчилсан. Энд гайхшруулж буй тоо нь өнөөгийн үнэ цэнэ гэх засварыг УИХ-ын гишүүн С.Баярцогт Сангийн сайд байхдаа санаачлан оруулсан санагдана. Гэхдээ өрийн таазыг Дэлхийн банкны сэрэмжүүлэх түвшин буюу 40 хувь байхаар хэлэлцэж байсан учир тухайн үед тоогоогүй байх. Өнөөдөр учрыг олж хужрыг тунгаахгүйгээр өрийн асуудлаа бид үнэн зөв шийдэж чадахгүй.


Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагын гүйцэтгэл /2015 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар/ дараах байдалтай байна.

Засгийн газрын өрийн тооцооллийн зөрүү/тэрбум төгрөг/

Үзүүлэлтүүд	2014	2015- 03 сар	2015- 06 сар	2015- 07 сар
Засгийн газрын өр				
Засгийн газрын өрийн үлдэгдэл (нэрлэсэн)	12,629.7	13,006.3	13,682.9	14,055.4
Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл (нэрлэсэн)	9,351.9	9,726.8	9,914.5	
Засгийн газрын дотоод өрийн үлдэгдэл (нэрлэсэн)	3,277.8	3,279.6	3,768.4	3,991.3
Засгийн газрын өрийн үлдэгдэл (ӨҮЦэнээр)	10,535.1	10,594.9	11,322.8	11,549.4
Засгийн газрын өрийн үлдэгдэл (ӨҮЦ) /ДНБ	48.0%	44.2%	47.2%	48.1%
БОДИТ БАЙДАЛ				58.5%
Эдийн засгийн үзүүлэлт				
Дотоодын нийт бүтээгдэхүүн (оны үнээр)	21,937.2	23,988.5	23,988.5	23,988.5


Засгийн газрын өрийг өнөөгийн үнэ цэнээр илэрхийлдэг улс орон бараг байхгүй. Засгийн газрын өрийн үлдэгдэл нь нэрлэсэн дүнгээр 13,006.3 тэрбум төгрөг, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл ДНБ-ий 44.2 хувьтай тэнцэж байгаа ба оны эцэст ДНБ-ий 58.3 хувьтай тэнцэх төлөвтэйг гаргажээ. Энэ бол санаатайгаар будилаантуулж, өрийн үзүүлэлтийг нуун дарагдуулж буй бүртгэл. Дэлхийн банкны улс орнуудын бодлого, институцийн үнэлгээг хэмждэг СРИА системээр өгсөн үнэлгээний дагуу өнөөгийн үнэ цэнээр тооцсон энэ харьцааг 2014 оны эцсийн байдлаар 57 хувь гэж тооцсон. Харин үүнийг Засгийн газар яахаараа 40 хувь гэж тооцсон байна вэ? Ингэж тооцдог аргачлал зохиож, хуулинд нэмэлт өөрчлөлт оруулжээ. Манай улсын гадаад өрийн үзүүлэлтүүд Дэлхийн банкны сэрэмжүүлэх түвшинтэй харьцуулахад 2015 оны эцсийн байдлаар ихээхэн өөрчлөгдөж муудах магадлалтай байдалтай байна.

Монгол Улсын гадаад өрийн эргэн төлөлтийн хуваарь




Засгийн газрын гадаад өр нь 2011 оныг дуустал зөвхөн гадаад зээл гэсэн нэг төрөлтэй байсан бол 2012 оноос Засгийн газрын баталгаа, Засгийн газрын гадаад бонд гэсэн хоёр төрлөөр нэмэгдсэн юм. Өөрөөр хэлбэл, 2012 онд Монгол Улсын Засгийн газар анх удаа гадаад зах зээлд бонд гаргасан бөгөөд мөн гадаад зах зээлд Хөгжлийн банкны гаргасан бондод баталгаа гаргасан. Гадаад өрийн бүтцийг үзвэл 2011 он хүртэл Засгийн газрын гадаад өрийг зуун хувь гадаад зээл эзэлж байсан бол 2012 онд 49 хувийг гадаад зээл, 16 хувийг баталгаа, 35 хувийг гадаад бонд эзэлжээ. Улмаар 2013 онд 50 хувийг гадаад зээл, 16 хувийг баталгаа, 34 хувийг гадаад бонд, 2014 онд 44 хувийг гадаад зээл, 26 хувийг баталгаа 31 хувийг гадаад

Хууль эрхийн засаглал (Rule of law)



бонд тус тус эзэлж байна.

Засаглалын үр ашигтай байдал



Эх сурвалж: Дэлхийн банк


Гадаад өр зээл үр ашиггүй байгаа учир шалтгаан юу вэ?

Монгол Улсын хуулийн засаглалын (хууль дээдлэх ёс) үзүүлэлтийн сүүлийн 17 жилийн динамикийг авч үзвэл 2004 оноос эрс унаж эхэлснийг харж болно.

Харин 2014 оны дөрөвдүгээр сарын 29-нд S&P компани Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг “BB-”-аас “B+” болгон бууруулсан. Гол шалтгаан нь, Засгийн газрын гадаад өрийн хэмжээ нэмэгдсэн явдал гэжээ. Эрхзүй, бодлогын орчин тогтворгүй болж, экспортын хэмжээ буурсан, мөнгөний хэт тэлсэн бодлого хэрэгжүүлж төлбөрийн тэнцлийн дарамтыг нэмэгдүүлсэн, гадаад валютын нөөц багассан зэрэг шалтгаан тоочжээ.


Доорх графикаас нийт өрийн 55 хувь буюу 10,8 тэрбум ам.доллар нь Засгийн газар, Монголбанк, Хөгжлийн банк улсын өр болж тооцогдоно. Манай орны экспортын гол нэрийн бүтээгдэхүүнүүд болох зэс, нүүрсний дэлхийн зах зээл дээрх үнийн прогноз дунд хугацаанд тааруу байгаа байдал, Хятадын эдийн засгийн өсөлтийн сааралт, саяхан Хятадын Засгийн газраас гаргасан уул уурхайн бүтээгдэхүүнүүдэд тавьсан импортын татвар зэрэг хүчин зүйлс нь манай гадаад өрийн төлбөрийн байдалд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж мэдэхээр байна.

Монгол Улсын гадаад өрийн эргэн төлөлтийн бүтэц /2015-2023/



Эх сурвалж: Сангийн яам

Монгол банкны гадаад өрийн эргэн төлөлт (сая ам.доллар)



ДҮГНЭЛТ ШААРДЛАГА

Монгол Улсын Засгийн газрын гадаад өрийн байдал, цаашдын төлвийг судалж үзээд дараах шаардлагыг Засгийн газар, Монголбанкинд хүргүүлэн, албан ёсоор хариу тайлбар өгөхийг шаардаж байна. **Нэгдүгээрт**, Өрийн шилэн данстай больё! Монгол Улсын Засгийн газрын гадаад өрийн талаарх ойлголтыг цэгцэлж, улсын өрийн талаархи үнэн бодит мэдээлэл гаргаж шилэн дансаар Ард түмэнд тайлагнахыг шаардаж байна.

Үүнд,

А. Засгийн газар, Монголбанк, Хөгжлийн банк, улсын үйлдвэрийн газар ба хувийн хэвшлийн гадаад өрийг нэгтгэн Олон улсын валютын сангийн аргачлалаар өрийн тооцоо судалгааг үнэн зөв гаргаж цэгцлэх, улсын нэгдсэн гадаад өрийн бүртгэлд бүрэн хамруулах,

Б. Энэхүү өрийг өнөөгийн үнэ цэнээр биш нэрлэсэн үнээр нь тооцох өрийн эрсдлийн олон улсын стандартыг 2015 оны улсын төсөв УИХ-аар хэлэлцэх явцад нэн даруй нэвтрүүлж, хэрэгжүүлэх,

Г. Монголбанк, Сангийн яамны өрийн тайлангийн хоорондын тооцооны зөрүүг нэгтгэж нэг мөр болгох, Засгийн газрын өрийн тооцоонд Монголбанкны гадаад өрийг оруулж тооцох

Хоёрдугаарт, өрийн тайлан мэдээгээ нэг мөр, үнэн зөв, цэгцтэй болгосны үндсэн дээр Сангийн яамнаас боловсруулах 2016 оны төсвийн төсөлд 2017 оноос төлөгдөж эхлэх Хөгжлийн банкны 580 сая ам.долларын бонд, Засгийн газрын Чингис болон Самурай бондын үндсэн болон хүүгийн төлбөрийг хэрхэн төлөх талаар тодорхой судалгаа тооцоог оруулах,

Гуравдугаарт, Шилэн дансны мэдээллээр ард иргэдийн дунд нийтийн нээлттэй хэлэлцүүлэг явуулах, улмаар зардлыг танах, 2017 оноос эхлэн Хөгжлийн банкны бонд, Чингис бондуудын үндсэн өр төлбөрүүдийг хэрхэн төлөх талаар бодлого, төлөвлөгөөг Засгийн Газраас нэн яаралтай боловсруулан УИХ-аар батлуулж, хэрэгжүүлэх явдал нэн чухал байна. ■



Вирустсэн компьютер шиг болсон Монголын улс төр, эдийн засгийг форматлах хэрэгтэй

Г.Занданшатар: Монгол Улсын өр аюулын харанга дэлдэж байна

Д.Бэхбаяр

УИХ-ын гишүүн, Гадаад харилцааны сайд асан Г. Занданшатартай ярилцлаа. Тэрбээр сүүлийн жилд Монгол Улсын гадаад дотоод бодлогын асуудалд анхаарал хандуулж, бас өрийн талаар ч багагүй судалгаа хийсэн байна. Бидний ярилцлага голдуу Монгол Улсын өрийн асуудлаар өрнөлөө.

-Та улсынхаа эдийн засаг, улстөрд багагүй судалгаа хийж, олон нийтлэл бичиж, ном ч хэвлүүлсэн байгаа. Судлаачийн нүдээр харахад манай улс ямар харагдаж байна вэ? Таны санал дүгнэлтүүд арай өөр сонсогдоод байгааг анхаарч байна?

-Үнэндээ бол Монгол Улсын улс төр, эдийн засаг хэт халуунтай, өвчилсөн байна. Гар утас, компьютерээр бол вирустээд гацсан байна. Reset хийж форматлахгүй бол вирус устахгүй, файл дамжаад л байх болно. Өөрөөр хэлбэл

одоогийн улс төр, эдийн засгийн өвчний шалтгааныг олж цэвэрлээд шинээр цогц бодлого тодорхойлж нийтээр даган мөрдөх хэрэгтэй. Ийм учраас миний хувьд гурван шалтгаанаар арай өөр өнцгөөс асуудлыг харж байна.

Нэгдүгээрт, улс төрийн гал тогоонд зууралдахаас илүүтэйгээр холоос тэр дундаа өндөр хөгжилтэй Америк улсын ардчиллын загвараас эх орноо том зургаар нь харж шинжиж, ажиллаж, судалгаа хийхээр өөр бодол төрдөг байх. Хоёрдугаарт, шинжлэх ухаан судалгааны дэлхийн хамгийн алдартай төвүүдийн нэг Стэнфордын Их сургуулийн судалгааны гал тогоонд ороод ирэхээр шинжлэх ухаанч харьцуулалтын боломж их байдаг. Тэнд Америк, Африк, Ази, Европын эрдэмтэн судлаачдын орон орны эрдэм шинжилгээ, судалгааны ажлууд, лекц яриатай харьцуулахад Монголын

асуудлыг бас өөр өнцгөөс хардаг юм байна.

-Эдийн засгийг өвчлүүлээд байгааг тэр вирус нь юу юм бэ?

-Энэ вирусийг "итгэлцлийн хямрал" гэж нэрлэж байна. Энэ нь хоорондоо уялдаа холбоотой, гинжин хэлхээ бүхий Эдийн засгийн хямрал, хариуцлагын хямрал, хууль, засаглалын хямрал, институцийн хямрал, засаглалын хямрал гэсэн таван вирус юм байна. Эдгээр вируст халдварт өвчнөөс болж, манайх өрийн хямралтай улсуудын эхний наймд явж байна. Олон улсын судалгааны байгууллагууд, ОУВС, Дэлхийн банкны тайлан, Хятадын судалгааны байгууллагуудын гаргасан мэдээллээр Монголыг өрийн хямралд орж болзошгүй улс гэж дүгнэж мэдээлсэн. Олон улсын валютын сангийн өрийн тогтвортой байдлын судалгаагаар Монгол Улс ойрын хугацаанд liquidity

crisis буюу гүйлгээний чадваргүй болж болзошгүй улс, өрийн тоо мэдээлэл ч бүрэн бус байна гэжээ.

-Вируст өвчнөөс салахын тулд засаг төр одоо ямар алхам хийж байна гэж бодож байна вэ?

-Манайд сүх далайтал үхэр амар гэдэг шиг л байх шиг. Heritage болон олон улсын судалгааны байгууллагуудын 2015 оны судалгаанаас дүгнэхэд Монгол Улсыг өрийн хямрал руу түлхэж буй хамгийн гол хүчин зүйл бол хуулийн засаглал сул, авилгалын хяналт муу гэж үзжээ. Хуулийн засаглал сул учраас хариуцлагын засаглал байхгүй байна. Хариуцлага байхгүй учраас Засгийн газрын үр ашигтай ажиллагаа байхгүй байна. Энэ бүх хариуцлага дагаад УИХ-ын буюу хууль тогтоох чадамж тааруу байна гэж дүгнэсэн. Дэлхийн банкны засаглалын институцын чадавхаар Монгол Улсын үзүүлэлт сүүлийн 10 жилд байнга уруудсан. Өмнө нь үе үе сайжирсан үзүүлэлт гарч байсан боловч тогтвортой биш байсан. Энэ бүхэн хариуцлагагүй, их өртэй улс орныг бий болгож байна. Үүнийг засах иж бүрэн бодлого хэрэгтэй байна. Харилцан уялдаа холбоотой, цогц шийдэмгий бодлого хэрэгжихгүй байна.

-Та "Алт дилерийн хэрэг-2" нэршлийг гаргаж ирээд байгаа. Та энэ тухайгаа ярина уу?

-Манай улсын нийт өр 21.6 тэрбум ам.доллар байна. Нийт өрийн ДНБ-тэй харьцах харьцаа 180 хувьд хүрчихлээ. Нэгдүгээрт, энэ их өр, зээлийг эдийн засгийн үр өгөөжтэй, экспортыг дэмжих, импортыг орлох, улс орныг хөгжүүлэх зээлд зарцуулсан бол ам. долларын ханш 2000 төгрөг хүрэхгүй байсан. Хоёрдугаарт, энэ бүхний цаана Монгол банкнаас тараасан 3,8 их наяд төгрөгийн үнэ тогтворжуулах зээл, 888 компанид өгсөн Чингис бондын зээлийн үр өгөөжийн асуудал нуугдаж байна. Монгол Улс хяналтгүй гурван төсөвтэй болсон. Хөгжлийн банк, Монгол банкны зээл гэж. Үүнийг "Алт дилерийн хэрэг-2" гэж нэрлэж байна. Намайг банкинд ажиллаж байхад банкны балансын гадуурх тайланд хувийн хэвшлийн болзошгүй гадаад өглөгийг бүртгэж, Төв банкинд тайлагнадаг байсан. Энэ байдал байхгүй болсон учраас 21.6 тэрбум ам.долларын өр бол бас бүрэн

бус тооцоо биш. Эндээс бид валютын төлбөрийн балансын тооцоохийх ёстой. Гэтэл гадаад өглөгийн тоо бүрэн бус, Дэлхийн банк, ОУВС-гийн тайлантай зөрж байгаа нь тодорхой болсон.

Гуравдугаарт, өрийн таазыг УИХ Засгийн газрын саналаар өсгөчихөөд өнөөдрийн үнэ цэнээр тооцож, бодит байдлыг буруу мэдээлж байгаа хэрэг юм. Өр, өр даах чадварын харьцааг өнөөдрийн үнэ цэнээр тооцдоггүй. Засгийн газрын нийт өрд Монгол банкны өр, улсын үйлдвэрийн газрууд жишээлбэл МИАТ-д гаргасан баталгаа, Хөгжлийн банкны өр бүгд орох ёстой. Миний бие Их сургуульд өнөөгийн болон ирээдүйн үнэ цэнийн талаарх корпорацийн санхүүгийн хичээл заадаг байлаа. Тэгэхээр би санаатайгаар өрийн ДНБ-тэй харьцах хязгаарыг Өрийн тааз тогтоох хуулийг зөрчих, ард түмний толгойг эргүүлэхийн тулд буруу тооцоолж байна гэж үзэж байна. Өнөөдрийн яг бодит тооцоогоор манай улсын өрийн тааз хэтэрчихсэн явж байгаа. Санхүүгийн тайлан мэдээг буруу гаргаж байна. Ганцхан жишээ хэлэхэд Сангийн яамны өнөөдрийн тооцоогоор Монгол Улсын өрийн ДНБ-тэй харьцах харьцаа 48.1 хувьтай байна. Энэ бол өрийг өнөөгийн үнэ цэнэд шилжүүлчихсэн харьцаа. Харин ОУВС, Дэлхийн банкнаас гаргадаг аргачлалаар 58,5 хувьд хүрсэн гэдгийг хэлэх хэрэгтэй. Өрийн тааз хэтэрчихсэн гэсэн үг.

-Бусад улс оронд өрийн хэмжээ нь ихэссэн, өрийн таазын хэмжээ ч нэлээд өндөр байдаг юм билээ. Манай холбогдох байгуулагынхан ингэж тайлбарладаг.

-Өрийн хэмжээ их байх нь асуудал биш. Германы ДНБ, өрийн харьцаа 74.70 хувь, нийт өр нь 1.8 триллион евро, Японы өр 11 их наяд доллар, ДНБ өрийн харьцаа 245 хувьд хүрснийг ОУВС анхааруулсан. Гэхдээ эдгээр нь экспортын асар том салбартай улсууд. Өөрөөр хэлбэл, нэмүү өртөг үйлдвэрлэдэг улсууд учраас экспортын орлогоороо өрийг буцааж төлөх асуудал нь тийм ч хүндрэлтэй биш. Харин Монгол Улсын хувьд зөвхөн нэг зах зээлээс хамаарч, уул уурхайн бүтээгдэхүүн экспортолдог. Хятадын эдийн засаг саарч байна. Шанхайн Хөрөнгийн биржийн огцом уналт

нэгийг хэлж байна. Нэг улсаас, цөөхөн бүтээгдэхүүнээс хамааралтай эдийн засагтай улс шүү дээ, манайх. Тиймээс энэ их өрийг төлөх гадаад зах зээлийн эрсдэл өндөр байгаа юм.

Өрийг эргэн төлөх нь эдийн засгийн, экспортын бүтээгдэхүүний чадавхиас ихээхэн хамаардаг. Тэгвэл Чингис бондын 1.5 тэрбум ам.доллар, Самурай бонд, Хөгжлийн банкны зээлүүдийг нэмүү өртөг бүтээдэггүй үр ашиггүй салбарт зарцуулсан учраас эргэн төлөх чадваргүй байгаа юм. Эргэн төлөх тооцоолол байх ёстой. Жишээлбэл, Гудамж төсөл. Хичнээн сайн ч хэдэн арван жилдээ энэ төслөөс мөнгө орж ирэхгүй. Чингис бондоос гэхэд төмөр замд 200 сая ам.доллар зарцуулсан гэсэн байна. Хаана байна төмөр зам? Энэ бол цэвэр хариуцлага. Ийм учраас л би энэ хариуцлагагүй ажлуудыг "Алт дилер-2" гэж нэрлэсэн.

Дээр нь цөөхөн компанид Монголбанкны дөрвөн их наяд төгрөгийн үнэ тогтворжуулах төслийн зээл, 888 компанид олгосон Чингис бондын зээлийн зарцуулалт үр дүнтэй өгөөжтэй байсан бол эдийн засаг хямрахгүй. Юунд зарцуулсан нь тодорхойгүй, ил тод бус зээлүүд. Энэ дөрвөн триллион төгрөгийн үр өгөөж өнөөдөр мэдэгдэхгүй байна, аудит болон хөндлөнгийн хяналт ч хийгээгүй явж байгаа.

-Өр, зээлийг хаанаас, ямар эх үүсвэрээс төлөх талаар тодорхой зүйл өнөөдөр алга. Өрийн талаарх судалгааг нэлээд сайн хийсэн хүний хувьд энэ байдлыг хэрхэн харж байна вэ?

-Энэ жил бид 960-аад сая ам.доллар эргүүлэн төлөх ёстой. Зах зээлээс ийм хэмжээний мөнгө гарахад валютын ханш дахин өснө. 2016 онд 400 сая ам.доллар төлөх ёстой. Дээр нь хамгийн хүнд асуудал нь 2017 онд 3.6 тэрбум ам.доллар төлөх ёстой. 2018 он гарангуут нэгдүгээр сард Чингис бондын эхний 500 сая ам.доллар төлөх хуваарьтай.

Тэгэхээр өрийн эргэн төлөлт манай эдийн засгийг яаж өөрчлөх бол? Дээрх зээлийг бид хаанаас төлөх вэ. Нэг бол дахин зээл авч төлөх болно. Зээл авах гэхээр улсын зээлжих зэрэглэл доошоо уначихсан учраас өндөр хүүтэй зээл авах болно. Мөн өрийн тааз нь

тулчихсан. Ийм аюултай дохио дэргэд тулаад ирсэн байна. Гэтэл төр, засагт энэ асуудалд анхаарал тавихгүй байна, өрийг хаанаас хэрхэн төлөх талаар тодорхой бодлого стратеги ч алга.

Ер нь төсвийн зарлагаа хэмнэх, татвар өсгөхөөс өөр гарцгүй харагдаж байгаа. Томоохон төслүүдийг хүчээр хөдөлгөхөөс өөр арга байхгүй. Хэмнэлтийн горимд шилжээгүйг нийгмийн сүлжээгээр явж байгаа Шилэн дансны зарим тайлан харуулна. Зарим газар шилэн данс сураг ч үгүй байна. Бас ОУВС-гийн тавьсан шаардлагыг биелүүлэхгүй байгаа. Манай Засгийн газар өрөө төлөх асуудалд биш 2016 оны сонгуульд л ихэд анхаарч, ширээ



Г.Занданшатар: Яг үнэндээ өнөөдөр бүсээ чангалаагүй байна.

сандалтайгаа зууралдсаар ихэнх цагийг авч байна.

Эм ууж эдгээхтэй адил эрс хатуу бодлогод Үндэсний эв нэгдэл хэрэгтэй. Авлигалын мөнгө төгрөгийг хурааж, Засгийн газрын бонд гаргаж, ард иргэдийн алт, мөнгөн эдлэлийг худалдаж авах ч юм уу, өөр ямар арга байдаг талаар санал бодлоо хуваалцах ёстой. Гэтэл өнөөгийн засаг зардлыг санхүүжүүлэх, цалинг тавихын тулд л ажиллах. Яг үнэндээ өнөөдөр бүсээ чангалаагүй байна. Сангийн яамны харьяа болон төрийн бусад байгууллага төрийн, төслийн мөнгийг үрж дууслаа. Өрийн бодьтой, зөв тоог гаргаагүй

учраас Засгийн газар ч мөн түүндээ хууртагдаад явж байна. Эдийг засгийг сэргээх бодьтой ямар ажил хийсэн юм бэ.

-Та өрийн талаар буруу тоо гаргаж, иргэдийг хуурч байна гэсэн том мэдээлэл өгч байна. Миний хувьд таныг судлаач, эдийн засагчийн хувиар энэхүү ярилцлагыг хийж байгаа. Та өрийн талаар судалгаа, тоогоо холбогдох байгууллага, хүмүүст танилцуулсан уу?

-Нийтлэл бичиж, шаардлага гаргасан. Танай сэтгүүлд ярилцлага өгч байгаа нь ч төр, засагт хүргэх нэг хэлбэр. Сая манайхан Засгийн газрын гадаад өрийн хямрал болж болзошгүй 14 улсын наймд нь Монгол Улс орсон байна гээд шуугиад л өнгөрлөө. Яагаад наймд оров, гарах арга зам юу байна гэдгийг холбогдох байгууллагууд судалж байгаа болов уу гэж найдаад хариуцаж буй хүмүүсээс лавлахад тодорхой бодлого одоогоор мэдэгдэхгүй байна.

Уг нь миний бичиж буй судалгааны ажил, ном өөр чиглэлээр байсан. Өрийн тухай судлаад ирэхээр энэ ажил руу орохоос өөр аргагүй болсон. Баланс нь зөрнө. Яагаад зөрөөд байна вэ гээд лавлахаар мэдэх газар байхгүй. Манай Засгийн газар өөрийн хариуцлагагүй, үр ашиггүй байдлаас авч хэлэлцдэггүй. Хуулийн засаглал, тогтвортой байдал, төрийн бодлого үйл ажиллагааны залгамж халаа манайд байхгүй. Хөгжлийг хэмждэг улс төрийн тогтвортой байдлын нэг үзүүлэлт байдаг. Энэ нь бодлогын тогтвортой байдлыг хэлж байгаа юм. Япон, Солонгос зэрэг Азийн зарим улсад бодлогын тогтвортой байдал маш сайн мөрдөгддөг. Японд төрийн алба 59 жилийн хугацаанд нэг ч өөрчлөөгүй бодлогыг баримталж чадсан байдаг. Сайд ирлээ, явлаа ямарч бодлогын өөрчлөлт гарахгүй.

-Манайд залгамж халаа гэсэн ойлголт ерөөсөө алга. Нэг юм хийлээ, дараагийн нам гарч ирлээ, ор үндэсгүй алга болох жишээтэй.

-Азийн найман улсын хөгжлийн бодлого загвар, ардчиллын амжилттай хөгжилд хийсэн бидний судалгаа байгаа юм. Бас Зүүн Азийн орнууд хөгжлийн эдийн засгийн бодлогоо хэрэгжүүлэх зорилгоор ямар төрлийн засаглалын сонголт хийсэн тухай Др.Инагучи нарын судалгааны хүрээнд Зүүн өмнөд Азийн найман орныг хамруулж, гурван

хэсэгт хуваасан байдаг. Эдгээр хэсэгт хамрах улс орнууд үндэсний стратегийн зорилт дэвшүүлж, хэрэгжүүлсэн байдал, засаглалын онцлогоороо ялгаатай. Сайн засаглалын хэмжүүр, улс үндэстэн нэгдэж стратегийн зорилтоо боловсруулан дэвшүүлэх чадвараас хамаарч, Зүүн өмнөд Азийн найман улс ялгаатай хөгжлийн түвшинд хүрсэн байна. Хөгжлийн ялгааны шалтгаан нөхцөл болсон хөгжлийн онолын хоёр хүчин зүйлийг хэрхэн хэрэгжүүлсэн байдлыг судалж үзэхэд нэгдүгээрт, эдийн засгийн хөгжилд хөтөлсөн сайн засаглал, хоёрдугаарт, үндэсний хөгжлийн стратеги бодлого, зорилт нөлөөлсөн байна.

Азийн орнуудын хөгжлийн нэгдүгээр хэсэгт, Сингапур, Солонгос, Хонконг болон Тайвань улсууд хамрагдана. Энэ дөрвөн улсын хамгийн гол бодлого нь үндэсний хөгжлийн бодлого. Уг бодлогоо тодорхойлж, түүнийхээ дагуу бодлогоо боловсруулж, ягштал хэрэгжүүлснээр улсаа хөгжүүлсэн. Тухайлбал, Япон дайны дараа шууд хэлээгүй ч Америк орныг гүйцэж түрүүлнэ гэсэн бодлого гаргаж, бүх нийгмээрээ хүлээн зөвшөөрсөн. Энэ бол япон мөрөөдөл. Хамгийн эхлээд гангийн үйлдвэртэй болсон. Дараа нь машин үйлдвэрлэнэ, электрон барааны үйлдвэртэй болно гэсэн Арлын орны хөгжлийн циклийг нь аваад үзвэл 10, 10 жилийн зайтай үндэсний хөгжлийн бодлогоо тодорхойлсон байдаг. Солонгос мөн адилхан Японыг гүйцэж түрүүлэх үндэсний хөгжлийн бодлого тодорхойлсон.

Хөгжлийн бодлого боловсруулах институци нь улстөрчид, нам хүчин биш төрийн мэргэшсэн тогтвортой алба. Эдгээр улсад төрийн албанд ажиллах нь хамгийн нэр хүндтэй, чадварлаг, улс төрийн ямар ч нөлөөнд автдаггүй албад тооцогддог. Ямар ч сайд ирсэн халагддаггүй тогтвортой байдал нь улс орныг хөгжүүлжээ. Японы хөгжлийн загвар Солонгос, Тайвань, Сингапур, Хонконгийн хөгжлийн бодлогын үлгэр жишээ болсон байдаг.

Азийн хөгжлийн хоёрдугаар хэсэгт Индонези, Тайланд, Малайз улс багтдаг. Гуравдугаар хэсэгт Филиппин орно. Байгалийн баялаг асар ихтэй мөртлөө хуулийн засаглал муу, төрийн албаны чадавх сул орон. Монгол Улс Филиппин

маягийн загвар руу орж байна. Үүний гаргалгаа нь төрийн алба, улс төрийн нөхцөл байдал, уул уурхайд түшиглэсэн бодлого зэрэг олон хүчин зүйлээс шалтгаална. Мөн үндэсний хөгжлийн тогтвортой бодлогогүй, байлаа гэхэд тунхаглалын чанартай, нийгмээрээ хүлээсэн зөвшөөрсөн зорилго, зорилт байхгүй. Форбес сэтгүүлийн 2013 оны судалгаагаар Филиппин улсын ДНБ-ий өсөлтийн 76 хувийн үр шимийг ердөө 40 гэр бүл хүртэж эзэмшдэг бол Тайланд улсад 33,7, Малайз улсад 5,6, Япон улсад 2,8 хувь байсан. Цөөхөн гэр бүл тухайн улсын ДНБ-ий өсөлтийн 10-аас дээш хувийг эзэмшиж байвал тэдний нөлөө улс төр, эдийн засгийн бодлогыг залуурдах нөлөөлөх боломжтой болдог.

-Азийн орнуудад ардчилал хөгжиж байна уу, эдийн засаг нь хөгжиж байна уу? Ардчилал, засаглал, эдийн засгийн хөгжлийн хамаарлын талаар таны судалгаанаас ямар дүгнэлт гарч байна вэ?

-Экспортод суурилсан үйлдвэрлэлийн эдийн засгийн бодлого хэрэгжүүлснээр Зүүн өмнөд Азийн орнууд дотооддоо хуримтлал бүхий, сайн дэд бүтэц болон хэрэглээний эдийн засгийн тогтцыг үүсгэн байгуулж чадсан. Японы загвараас үлгэр авч, БНСУ болон Тайван гэх мэт улсууд хөгжлийн сууриа тавьсан. Эдгээр улс электроник хэрэгсэл болон компьютерийн үйлдвэрлэл, мэдээллийн технологийг давуу хөгжүүлснээр одоогийн хөгжилд хүрсэн шүү дээ. Хоёрдугаар хэсгийн Малайз, Индонез болон Тайланд улсууд нь Японы үйлдвэрүүдийн бүтээгдэхүүн нийлүүлэх орнууд болсон бөгөөд нэгдүгээр хэсэгт орсон улсуудтай харьцуулах юм бол харьцангуй хөгжил нь удаашралтай байсан. Эдгээр улс Солонгосын 1990 оны эдийн засгийн хөгжлийн төвшинд хүрэхийн тулд Малайз 17, Тайланд 22, Индонез 44 жилийг зарцуулсан. Гурав дахь бүлэг дэх Филиппин улс эхний хоёр хэсгээсээ хөгжлөөр хоцрогдсон улс болсон.

-Та зөвлөлдөх ардчиллын талаар ном бичсэн. Энэ талаараа ярина уу. Монголд нэвтрүүлэх боломжтой юу?

-Ардчиллын талаар харьцуулсан судалгаа хийж, том эрдэмтэдтэй уулзаж, ярилцсан зүйлсээ хуваалцах ёстой учраас "Зөвлөлдөх ардчилал ба хөгжлийн гарц" судалгааны чиглэлтэй

ном бичсэн. Өнөөдөр дэлхий дахинд ардчиллын гурав дахь давалгааны дараахь ухралтын үе тохиож байна. Даяаршил техник технологийн эрин үед дэлхийн олон орны ардчилал саарч, ухарч, хямралд орж байна. Тиймээс улс төрийн шинжлэх ухаанд ардчиллыг боловсронгуй болгох арга хэлбэрийг эрэлхийлж байна. Миний хувьд тэрхүү гарц нь зөвлөлдөх ардчилал гэж үзэж байгаа.

Монголд зөвлөлдөх ардчилал хэрэгтэй. Энгийнээр хэлбэл, бүгдээрээ

Гуравдугаар хэсэгт Филиппин орно. Байгалийн баялаг асар ихтэй мөртлөө хуулийн засаглал муу, төрийн албаны чадавх сул орон. Монгол Улс Филиппин маягийн загвар руу орж байна.

Үүний гаргалгаа нь төрийн алба, улс төрийн нөхцөл байдал, уул уурхайд түшиглэсэн бодлого зэрэг олон хүчин зүйлээс шалтгаална. Мөн үндэсний хөгжлийн тогтвортой бодлогогүй, байлаа гэхэд тунхаглалын чанартай, нийгмээрээ хүлээсэн зөвшөөрсөн зорилго, зорилт байхгүй.

хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй гэсэн ардын маань сайхан зүйр үг байна. Гол санаа нь ард түмнээ сонсож, тэдэнтэйгээ ярилцаж зөвлөлдөх гэж байгаа юм. Манай одоогийн ардчилал бол төлөөллийн ардчилал. Төлөөллийн ардчилал болохгүй байна. Төлөөллийн гишүүд болохоор ард түмний биш бүлгийн эрх ашигт үйлчлээд байна. Төлөөллийн ардчилал нь ард түмнээ төлөөлж байх

ёстой.

Монголын эдийн засгийн хямрал хариуцлагагүй төрийнх гэдэг нь ойлгомжтой. Хариуцлагын төрийн хямрал нь хувь улстөрчдийн хариуцлагаас үүдэж эдийн засгийн, хариуцлагын, хуулийн засаглалын, институцийн, засаглалын гэх таван төрлийн хямрал гинжин холбоог үүсгэсэн гэдгийг би дахин онцлон хэлмээр байна. Таван толгой, төмөр зам бусад олон тулгамдсан асуудлыг зөвлөлдөх ардчиллын аргачлалаар шийдсэн бол бид маш хурдацтай хөгжих байлаа. Оюутолгойг ч зөвлөлдөх ардчиллаар шийдсэн бол ийм их хэл ам гарахгүй явах байсан гэж боддог.

-Цаашдаа ямар бодлого хэрэгжүүлэх талаар таны санал юу байна вэ?

-Зэс, нүүрсний дэлхийн зах зээл дээрх үнийн прогноз дунд хугацаанд тааруу байна. Хятадын эдийн засгийн өсөлт саарлаа. ОХУ, Хятадын уул уурхайн түншлэл, Хятадын Засгийн газраас гаргасан уул уурхайн бүтээгдэхүүнүүдэд тавьсан импортын татвар зэрэг хүчин зүйлс нь манай гадаад өрийн төлбөрийн байдалд ихээхэн сөрөг нөлөөг үзүүлж мэдэхээр байна. Иймд Өрийн шилэн данстай болох хэрэгтэй. Засгийн газрын гадаад өрийн талаарх ойлголтыг цэгцлэх шаардлагатай. Улсын өрийн талаархи үнэн бодит мэдээллийг гаргаж шилэн дансаар ард түмэнд тайлагнах хэрэгтэй байна. Мөн Олон улсын валютын сан, Дэлхийн банкны аргачлалаар өрийн тооцоо судалгааг үнэн зөв гаргаж цэгцлэх. Өнөөгийн үнэ цэнээр биш нэрлэсэн үнээр нь өрийн таазыг тооцдог олон улсын стандартыг 2016 оны төсөв хэлэлцэх явцад нэн даруй нэвтрүүлж, хэрэгжүүлээсэй.

Монголбанк, Сангийн яамны өрийн тайлан хоёр өөр тоо гаргаж байгааг нэг мөр болгох, Засгийн газрын өрийн тооцоонд Монгол банкны өрийг оруулж тооцох нь зөв. Түүнчлэн 2017 оноос эхлэн Хөгжлийн Банкны бонд, Чингис бондуудын үндсэн өр төлбөрүүдийг хэрхэн төлөх талаар бодлого төлөвлөгөөг Засгийн газраас нэн яаралтай боловсруулан эрдэмтэд судлаачдаар хэлэлцүүлэх нь чухал байна. Төсвийн бүх шатны үр ашиггүй зарлагыг танаж улс даяар хэмнэлтийн горимд шилжих саналуудыг би дэвшүүлж байгаа. ■

Гадаад өрийн дарамтад орж байсан хоёр орны жишээ



Эдийн засагч, судлаач Л.Гангэрэлийн манай сэтгүүлийн энэ оны 081 дугаарт бичсэн "Засгийн газрын гадаад өрийн тойм" нэртэй нийтлэлээс товчлон хүргэж байна.

Л.Гангэрэл /Эдийн засагч/

Аль ч улсын Парламент Засгийн газартаа гадаад өр төлбөрийн сайн хяналт тавьж байх шаардлагатай Засгийн газрын гадаад өрийн асуудал нь зөвхөн улсын гадаад өрөөс гадна хувийн хэвшлийн гадаад өрийн менежменттэй салшгүй холбоотой асуудал. Засгийн газрын гадаад өр ба хувийн хэвшлийн гадаад өрийн асуудлыг хамтад нь хөндсөн, гадаад өрийн дарамтад орж байсан Чили, Аргентин улсын жишээг авч үзье.

Чили:

-Чилийн их өрийн уг эх сурвалж нь 1975 оноос эхлэлтэй хувийн хэвшлийн хяналтгүй, их хэмжээний зээллэгтэй холбоотой

-1979-1982 онд үйлчилж байсан тогтмол ханшны бодлогоос улбаалан гадаад валютын зээл нь харьцангуй хямдаар олдож байсан

-Нэмээд Төвбанкнаас дотоодын банкуудын гадаадаас авах зээлд тавих хязгаарлалтыг 1980 онд үгүй хийсэн

-Дээрх бүх арга хэмжээнүүдийн дүнд Чилийн Засгийн газрын гадаад өр эдийн засгийн их идэвхжлийн үедээ (1982-1988) 6.6 тэрбум ам.доллараас 13.2 тэрбум хүртэл, хувийн хэвшлийн гадаад өр 807.0 сая ам.доллараас 10.6 тэрбум ам.доллар болж өссөн

Гадаад өрийг бууруулах талаар Төвбанк, Засгийн газраас хамтран авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд:

-Гадаад өрийн төлөх хугацааг сунгах,
-Үндсэн төлбөр болон хүү төлөх хугацааг өөрчлөх, зарим зээлийн хувьд зээлийг эргэн үнэлэх

- Зээлийн төлбөрийг хийхийн тулд шинээр мөнгөний нийлүүлэлт хийх амлалт авах зэрэг ажлыг гадаадын зээлдэгчтэй хамтран хийсэн.

Төв банкнаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд:

-Олон улсын бондын зах зээл дээр 30 хүртэл хувиар хямдраад байсан Засгийн газрын бондоо эргүүлэн худалдан авах

-Хувийн хэвшлийн гадаад өрийг хөрөнгөжүүлэх (өрийг хувьцаанд хөрвүүлэх механизм)

Ингэж ажилласны үр дүнд Засгийн газар гадаад өрийн 14 хувийг эргүүлэн худалдан авах механизмаар, хувийн хэвшлийн гадаад өрөө хөрөнгөжүүлэх схемээрээ 624 сая ам.доллараар багасгаж чадсан.

Аргентин:

Латин Америкийн орнуудын зээлийн их хямралын үед Аргентин 1982 онд өөрийн анхны гадаад өрийн дефолтоо зарласан. ОУВС, Дэлхийн банкны өгсөн заавар зөвлөмжийг сайтар биелүүлж, онц үнэлгээ авсны үндсэн дээр 1994 оноос эхлэн Аргентин улс гадаад өрийн зах зээлд нэвтрэх боломжтой болсон бөгөөд 1992-1999 онд гадаад өр нь 61 тэрбум ам. доллараас 145 тэрбум болтол огцом өссөн.

Гадаад өр огцом өссөн шалтгаанууд: 1989-1990 оны өндөр инфляцийн дараа эдийн засгийн бүтцийн өөрчлөлт хийх нэрийдлээр гадаад худалдаа, хөрөнгийн гадагшлах үрсгалыг либериальчилсан.

Түүнчлэн гадаад валютын хөрвөх хууль гэгчийг гаргаж ам.долларыг песотой 1:1 гэсэн тогтмол ханшаар уяж өгсөн. Гадаад худалдааны чөлөөлөлт болон тогтмол ханшны бодлого нь гадаад валютын эрэлтийг нэмэгдүүлж, гадаадаас зээллэг авахаас аргагүй байдалд хүргэсэн.

Дээрх хоёр орны жишээнээс авах сургамжууд:

-Хувийн хэвшлийнхээ гадаадаас авах зээллэгийг зохицуулж, хязгаарладаг арга механизмыг сайтар боловсруулж, түүнийг мөрдөж байх.

-Төвбанк нь Засгийн газартайгаа хамтран өөрийн орны онцлог тохирсон гадаад өрөө багасгах стратеги төлөвлөгөөг боловсруулан түүнийг улс төрийн нөлөөнөөс харьцангуй ангид хэрэгжүүлж чадвал гадаад өрийн дарамтнаас гарч болдог.

- Гадаад валют, гадаад худалдааны үйл ажиллагаагаа хэт либериальчлах бодлого явуулах нь эдийн засгийн хөгжил, бизнесийн өрсөлдөх чадвар дорой улсуудын хувьд хүндээр тусч болдог.

-Эдийн засгийн томоохон реформыг ихээхэн тооцоо судалгаатай, тухайн улсынхаа гадаад болон дотоод өрийн байдал, нийт макро эдийн засгийн хэтийн төлөвтэйгээ уялдуулан авч хэрэгжүүлэх шаардлагатай.

-ОУВС, Дэлхийн банк зэрэг олон улсын санхүүгийн байгууллагуудын тухайн орны эдийн засгийн талаар өгч буй заавар зөвлөгөөг өөрийн орны онцлог, гадаад болон дотоод улс төр, эдийн засгийн нөхцөл байдалтайгаа уялдуулан авч үзэн тэдгээр зөвлөгөөг

авч хэрэгжүүлэх эсэхээ шийдэж байх нь чухал.

Бодлогын зөвлөмж

-ОУВС-гийн Засгийн газрын гадаад өрийг тооцоолдог аргачлалын дагуу Монголбанкны гадаад өрийг Засгийн газрын гадаад өрөнд оруулж тооцоолох

-Засгийн газраас Хөгжлийн банк, Засгийн газрын бондуудын үндсэн төлбөр болон хүүг хэрхэн төлөх нарийвчилсан стратеги төлөвлөгөөг боловсруулж, УИХ-аар нэн яаралтай батлуулах

-Монгол Улс өөрийн гадаад бонд болон бусад гадаад өр төлбөр дээрээ дефолт болвол ямар хариуцлага хүлээх,

үүний эсрэг ямар арга хэмжээ авах талаар судалгааг Засгийн газраас яаралтай хийх

-Цаашид Засгийн газар эсвэл Хөгжлийн банк гадаад бонд гаргах болон гадаад их хэмжээний зээллэг авахдаа түүнийгээ юунд зарцуулах төсөв төлөвлөгөөгөө УИХ-аар урьдчилан батлуулж байх

-Хувийн хэвшлийн гадаад өрийг улсын нэгдсэн гадаад өрийн бүртгэлд бүрэн хамруулан бүртгэдэг олон улсын стандартыг нэн даруй нэвтрүүлж хэрэгжүүлэх

-Төвбанк, Сангийн яамтай хамтран хувийн хэвшлийн гадаад өрийн зохицуулалтыг хийх хууль эрх зүйн

механизмыг бий болгож, хэрэгжүүлэх

-Нэн тэргүүнд ашиглах боломжтой ашигт малтмалын стратегийн ордуудын гадаад хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулахдаа нэг шалгуур үзүүлэлтээр нь урт хугацаат, хямд өртөгтэй санхүүгийн эх үүсвэр өгөх гэж сонгон, уг эх үүсвэрээр богино, хугацаатай, өндөр өртөгтэй гадаад өрөө төлөх

-ОХУ-аас импортолдог нефть, шатахууныг махны бартер худалдаа болон Оросын Төвбангтай рублийн своп хэлцэл хийх замаар рублиэр худалдан авах арга замыг эрэлхийлж, гадаад валютын гадагшлах урсгалыг багасгах шаардлагатай. ■

ЗОЧИН

Биатрис Ди Мауро: Монгол дараагийн Грек гэж хэлэхгүй ч өртөмтгий байна

Б.Үүрийнтуяа

Биатрис Вэдер Ди Мауро 2001 оноос хойш Майнцын Иоханс Гутенбергийн их сургуулийн Олон улсын макроэдийн засгийн тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байна. Тэрбээр 2004-2012 онд Германы эдийн засгийн шинжээчдийн хорооны гишүүнээр, 2002-2004 онд Швейцарийн эдийн засгийн зөвлөхүүдийн хороонд ажиллаж байсан бөгөөд Австри улсын Дэд Канцлерын зөвлөх хийж байсан. Түүнчлэн 1994-1996 онд Олон улсын валютын санд эдийн засагч, тус байгууллагын судалгааны хэлтэст эрдэм шинжилгээний ажилтнаар уригдаж



Хуримтлал үүсгэж байж төсвийн алдагдлыг бууруулж, өрөөс мултарна

байсан удаатай.

Тэрбээр манай улсад дөрвөн өдөр саатсан бөгөөд "UB Impulse: Чанартай өсөлт" цуврал лекцид уригдан "Улсын өрийн зохицуулалт: Европын холбооны туршлага" сэдвээр илтгэсэн. Энэ хүрээнд манай сэтгүүл түүнтэй Монгол Улсын өрийн асуудлаар ярилцсан юм.

-Грек, Аргентин хоёр орныг дэлхийн эдийн засгийн "нүдэнд орсон шороо" нь гэх болсон. Монгол Улсыг ч мөн дээрх орнуудтай харьцуулах болж. Та үүнтэй санал нэгдэх үү?

-Монгол Улсын хувьд өрийн хэмжээгээ бууруулж чадахгүй байгаа нь сэтгэл зовних нэг үндэслэл яах аргагүй мөн. Гэвч өрийн хэмжээг Грек тэргүүтэй орнуудтай харьцуулвал тийм ч өндөр санагдахгүй байна. Гэхдээ Монгол евро бүсийн улс биш. Ийм учраас Монголын ард, Грекийн адил Европын Төвбанк зогсохгүй. Европын Төвбанк Грекийн арыг дааж байгаагүй бол өнөөдөр тэд тэр хэмжээний өрөнд дарагдахгүй байсан. Тэгэхээр, дангаараа гэж болох Монгол шиг орнууд өр дааж даважгүй хэмжээнд

асар хурдан хүрэх магадлалтай. Учир нь зээлдэгчид ажиглалтын байдалд шилжсэнээр зээлийн хүү өсөх аюултай. Иймд Монгол Улс өрийн хэмжээгээ бууруулахад анхаарах шаардлагатай. Үүнтэй холбоотой хууль, дүрмүүд байна. Гэхдээ хэрэгжүүлэх хэрэгтэй.

-Өрийн хэмжээг аль болох бага хэмжээнд барих хэрэгтэй гэлээ. Тэгвэл Монгол Улсын Засгийн газар өрийн асуудалдаа хэрхэн хандах ёстой юм бол?

-Өрийг бууруулах хэдхэн арга байдаг. Хэрэв инфляци бага, өсөлт бодит бол өрөөс мултрах арай хялбар болно. Хоёрдугаарт, бүтцийн өөрчлөлт. Гэхдээ улс орнууд бүтцийн өөрчлөлт хийх хүсэлгүй байдаг нь зээлдэгчдэд энэ нь таалагддаггүйтэй холбоотой. Гуравдугаарт, евро бүсийн орнуудын хэрэгжүүлж буй төсвийн таналт. Ингэснээр төр мөнгөний бодогоо чангалж, өрийн хэмжээгээ бууруулах боломж бүрдэнэ. Олон улсын валютын сангийн сүүлийн мэдээллээс харахад Монгол Улс бодлогоо чангатгаж, алхам алхамаар өрийн хэмжээгээ бууруулахыг зөвлөсөн байсан.

-Монгол Улсын Засгийн газар олон улсын зах зээл дээр бонд гаргасан. Харамсалтай нь, босгосон мөнгөө үрэн таран хийчихлээ гэсэн шүүмжлэлд нэлээдгүй өртөж байгаа. Харин одоо өмнөх бондын өрийг дарахын тулд ахин бонд гаргах тухай ярьж эхэлсэн нь ухаалаг алхам байж болох уу?

-Тийм ч оновчтой арга гэж хэлэхгүй. Хэрэв инфляци болон өр өссөөр байвал түүнийг санхүүжүүлэх хүндрэлтэй болно. Иймд мөнгөний хатуу бодлого барих хэрэгтэй. Ийм зүйлс байгалийн баялагт суурилсан эдийн засагтай орнуудад түгээмэл тохиолддог. Газар доорх баялагаа барьцаалах хэлбэрээр зээл аваад байдаг. Ингэх нь газар дор байгаа хөрөнгөө баялаг болохоос нь өмнө үрчихэж байгаа гэсэн үг. Өрийг өрөөр дарна гэдэг ухаалаг алхам биш. Яг ийм замаар Грек явсан. Өр, зээл асуудал дэгдээх хэмжээнд хүрч эхэлмэгц бууруулах арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай. Урд хормойгоороо хойд хормойгоо нөхөх замаар улам их өр тавиад байж болохгүй. Гадаад өр, валютын өр зэрэг нь ахархан хугацаанд асар өндөр болж орхидог. Тийм учраас тухайн улс ийм төрлийн хямралд

өртөхгүй байх асуудалд тун няхууртай хандаж байх хэрэгтэй. Монголын санхүүгийн үзүүлэлтүүдээс анзаарахад байдал тун муу харагдаж байгаа юм. Хямрал тохиохын өмнө эдийн засгийн үзүүлэлтүүд гэрэл, гэгээтэй харагдаж болох ч тэдгээрийн цаана оршиж буй бодит байдал хүндэрсэн болохыг хожуу олж харах нь түгээмэл байдаг.

-Тоонд хууртаж байна гэсэн үг байх нь?

-Тийм. Тухайлбал, Европын хямралын өмнөхөн банкуудын мөнгөн хөрөнгийн дүн боломжийн харагдаж байлаа. Гэвч мөнгөн хөрөнгө болоод эрсдэлийн тонн үзүүлэлт буруу болох нь батлагдсан шүү дээ. Аюул дэгдсэний дараа "ийм юм болно гэж мэдсэн юм" гэж хэлэх амархан байдаг. Харамсалтай нь, өмнө нь бүгд хэтэрхий тайван байсаар алдаж орхидог.

-Тэгвэл манай улсын хувьд бид өрийн дарамтад орохгүйн тулд юу хийх ёстой вэ, Монголын Засгийн газар өрийн таазаа ДНБ-ий 58 хувиас хэтрэхгүй байхаар тогтсон. Үүн дээр таны бодол?

-Тун энгийн. Хуримтлал үүсгэх хэрэгтэй. Тэгж байж төсвийн алдагдлыг бууруулж, өрөөс мултарна. Дэлхийн банк болон Олон улсын валютын сангийн өнгөрсөн оны тогтвортой байдлын судалгаагаар Монгол Улсын өрийн эрсдлийг "тогтвортой, өрийн хэмжээ өсөх эрсдэл өндөр" гэсэн байсан. Энэ нь Монгол өрийн хямралд орох магадлалтай гэсэн үг. Дээрх судалгаанд тухайн улсын засаглалын, тухайлбал, улс төрийн, татварын болон хүнд суртлын зэрэг тогтвортой байдалтай хамаарах зүйлсийг харгалзан үздэг. Харин Монгол засаглалын хувьд тийм ч тогтвортой биш байна. Тэгэхээр Монгол Улс хямралд өртөх бүсэд нэвтэрсэн гэж үзвэл өссөөр буй өрийн хэмжээгээ сайтар хянаж хэрэгтэй.

-Өнөөгийн өрийн хэмжээг авч үзвэл манай улс хяналт тогтоож чадах болов уу. Эсвэл Монгол Улс Грек, Аргентинийн араас орж мэдэхээр байна уу?

-Грек, Аргентинийн араас шууд орохгүй байх л даа. Хэдий тийм ч цаг алдах тусам байдал улам хүндрэх нь ойлгомжтой. Хасах динамик руу орсон л бол түүнийг залруулах хэцүү болно. Засгийн газрууд хэтэрхий удаан хүлээгээд байдаг. Тэд асуудлыг огоорч явсаар байдал хэтэрхий хүндэрсний

дараа арга хэмжээ авч эхэлдэг. Зах зээл үймээд ирвэл итгэлээ алдана. Тийм ч учраас эрсдэлийн зэрэг тогтоох хэрэгтэй. Монгол Улсын хувьд дампуурлаа зарлах хэмжээнд очих эсвэл тэр зүгт явах хүсэлгүй байгаа нь мэдээж. Тэгэхээр хөрөнгө оруулагчдын итгэлийг олох хууль, дүрэм бий болгох хэрэгтэй. Гэхдээ хамгийн чухал нь тэдгээр хуулиа чандлан мөрдөх. Ингэж байж хөрөнгө оруулагчдын итгэлийг алхам алхмаар олж авна. Хууль байгаад хэрэгжихгүй бол нэмэргүй. Нэр хүндийг асар их хөдөлмөрийн үр дүнд олж авдаг ч алдахаа хүрвэл тун амархан.

-Монголын Засгийн газар хаа хүрээд аюул нүүрлэлээ, буцах хэрэгтэй гэх ёстой юм бол?

-Одоогийн замналаасаа буцах цаг хэдийнэ ирчихсэн байна. Валютын нөөц багассан, өрийн эргэн төлөлт ойртсон, мөнгөн тэмдэгтийн ханш суларч байгаа нь валютын өрөө эргэн төлөхөд хүндрэл учруулна. Тэгэхээр төсөв, мөнгөний бодлогоо чангаруулах хэрэгтэй болж байна. Үүний зэрэгцээ илүүдэл зардлаа танах шаардлагатай. Түүнчлэн үүсээд буй нөхцөл байдалд хэнээс, хаанаас тусламж авах боломжтой тухайгаа бодох хэрэгтэй.

-Грек евро бүсийн нэг хэсэг биш гэж бодъё. Ийм өнцөгөөс авч үзвэл Монгол дараагийн Грек үү?

-Грект бүсийн нэг орон гэдэг утгаараа олон давуу тал байсан. Тэр хэмжээгээрээ ч өрийн ийм өндөр үзүүлэлттэй болсон. Тус улс Европын холбооны орон байгаагүй байсан бол тэр их хэмжээний өр хуримтлуулахгүй байсан шүү дээ. Монголын тухайд гэвэл, Грек шиг өрийн хямралд өртсөн нөхцлүүдтэй нүүр тулж байгаа нь үнэн. Жишээлбэл, санхүүгийн салбарын сул хөгжил, ашигт малтмалд суурилсан эдийн засагтай гэх мэт.

Үүн дээр нэмээд мөнгөн валютын хямралд өртөх эрсдэлтэй. Монгол дараагийн Грек гэж хэлэхгүй ч Грекийн адил өртөмтгий байна. Хямрал дангаараа ирдэггүй. Нэг нь нөгөөгөө бий болгож байдаг. Яг л нэг тийшээ харж байхад нөгөө талаас цохих мэт. Банкны салбар хамгийн хүнд байна гээд бодож байхад валютын эсвэл өрийн хямрал угтаж байх жишээтэй. Иймд Грек шиг болохгүйн тулд тэдний алдаанаас харж, суралцах хэрэгтэй. ■

ГАРЦ

Өрийн хавхнаас өндийх боломж

Д.Жаргалсайхан /Нийтлэлч/

Уул уурхайн мөчлөг өсөх үед алсын хараатай улс орнууд хөрөнгө мөнгө хуримтлуулж нөөцөлдөг. Орос, Казахстан жишээ нь тэгж чадсан учир мөчлөг унах цагт тохиодог эдийн засгийн хямралыг өлхөн давж байлаа. Манайх болохоор өсөх үед нь хуримтлуулах байтугай өрөнд баригдаж орхив. Уул уурхайгаасаа маш их орлого орохтой уралдаад маш их өр тавиад байсан нь Монгол төрийн удирдлагын бас нэг “гайхамшиг”. Орлого нь улс төрчдөд, өр нь иргэдэд ногдов.

Монголын төр, засгийн удирдлага эдийн засгийн бялуугаа том болгохын оронд өөрийн зүсмээ томруулахыг хичээснээр сав л хийвэл төр засгаа сольж, эрх мэдэл булаацалдсаар дахин нэг зуныг барав. Эдийн засаг энэ онд гурван хувь өсөхөөр байгаа ч гадаад өрийн хүүгээс бараг хоёр дахин хоцорч, улс орон өрийн хавханд орчихоод байгаа тухай би өмнөх нийтлэлдээ бичсэн.

Өнөөдөр Монгол Улсын гадаад өр Төв банкны Хятадтай байгуулсан солилцоо /SWOP/, Хөгжлийн банкны өмчит компаниудын өрийг хамруулан тооцвол, төр засгийнхны хэлээд буй шиг эдийн засгийнхаа 55 хувь биш, бүр 90 хувьтай тэнцэх юм аа, Уул уурхайн хямрал хальсаар барилга, үндсэн хөрөнгийн салбарыг хамарч, барьсан барилгууд нь борлогдохгүй, зарсан сууцны зээлийн эргэн төлөлт муудан, чанаргүй зээл нь өссөн банкны салбарыг ч сулруулах боллоо.

Монголын төр засаг өрийг өрөөр төлөх болж, дотоодын зах зээл дээрээс ч хамгийн өндөр хүүтэй хөрөнгө босгож байгаа нь засгийн газрын санхүүгийн эрсдэлийг хөөргөдөг, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг бууруулан, Засгийн газрын бондыг зарах хүслийг нь дэврээж байна.

Монголын Засгийн газар эдүгээ эх эцгийнхээ зээлийн картыг дур зоргоороо зарцуулж найр хийж, үнэтэй хөрөнгө зээлэн авч дураараа дургиж байгаа эрх танхил хүүхэд шиг болжээ.

Монгол Улс гадаад өрийн хавхнаас гарахад хэцүү, гарахгүй удвал улам хэцүү болоод байна. Улс орон маань явал энэ хавхнаас гарах вэ?

Анхны алхам

Байхгүй мөнгөөр баахан юм худалдаж аваад эцгээ зээлийн өрөнд оруулаад байгаа энэ хүүхдээс хамгийн түрүүнд кредит картаа салгаж авах ёстой. Нэмж зээл авахаа зогсоохыг эрүүл саруул бодолтой иргэд Монголын Засгийн газрыг шаардаж байна. Ер нь Засгийн газрын гадаад өрийн удирдлагыг ил тод болгож, зарцуулалтыг хянахад иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, өрийн хөрөнгийг улс төрчидтэй холбоотой компаниудад олгохыг тас хорих, тухай бүр нь нягтлаж цаг болжээ.

Дараагийн алхам

Энэ оны төсөвт яаралтай, дахин тодотгол хийж урсгал зардлаа хэвээр байлгах, нийгмийн зөвхөн эмзэг хэсэгт төвлөрч, төрийн үйлчилгээний ажилчдын цалинг хамгийн түрүүнд олгож байх горимд шилжих журам тогтоож төсвийн алдагдлыг ДНБ-ийхээ хоёр хувиас хэтрүүлэхгүй байлгах хуулийг сэргээх шаардлагатай байна. Төсвийн хөрөнгө оруулалтыг дахин эрэмбэлж, өгөөж нь урт хугацаатай хөрөнгө оруулалтыг багасгахаас өөр сонголт алга болжээ. Ирэх оны төсвийг батлахдаа ч энэ чиглэлийг барьж, төр засаг өөртөө шинээр үндсэн хөрөнгө авахаа зогсоож, гадаад айлчлалын зардлаа эрс багасгах цаг болжээ.

Гуравдугаар алхам

Монголбанкны хараат бус байдлыг сэргээж, орон сууцны зээлийн болон үнэ тогтворжуулах хөтөлбөрийн тэнцлийг байх ёстой, Засгийн газрын тэнцэл яаралтай шилжүүлэх ажил оройтож байна. Монголбанк Засгийн газрын шахалтаар төсвийн алдагдлаас үүсэлтэй алдагдлыг нөхөх бодлогыг хэтрүүлэн хичээж, улмаар ханшийн уналтыг хазаарлахын тулд валютын нөөцөө шавхаад байна. Хэрэв СВОП-ын өрийг тооцвол, Төв банканд валютын

нөөц үлдсэнгүй.

Монголбанк өөрөө зээл өгч буй хууль бус үйлдлийг зогсоож, цөөхөн хэдэн компанид олгосон зээлийг нь бас Засгийн газрын тэнцэлд авч эргэн төлөлтийг Сангийн яам хянаж ёстой.

Дөрөвдүгээр алхам

Ерөнхий сайд Ч.Сайханбилэг зургаан сарын өмнө УИХ-аар батлуулсан макро эдийн засгийг тогтворжуулах хөтөлбөрөө шуурхай хэрэгжүүлэх, түүний дотор том төслүүдээ хөдөлгөх, юуны өмнө талцуулсан Таван Толгойн ажлыг урагшлуулахын тулд “Эрдэнэс Таван Толгой”, “Энержи ресурс” компаниудын хамтарсан консорциум болгох, стратегийн хөрөнгө оруулагч шалгаруулж, гэрээ байгуулан, дэд бүтэц, барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх шаардлагатай байна.

Тавдугаар алхам

Авилгачдыг өршөөх гэхээсээ илүү нийтийн хөрөнгөнд учруулсан хохирлыг нь төлүүлж, ажилчдын цалинг тавих, нийгмийн зайлшгүй зардлаа нөхөх нь шударга ёсонд нийцнэ. Төлбөрөө хийсэн авилгачдыг төрд ажиллах эрхийг нь бүх насаар нь хасчихаад “өршөөхгүй” бол эргэж буцан “зөвлөгөө” өгчих гээд амьтан хүний толгой эргүүлж, цаг, хөрөнгө алдуулаад салахгүй шүү дээ.

Мөн төрийн өмч нэртэй намын өмчийн үйлдвэрийн газруудыг хувьцаат компани болгон Хөрөнгийн биржээр дамжуулан худалдах замаар үргүй зардал, татаасыг арилгаж, авлигын томоохон үүрийг цэгцлэх цаг болоогүй гэж үү.

Монгол Улсыг өрийн хавхнаас өндийх, цаашдаа эдийн засгаа уул уурхайн мөчлөгийн хамаарлаас хамгаалахын тулд төр засаг наад зах нь эдгээр таван алхмыг хэрэгжүүлэхийг цаг хугацаа шаардаж байна.

Тэгээд эхэлбэл гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад итгэл төрүүлж, эдийн засагт ихээхэн шаардлагатай байгаа хөрөнгө босгоход Монголын арилжааны банкууд, санхүү бизнесийн байгууллагуудад хямдхан болох юм. ■



INVEST MONGOLIA

Тогтвортой байгаа ч туйлдаж магадгүй

А.Бүрэнжаргал

Санхүүгийн хувьд бөхийлгүй байр сууриа хадгалж буй тулгуур салбар нь арилжааны банкууд. Өнөөдөр Монголын эдийн засаг хүндрэлтэй, бэлэн мөнгөний эргэлт бага байгаа ч банкууд өөрийн хөрөнгөөр эрсдэлийн өмнө цалгардахааргүй байгааг Монголын Банкны холбооны ерөнхийлөгч О.Орхон хэлэв. Энэхүү байдлыг хэрхэн хадгалж тогтвортой байж цаашид ямар арга хэмжээ авах вэ? Яг л энэ асуултын хариулыг дөрвөн том банкны захирал Төвбанкны төлөөллийн хамт сууж байгаад олон нийтийн өмнө гарцаа хэлэлцсэн. Зөвхөн энэ талаар ч гэлтгүй эдийн засгийн нөхцөл байдал, томоохон төслүүдийн явц, хөрөнгө оруулалттай холбоотой асуудлыг хэлэлцдэг "Хөрөнгө оруулалтын чуулга уулзалт 2015" өнгөрсөн сард амжилттай зохион байгуулагдсан.

"Фронтинер" компаниас ес дэх жилдээ зохион байгуулж буй тус чуулганд гадаад, дотоодын 500 орчим төлөөлөгч оролцсон. Эрчим хүчний сайд асан Д.Зоригт "Монгол олон улсын анхаарлаас гараагүй байна. Эдийн засаг уруудаж байна гээд бид царгалсан дүр төрх үзүүлж буй. Гадныхан биднийг сонирхож хамтран ажиллах боломжийг эрэлхийлсээр байгааг харлаа" гэсэн юм. Хуралдааны хэсэг бүрээс хөрөнгө оруулагчид төдийгүй монголчууд тодорхой ойлголттой болж нэгдсэн мэдээлэл авч байсныг энд дурьдах хэрэгтэй. Үүнээс онцолж санхүүгийн салбарын үйл явц, эрсдэлийн өмнө баримтлах бодлогоо хэлэлцсэн нь хамгийн авууштай байлаа.

Төсөв, мөнгө, хөрөнгө оруулалт, иргэдийн амьжиргааны түвшин энэ бүгд өөрөө нийгмийн нэг илэрхийлэл болж

банкны салбараар хэмжигдэх нөхцөл бүрдэх нь бий. Энгийн жишээ авахад амьжиргааны түвшнээс доогуур амьдралтай иргэд орон сууцтай болж чадахгүй өдийг хүрлээ. Энэ байдлыг халхлахаар ипотекийн зээлийн 10 хувийг иргэд төлж үлдсэн 20 хувийг төрөөс батлан даах асуудлыг хөндсөн. Энэ талаар Монголын Банкуудын холбооны ерөнхийлөгч О.Орхон "30 хувийн урьдчилгаа төлөх чадваргүй хүмүүст энэ бас нэг боломж. Гэхдээ үлдсэн 90 хувийг цалингийн орлогоосоо төлөх нөхцөл үүсч байгаа юм. Түүнчлэн эргэн төлөлтийн хугацааг 20-30 жил болгосон. Сар бүр төлөх мөнгө нь буурч байгаа мэт боловч үргэлжлүүлэн 10 жил зээлээ хүүтэй нь төлнө гэсэн үг. Энэ нь нэг талаас хямралын үед иргэдийг орон сууцтай болгох талаас нь авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ боловч эдийн засгийн утгаараа иргэд болон банкуудад зээлийн дарамт нэмэгдэж байна" гэсэн юм.

Банкуудад гэсэн учир нь эдийн засгийн нөхцөл сайнгүй үед чанаргүй зээлийн хэмжээ ихсэх хандлага байгаатай холбоотой. Энэ оны эхний улирлын байдлаар нийт 72.4 мянган зээлдэгчид 3.1 их наяд төгрөгийн зээл олгожээ. Харин өнгөрсөн зургаадугаар сарын байдлаар хугацаа хэтэрсэн ипотекийн зээл 1.8 хувь, чанаргүй зээл 0.5 хувь байгаа талаар банкны салбарын судалгаанаас харж болно. Үүнтэй холбоотой нэмж эрсдэлтэй зээл гаргахгүй байх талаар арга хэмжээ авч буй аж. Санхүүгийн зарим салбарын хувьд зээлээ зогсоосон гэх мэдээллийг ч өгч байлаа. Эдийн засгийн сайнгүй байдал гэнэт үүссэн асуудал биш. Харин



2012 оноос эхэлсэн эрсдэлээ тооцоолох боломж олгож буй хямрал гэж эдийн засагчид үзэж байна. Түүнчлэн эдийн засгийн сайнгүй үе болох 2009 онд чанаргүй зээлийн хэмжээ 17 хувьд хүрч байсан. Үүгээр ч зогсохгүй зарим банк хаалгаа барьсантай харьцуулахад одоогийн нөхцөл байдлаа муутгаж аюулын харанга дэлдэхээс илүү ямар арга хэмжээ авч эрсдэлээ тооцоолох хэрэгтэй вэ гэдэгт анхаарч ажиллах хэрэгтэй гэж үзсэн. Энэ гаргалгааг тайлбарлахдаа өөрийн хөрөнгөө баталгаажуулж муу зээлийн эсрэг сан байгуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж буй гэнэ. Түүнчлэн топ дөрвөн банкны өөрийн хөрөнгийн хэмжээ 16-17 хувь байгаа нь сайн үзүүлэлт гэдгийг Банкуудын холбооны ерөнхийлөгч О.Орхон дурьдсан.

Эдийн засгийн өсөлтөө дагаад банкны салбарын өсөлт ч зогсож байгаа талаар Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газрын захирал Д.Болдбаатар “Оны төгсгөлд муу зээлийн хэмжээ 10 хувьд хүрэх боловуу гэсэн тооцоолол байна. Гэхдээ манай банкуудын өөрийн хөрөнгө хангалттай байна. Энэ онд ерөнхийдөө амь зогоосон, аргацаасан байдалтай өнгөрөх байх. Ирэх жилд ч олигтой өсөлт ажиглагдахгүй болов уу” гэлээ. Мөн тэрбээр “Төсвийн орлого тасарч байгаа нь орлогын буруу зарцуулалттай холбоотой. Өмнөх жилүүдэд төсвийн орлого нэмэгдэхийн хэрээр бид орлогоо хуримтлуулах биш зардлаа нэмж ирсэн. Орлого тасалдахаар зардлаа танахаас өөр гарцгүй болсон. Бидэнд том сургамж болж байна” хэмээн онцолсон. Тус хурлыг зохион байгуулагч “Фронтинер” компанийн захирал Маса Игата “Өр дээр өр нэмэх нь онцгүй хэдий ч хөрөнгө оруулагчдад бодит байдлаа танилцуулж тусламж авахаас өөр арга үгүй. Мэдээж мөнгөний эх үүсвэргүй бол Монголын томоохон банкууд одоохондоо тогтвортой байгаа ч туйлдах нөхцөл бүрдэх эрсдэл бий. Тиймээс хүссэн, хүсээгүй өрийн

удирдлагыг аль болох уян хатнаар зохицуулах хэрэгтэй болж буй” гэлээ.

Норихико Като /ХААН банкны гүйцэтгэх захирал/:

Арилжааны банкуудын хувьд хугацаа хэтэрсэн зээл их байна. Тэр тусмаа барилгын салбар, найман хувийн зээлтэй холбоотой хугацаа хэтрэлт голлож байна. Эдийн засгийн уналтын үе жил гаран үргэлжиллээ. Хугацаа хэтэрсэн зээл, банкуудын хөрөнгийн өсөлтийн хурд үүнээс ч илүү хурдтай муудах хандлага байх байсан. Харьцангуй сайн арга хэмжээ авч буй тулдаа үзүүлэлтүүд өдий зэрэгтэй байна. Энэ жилийн хувьд банкуудын хувьд өсөлт байхгүй нэгэн жигд хэмжээнд явж буй. Мөн Монголбанкны зүгээс ам.доллараар зээл олгохгүй байхыг зөвлөсөн нь миний бодлоор цаг үеэ олсон сайн бодлого гэж харж байна.

Л.Оюун-Эрдэнэ /Голомт банкны гүйцэтгэх захирал/:

Эрсдэлүүд их байгаа ч бид ямар боломжууд байна вэ гэдгийг эрж, хайх хэрэгтэй. Банкны салбар дахь нийт зээл нь ДНБ-тэй хэрхэн харьцаж буй талаас нь авч үзвэл манай улсын хувьд 50 хувийг эзэлж байна. Хөгжингүй эдийн засагтай ихэнх оронд энэ үзүүлэлт дунджаар 150 хувьтай тэнцдэг. Тэгэхээр бид одоо байгаа энэхүү харьцааг авч үзэх боломж байна. Монголын банкууд цаашид өсч хөгжиж, зээл олгох боломж бий гэж харж байна. Хугацаа хэтэрсэн зээл, одоо тулгамдаж буй асуудлын хувьд зарим нэг салбарт жишээлбэл, уул уурхай, барилга, үйлдвэрлэл, худалдааны салбар ажиглагдаж буй зүйлс бий.

Эдгээр салбар нь гадаад валютаас хараат байгаа учраас зээлийн хүндрэлтэй байна гэсэн үг. Тиймээс цаашид ямар боломж бий вэ гэдгийг сайн бодож үзэх ёстой. Мөн бусад салбарт зээл олгох. Хөдөө аж ахуй, жижиг дунд бизнесүүд,

импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжих бодлого баримталж болох юм.

М.Болд /ХАС банкны гүйцэтгэх захирал/:

Бүх салбарт сайнгүй зүйл болоод байгаа юм биш. Банкны салбарт ажиглагдаж буй эерэг зүйлийн тухай хэлэх хэрэгтэй. Монголын арилжааны банкууд хоёр жилийн хугацаанд сайн бэлтгэсний дагуу "Тогтвортой санхүүжилтийн гэрээ"-нд гарын үсэг зурсан. Ингэснээр тогтвортой санхүүжилтийн зарчмуудыг зээл олгоходоо хэрэгжүүлдэг болсон. Банкууд хамтарч энэ гэрээг байгуулсан нь харьцангуй шинэлэг санаачлага байсан юм.

Олон улсад ч арилжааны банкууд энэхүү санаачлагыг гаргаж чаддаггүй. Тогтвортой санхүүжилт гэдэг нь байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллөөр нь тухайн төслийг үнэлээд зээл олгох эсэхээ шийддэг процесс. Энэ жилээс эхлээд зээл хүсэгч компаниудад байгаль орчин болон нийгэмд ямар нөлөө үзүүлэх вэ гэдэг талаас нь шалгуур тавьдаг болсон. Уул

хугацаа хэтэрсэн зээлийг нэмэгдүүлэхгүй байх тал дээр голлон анхаарах хэрэгтэй. Монгол Улс хямралын доод түвшинд хүрсэн эсэхийг олон үзүүлэлтээр хэмжинэ. Үүний нэг бол хугацаа хэтэрсэн зээлийн үзүүлэлт.

Түүнчлэн зах зээл хумигдаж буй эсэх гол нөлөө үзүүлнэ. Миний бодлоор Монголын банкны салбарт эерэг үзүүлэлтүүд гарах боломж бий гэж харж байна. Гол нь тогтвортой өсөлтийн хангах. Түүнчлэн бодит байдал дээр ямар боломжууд байгааг олж харснаар нөхцөл байдал сайнаар эргэх боломж байна.

Д.Болдбаатар /Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газрын захирал/:

Монголын санхүүгийн салбар томрох хэрэгтэй гэдэгтэй санал нэг байна. Хамгийн чухал инновацийн чанартай хэлэх зүйл бол хөдлөх хөрөнгийг барьцаа болгон ашиглах боломж бүхий шинэ хууль гарсан. Ингэснээр банкууд төдийгүй бизнес эрхлэгчдэд багагүй боломж нээгдсэн.



Д.Болдбаатар: Банкуудын байр суурь бэхжиж байна

уурхайн компаниудын хувьд дээрх шалгуурт нэлээн их зардлыг төсөвлөх хэрэгтэй байдаг. Нийгэмд үзүүлэх нөлөөллийн хувьд хамгийн наад зах нь ажилчдынхаа нийгмийн даатгалыг төлөх мөнгө төсөвтөө оруулсан эсэхийг шалгах юм.

Грэмэ Кноуд /Мүүдис агентлагийн хөрөнгө оруулалт хариуцсан захирал/:

Монголын хувьд хөгжиж буй бусад оронтой харьцуулахад Засгийн газрын үзүүлэлт "B2" зэрэглэлтэй байгаа. Азийн хөгжиж буй бусад оронтой харьцуулахад харьцангуй тогтвортой байна. Тулгамдаж буй эрсдэлүүдийн хувьд хугацаа хэтэрсэн зээлийн үзүүлэлтийг илүү тодорхой болгох хэрэгтэй. Энэ нь чансаа тодорхойлох банкуудад итгэх итгэлийг хэмжих хэмжүүр юм. Одоогийн нөхцөл байдлаас харахад

Нөгөө талаас бизнесээ өргөжүүлэх боломж нээгдэж буй. Түүнчлэн арилжааны банкуудын хувьд хөрөнгө мөнгөний дутагдал байхгүй байгаа нь сайн үзүүлэлт.

Энэ нь одоо тулгамдаж буй асуудлаа шийдвэрлэх боломж байна гэж харж байна. Монголбанкны хувьд цаашид илүү бүтээлч байдлаар шинэ өөрчлөлтүүдийг хийх, санхүүгийн салбарыг төрөлжүүлэх зэрэг ажлыг үргэлжлүүлнэ. Мөн хугацаа хэтэрсэн зээлийг нэмэгдүүлэхгүй байх тал дээр гол анхаарлаа хандуулна. Эцэст нь хэлэхэд арилжааны банкуудын байр суурь бэхжиж байна. Өөрийн хөрөнгийн хэмжээ сайжирч байна. Бидний тавьсан шаардлагаас ч илүү үзүүлэлт ажиглагдаж байна. ■



Бүрхэг ирээдүйн бүүдгэр таамаг

Г.Орхон

Олон улсын зах зээл дээрх зэсийн ханш “зэвэрлээ”. Учир нь ойрын хугацаанд тус таваарын ханш сэргэхгүй. Цаашид үнэ буурах хандлага үргэлжлэх бөгөөд 2016 онд ханш доод цэгтээ хүрнэ гэх.

Олон улсын шинжээчид ийн дүгнэсэн бөгөөд тэдний зарим нь нэг тонн зэс 5000 ам.доллар байх үе дахин таван жил үргэлжлэх гэнэ. Хэдий дэлхийн зэсийн хэрэглээ буурсаар буй ч ирэх таван жилийн хугацаанд өнөөгийн эрэлтээс гурван сая тонн илүү зэс хэрэглэх аж. Энэ нь эрэлт буурч, нийлүүлэлтэд өөрчлөлт гарна гэсэн үг. Тухайлбал, өмнөд Африкт ирэх онд зэсийн шинэ орд ашиглалтад орно гэж байгаа. Гэхдээ л зах зээлийн жамаар эцсийн дүндээ зэсийн ханш эргэн унах нь.

Хэрэв 2018, 2019 оноос эрэлт нэмэгдвэл зэсийн үнэ өснө. Гэхдээ өнгөрсөн оны 6500 ам.долларын ханшид 2019 оноос л дүйж очихыг Хятад дахь “CRU” группын гүйцэтгэх захирал Жонн Жонсон энэ жилийн “Инвест Монголиа” чуулганы үеэр ярьсан. Шинжээчдын таамаг биеллээ олж байна уу гэлтэй саяхан зэсийн томоохон хэрэглэгч БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индекс доошилсноос үүдэн уг таваарын үнэ гурван өдөр дараалан хямдрал. Ханшийн уналтад мөн тус улсын аж үйлдвэрлэл буурсан нь нөлөөлжээ. Түүнчлэн есдүгээр сарын 16-ны байдлаар Лондонгийн Металлын биржид гурван сарын дараа худалдан авах зэсийн суурь үнэ суларч, нэг тонн нь 5270 ам.доллартай тэнцэв. Мөн ирэх арванхоёрдугаар сард нийлүүлэх


зэсийн үнэ 0.4 хувиар буурч фунт нь 2.3970 ам.доллартай дүйхээр байгаа бол Шанхайн биржид арваннэгдүгээр сард худалдан авах ханшийг 0.8 хувиар бууруулж тооцжээ.

Монголын хувьд ойрын хугацаанд энэ зах зээлээс олох орлого буурах дүр зураг ажиглагдаж буй. Үүнийг Монгол Улсаас Хятадын зах зээлд нийлүүлдэг 10 гол түүхий эдийн нийлүүлэлтийн индекс буурснаас харж болно. Гол асуудал нь тоо хэмжээ буурсанд бус үнэ доошилсонд байгаад юм. Нөгөө талаас Хятадын эдийн засгийн удаашрал ашигт малтмалын зах зээл дээр томоохон өөрчлөлт бий болгосныг CRU группын гүйцэтгэх захирал Жонн Жонсон мөн хэлсэн. Тэрбээр “Өнгөрсөн зургаан сарын хугацаанд зэс, нүүрс тэргүүтэй

10 гол бүтээгдэхүүний үнэ 40 хувиар буурсан байна. Зах зээл дээр эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэртэй холбоотой гарч байгаа гол өөрчлөлт бол үнийн бууралт. Тэгэхээр тухайн салбарт нийлүүлэлт талаасаа бууралт байвал энэ нь дараагийн тэнцвэрт нөлөөлнө. Одоогоор ийм зүйл байхгүй байна” хэмээв.

Хятадын өнгөрсөн гурван жилийн нэгээс долдугаар сарын импортын статистикаас үзвэл 2015 онд таваарын топ 10 импортоос 150 тэрбум ам.доллар “арчигджээ”. Энэ нь нийтдээ Монголын ДНБ-ий хэмжээг 12 дахин өсгөсөнтэй тэнцэхүйц бууралт аж. Энэ байдал ашигт малтмал экспортолдог олон оронд нөлөөлсөн байжээ. Нэг талаас зэсийн нийлүүлэлтийн хэмжээ

2015 онд Хятадын таваарын топ 10 импортоос 150 тэрбум ам.доллар арчигджээ, энэ нь нийтдээ Монголын ДНБ-ий хэмжээг 12 дахин өсгөсөнтэй тэнцэхүйц бууралт юм.



Эх сурвалж: CRU

өндөр байсан учир үнэ буурсан. Харин өдгөө ашигт малтмалын зах зээл эрэлт багатай байна. Хятадын Засгийн газар ирэх таван жилд нийлүүлэлтэд ихэд анхаарч “мэдрэмжтэй” бодлого барих гэнэ. Мөн тус улс татварын орчин, мөнгөний бодлогодоо өөрчлөлт хийж байна. Хятадын хувьд зардлын өсөлт нэлээн байгааг судлаачид тэмдэглэжээ.


Өөрөөр хэлбэл, ашигт малтмалын зах зээл дээр ажиллаж буй Хятадын компаниуд зардал өндөртэй байдаг аж. “CRU”-ийн судлаачдын дүгнэж буйгаар, ялангуяа 2016 онд зэс, нүүрс, төмрийн хүдэр тэргүүтэй тавааруудын үнэ буурч, зардал өсөх нь.

Ийнхүү үнийн бууралтаас шалтгаалж ойрын хугацаанд энэ зах зээлээс олох

Монгол Улсын орлого буурахыг олон улсын шинжээчид таамаглаж байна. Өнгөрсөн оны байдлаар Монголын экспортын нийт орлогын 70 гаруй хувь нь дээрх бүтээгдэхүүнүүдээс орсон орлого байж. Жонн Жонсон “Ханшийн сулралаас үүдэн энэ онд Монголд орж ирэх байсан орлого 800 сая ам.доллараар буурна. Энэ нь өмнөх үетэй харьцуулахад нэг тэрбум ам.долларын алдагдал хүлээнэ гэсэн үг” гэв.

Байдал цаашид хэрхэн нь үнийн хэтийн төлөвөөс шалтгаалах нь. Хэрэв олборлолтод тодорхой өөрчлөлт гарахгүй бол ханш 2019 он хүртэл өсөхгүй, одоогийн байдлаар үргэлжлэн явж таарна. Гэхдээ Монгол Улсын экспортлох бүтээгдэхүүний хэмжээнээс шалтгаалж, 2019 оноос хойш орлого өсөх магадлал бийг шинжээчид онцолж буй. Гэвч үнэ өсөхгүй тул олборлолтоо нэмэгдүүлж байж илүү ашиг олох боломж бүрдэх аж. ■

2015 оны эрэлтийн хэтийн төлөв буурсан бөгөөд ирэх таван жилийн Нийлмэл жилийн өсөлт дөнгөж 2.9 хувь байна



Эх сурвалж: CRU

ЗҮГ ЧИГ

Эрэлт дагаж хувьсах үл хөдлөх

Г.Түшээ

Улсынхаа нийслэлд зургаан жилийн дараа эгэн ирсэн ээж минь “Энэ өндөр барилгуудын дэргэд нь зогсоод оройг нь харах гэхээр толгой эргээд байх юм. Улаанбаатарт үзээгүй барилга зөндөө болжээ” гэв. Мөн бидний хэлж заншсан багшийн дээдийн орчмыг “Яасан их өөрчлөгдөө вэ” гэсээр ижий минь нийслэл хотын шинэ төрхөд нүдээ дагасан нь саяхан.

“Сүхбаатарын” гэх нэршлээ Чингисийн хэмээн “өөрчилсэн” Улаанбаатарын төв талбайд хөл тавилгүй удсан олны



мэлмийд эгнээ нэмж, зүсээ өөрчилсөн барилгууд шил дараалан сүндэрлэх болсон. Хаашаа л харна цамхаг нэртэй шилэн барилгууд. Үүний хажуугаар “Zara”, “Gucci”, “D&G” тэргүүтэй дэлхийн брэндүүд манай нийслэлд салбар дэлгүүрээ нээсээр.

Өнгөц харвал Монгол Улсын үл хөдлөх хөрөнгийн салбарын хөгжил урагш явна гэж болмоор. Гэвч орчин үеийн шаардлага, стандартад нийцсэн авто машины зогсоол, барилгуудын өнгө үзэмжийн хослол, гадна талбайн

тохижилт, хэмнэлттэй цахилгааны эх үүсвэрийн шийдэл гэх мэт асуудлыг хэрхэн авч үзсэн байдлаар нь дүгнэвэл өнөөгийн ахиц дэвшлийг чамлах хүн цөөнгүй.

Чухам эл салбар хаана яваа, хаашаа чиглэж буйг энэ жилийн “Инвест Монголиа” чуулган онцлов. Улсын эдийн засаг хүнд байгаа ч компаниуд барилга барихаас гадна зарим төсөлд хөрөнгө оруулах сонирхолтой байгаа гэнэ. Учир нь үл хөдлөхийн салбарт хэрэгжиж буй төслүүдийн зарим нь тухайлбал,

хотын төв, Зайсан орчимд байрлалтай үл хөдлөх хөрөнгө багагүй эрэлттэй байх аж. Мөн оффисийн зориулалттай барилгын эрэлт давамгайлж байна. Уг эрэлтийг даган оффисийн барилгын тоо нэмэгдэж, үнэ буурсан тул урт хугацааны зээл авахад тохиромжтой үе гэдгийг шинжээчид хэлж байна. Харин компаниуд хийгээд хөрөнгө оруулагчид өнөөгийн нөхцөлд тогтвортой үлдэхийн тулд зах зээлд юу хэрэгтэй түүнийг нийлүүлэх гэнэ.

Бүтээн байгуулалтынхан эрэлт, нийлүүлэлтийн “жороор” явна гэж байгаа ч өдгөө зах зээл дээр 30 гаруй мянган орон сууц эзнээ хүлээж буй. Барилгын тоо эрэлтээс давсан тохиолдолд банк хэрхэх нь олон хүнд сонин. Засгийн газрын найман хувийн хүүтэй зээлийн хөтөлбөр арилжааны банкуудын олгосон зээлийн дийлэнхийг ипотекийн зээл бүрдүүлж байгаа зэрэг тодорхой өөрчлөлт авч ирсэн. 2010 онд 16 мянган хүн орон сууцны зээлтэй байсан бол өдгөө 60 гаруй мянгад хүрсэн байгаа юм. Үүнээс

хугацаа хэтэрсэн зээл 2.3 хувьтай, муу зээл нэг хувьд хүрэхгүй аж. ХААН банкны гүйцэтгэх захирал Норихико Катогийн хэлснээр хугацаа хэтэрсэн зээл банкныханд тийм ч хүнд асуудал биш байна. Гол нь иргэдийн орлогын түвшин зээл авахад хүрэлцэхгүй байгаа, Засгийн газрын баталгаа бэлэн мөнгө биш зэрэг нь чухалчлах асуудал гэлээ. Тодруулбал, ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөр болох 30 хувийн зөвхөн 20 хувьд Засгаас батлан даалт гаргаж өгч байгаа юм. Гэвч уг шийдвэрийг холбогдох албаныхан эцэслээгүй байна.

Иргэдийн хувьд бага талбайтай орон сууц худалдан авах сонирхолтой байдаг нь тэдний санхүүгийн чадамжтай ч холбоотой орших аж. Норихико Като “Ер нь эрэлт, нийлүүлэлтийн талаас энэ зах зээл удаашрах хандлагатай байна. Гэсэн ч орон сууцны эрэлт хэрэгцээ гарч ирсээр байх болно” хэмээв. Нэг жишээ дурьдахад, Улаанбаатар хотын 1.4 сая иргэний 60 гаруй хувийг орон сууцжуулах шаардлага бий. Ингэхийн

тулд ирэх таван жилд 200 мянган айлын орон сууцыг шинээр барих хэрэгтэй. Тус салбарын хөрөнгө оруулалт өдгөө дотоодын нийт бүтээгдэхүүний 7.8 хувьтай тэнцэж буйг “Asia Pacific Investment Partner” компанийн захирал Б.Цэндсүрэн ярилаа.

Тэрбээр ирэх хоёр жилд Монголд 10 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирнэ гэж таамаглаж байна. Учир нь үл хөдлөх хөрөнгийн салбарын хөрөнгө оруулалт богино хугацаанд нэмэгдэж, мөн хугацаанд хөгжсөн гэх. Мөн улсын гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх жилүүдээс буурч байгаа ч үл хөдлөхийн салбарт хөрөнгө оруулалт хийхэд тохиромжтой цаг гэдгийг салбарынхан онцолж байна.

Ийнхүү Монголын үл хөдлөхийн салбарт иргэдийн санхүүгийн чадамжийг харгалзахад нийлүүлэлт илүү мэт харагдаж байгаа ч эрэлт өдгөө байсаар байна. Цаашид өөрчлөлтүүд гарна гэдэгт салбарынхан итгэлтэй сууна. ■

ЯРИЛЦЛАГА

Зах зээл юу хүсэж байна түүнийг л үйлдвэрлэ

А.Бүрэнжаргал

“Ханган нийлүүлэгчдийн хөгжил чанарын төв” ТББ-ийн гүйцэтгэх захирал Б.Төгөлдөртэй ярилцлаа. Тус байгууллага нь хувийн хэвшлийн төлөөллийн санаачлагаар АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн “Бизнесийн дэмжих санаачлага” төслийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан, бизнес хөгжлийн хүрээнд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилготой юм.



-Байгууллагын үндсэн үйл ажиллагаа болон энэ чиглэлд ажиллах болсон шалтгаан юу вэ?

-Ханган нийлүүлэгчдийн хөгжил чанарын төв нь анх 2012 оны арванхоёрдугаар сард байгуулагдсан.

Тухайн үед хувиараа үйл ажиллагаа явуулдаг хүмүүстэй уулзаад тулгараад байгаа гол асуудал нь юу вэ гэдгийг судалсан. Үүний үр дүнд хувийн хэвшил төдийгүй томоохон компаниуд нэг зүйл дээр санал нэгдэж байсан. Тэдний

хэлж буйгаар бид бизнес хийгээд тодорхой түвшинд хүрчихсэн. Гэхдээ нэг цэг дээр ирээд зогсчихоод байна. Цааш хөгжихийн тулд бидэнд чанарын удирдлага гэдэг зүйлийн талаарх ойлголт мэдээлэл, мэдлэг хэрэгтэй байна.

Ялангуяа томоохон компаниуд гэхээсээ илүү тус компаниудад үйлчилгээ үзүүлж байдаг жижиг ханган нийлүүлэгчдийг энэ талаар ойлголттой болгох шаардлага байгааг онцолсон.

Цааш алхахын тулд олон улсын стандарт, чанарын шаардлага хангасан ханган нийлүүлэгч, бүх бүтээгдэхүүн нь гологдолгүй гарч байх дотоодын нийлүүлэгчдийг бэлтгэх хэрэгтэй байна. Яг ийм зарчмын талаар хэд хэдэн том компаниуд санал тавьсны дагуу энэ салбарт үйл ажиллагаа явуулах ойлголт анх төрсөн. 2011 оны үед энэ чиглэлээр судалгаа явуулж байхад манай улсад чанарын удирдлага гэдэг ойлголт тааруу байсан. Үүнээс хойш багагүй өөрчлөлт гарсан. Засгийн газрын мөрийн хөтөлбөрт ч чанарын удирдлагын талаарх бүх үйл ажиллагааг дэмжих талаар тусгаж өгсөн.

-Чанарын удирдлага гэдэг ойлголт шинэ төдийгүй бүхий л салбарт дутмаг байгаа нь үнэн. Энэ бүгд юунаас шалтгаалж байна вэ?

-Бидний зорилго дотоодын үйлдвэрлэл эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх юм. Худалдааны компани бол манай үйлчлүүлэгч биш гэж ойлгож болно. Нэг газраас аваад нөгөөд зарж байгаа бол манай үйлчлүүлэгч биш. Монголын бизнес эрхлэгчид олон хүчин зүйлээс болоод өрсөлдөх чадвар муутай байна.

Макро эдийн засгийн орчин тогтвортой биш, зах зээл жижиг, дэд бүтэц муу хөгжсөн зэргээс өрсөлдөх чадвар тааруу байна. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг сайжруулах зорилгоор үндсэн хоёр төрлийн үйл ажиллагаа явуулдаг. Энэ нь ханган нийлүүлэгчдийн хөтөлбөр юм. Бид үүгээрээ томоохон худалдан авагч нарт яаж бүтээгдэхүүн нийлүүлэх вэ, тэдний тавьсан шаардлагад яаж нийцүүлэх тал дээр анхаарч ажиллаж байна. Тухайлбал, томоохон худалдан авагчид бид Монголоос худалдан авах сонирхол байна.

Гэхдээ тэд чанарын шаардлага хангахгүй, хугацаандаа нийлүүлж чадахгүй байна гэсэн асуудал тулгардаг гэдэг. Энэ үйлдэлд бид чанар болоод ханган нийлүүлэлтийн тал дээр тусламж

үзүүлдэг. Шаардлагатай бол санхүүгийн дэмжлэг үзүүлдэг. Мөн чанарын удирдлагын хөтөлбөр үйлчилгээгээр бид бизнес эрхлэгчид ард түмэнд ойлголт өгөх зорилгоор сургалт зохион байгуулж байна. Өнөөдрийн байдлаар хүнсний аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал, ISO 9001-ийн олон улсын сертификаттай сургалт зохион байгуулж байна.

-Өнөөг хүртэл хэчнээн байгууллагатай хамтарч чанарын түвшинд ахиц гаргасан байна вэ?

-Ханган нийлүүлэгчдийн тухайд чанарыг эрхэмлэхийг уриалдаг. Манай ихэнх үйлчлүүлэгч өөрсдийн чадах зүйлийг үйлдвэрлэхээд түүнийгээ зарах гээд байдаг. Харин бидний зүгээс "Та зарж чадах зүйлээ л үйлдвэрлэ" гэж зөвлөдөг. Монгол Улс уул уурхайгаас хамаарсан эдийн засагтай, ирээдүйд хөгжих боломж бий. Гэхдээ уул уурхайн ханган нийлүүлэгчдийг хөгжүүлэх замаар жижиг, дунд бизнесээ хөгжүүлэх боломжийг ашиглах хэрэгтэй.

Эрдэнэт, Оюутолгой ханган нийлүүлэлт бүгд дотоодоос хангагдаж байвал бид хөгжинэ гэсэн үг. Одоогоор 30 орчим байгууллагад чанарын удирдлага буюу дээр хэлсэн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Манай үйлчлүүлэгчид тодорхой худалдан авагчтай, өөрийн гэсэн үйлчлүүлэгчидтэй хэдий ч зах зээлээ бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байна гэсэн үүднээс манайд ханддаг. Чанарын удирдлагын талаарх сургалтад 350 орчим жижиг, дунд бизнес эрхлэгчдийн 600 гаруй хүн сургалтад хамрагдаад байна.

-Дотооддоо үйлдвэрлэснээр хэмнэлт хэр гарч байна вэ?

-Үнийн хувьд ойролцоо байдаг ч хамгийн гол нь цаг хугацаа, тээврийн зардал хэмнэнэ. Мөн найдвартай ханган нийлүүлэгчтэй болдог учраас дотооддоо хөгжүүлэх сонирхол их байна.

-Чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх гэхээр санхүүгийн асуудал тулгамддаг тухай үйлдвэрлэл эрхлэгчид хэлдэг?

-Ихэнх үйлдвэрлэгчийн хувьд санхүүгийн асуудлаас илүү

менежментийн тааруу байдлаас болдог. Бизнес санааны хувьд та юу хийх гэж байгаа, худалдан авагчид нь хэн байх вэ гэхэд зах зээл дээр гараад шууд л гацахаар санаа байдаг. Өнөөдөр та 10 бүтээгдэхүүн гаргаж байсан бол маргааш 100 хийхэд хэрэглэгчид яагаад авна гэж бодож байна вэ гэсэн асуултад л манайхан уначихдаг. Худалдагч худалдан авагч нарын харилцаа илүү албан ёсны, итгэл үнэмшилтэй байх хэрэгтэй. Томоохон байгууллагуудын хувьд өдөр тутмын санхүүгийн асуудлаас гарсан байдаг. Харин жижиг ханган нийлүүлэгчдийн хувьд өдөр тутмын орлогоосоо санхүүждэг зэрэг санхүүгийн хувьд асуудал болж магадгүй. Манайд хандаж байгаа жижиг, дунд бизнес эрхлэгчдийн 50-60 хувь нь мөнгөний гэхээсээ илүү менежментийн асуудалтай байдаг.

-Харилцагч байгууллагуудын хувьд чанарт анхаарч ажиллаж байгаа салбарт төдийгүй түлхүү хөгжүүлбэл зохих салбар нь юу вэ?

-Саяхныг хүртэл салбарын хязгаарлалт байгаагүй. Сүүлийн жилүүдэд барилга, арьс, ноос, ноолуурын салбарт харилцагчид их бий. Яваандаа мах, ноос ноолуур, хүнсний ногоо, мэдээллийн технологи, үйлчилгээ гэсэн зургаан салбарт үйл ажиллагаагаа өргөжүүлнэ.

Монгол Улс хоёр том гүрний дунд орших учир аль нэг салбарт түлхүү анхаарч ажиллах хэрэгтэй. Дээр хэлсэн салбаруудыг анхаарах юм бол ихэнх түүхий эд нь дотооддоо, байгаа салбар юм. Манайд бүтээмж муудсаар байгаа. Тухайлбал, мал аж ахуйн салбарт хонь их байлаа гээд бид махны дутагдалд орж байна.

Түүнийгээ боловсруулж чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн гарахгүй байгаагаар хэмжиж болно. Хөдөө аж ахуйн салбараа хөгжүүлэлгүйгээр хөгжсөн хоёрхон л улс байдаг. Сингапур, Хонконг. Хөдөө аж ахуйн салбарын хөгжил малын тоогоор бус бэлтгэж буй махны нөөцөөр тодорхойлогдоно. ■



КОМПАНИУДЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ БЭЛТГЭХ, ЧАДАВХЖУУЛАХ 100 ЦАГИЙН СУРГАЛТ

■ СУРГАЛТЫН АЧ ХОЛБОГДОЛ:

Гүйцэтгэх захирлуудад зориулсан цогц сургалтад хамрагдсанаар байгууллагын дээд түвшний удирдлагын зайлшгүй эзэмших ёстой мэдлэгийг асар богино хугацаанд олж авч өөрийн компанидаа шууд хэрэглэх боломжтой арга-зүйд суралцаж, сургалтын эхний өдрөөс өөрчлөлт, амжилтыг мэдрэх өргөн боломжтой.

■ ХААНА:

“Бишрэлт” Зочид
Буудал “Хурлын танхим”

■ ХЭЗЭЭ:

2015.09.17 - 10.03 Долоо хоногийн
ПҮРЭВ, БААСАН, БЯМБА
гаригийн 09:00-17:00 цагт
явагдана.

■ ХЭН ХАМРАГДАЖ БОЛОХ ВЭ:

Компанийн эзэд, Гүйцэтгэх захирал, захиралд бэлтгэгдэж буй чадварлаг менежер, гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтнууд

■ ҮНДСЭН БА ЧИГЛҮҮЛЭГЧ БАГШ НАР:

- Глобал Стратегийн Удирдлагын Институт-Ц.Оюунжаргал
- Менежментийн Холбоо-Д.Цэрэндорж
- Имако Консалтинг- Р.Лхагвадулам
П.Эрдэнэтулга, Б.Энхтүвшин
- Имако Консалтинг хуулийн зөвлөх- Л.Отгонбаяр

№1 CEO TRAINING SERIES

СТРАТЕГИЙН УДИРДЛАГА БА 21-Р ЗУУНЫ МАНЛАЙЛАЛ

- Менежментийн орчин үеийн чиг хандлага
- Стратегич сэтгэхүй ба стратегийн төлөвлөлт
- Стратегийн шинжилгээний хэрэгслүүд
- Байгууллагын стратеги ба багцын удирдлага
- Шинэ зууны удирдагчийн эзэмшвэл зохих ур чадварууд
- Компаний санхүүгийн удирдлага
- Компаний санхүүгийн шинжилгээ
- Байгууллагын стратеги ба Мэдээллийн технологийн шийдлүүд



№2 CEO TRAINING SERIES

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ БА ГЭРЭЭНИЙ ЭРХЗҮЙ

- Компанийн засаглал ба гүйцэтгэх удирдлага
- Бизнесийн стратеги ба стратегийн сонголт
- Маркетингийн стратеги: Үнэ цэнийг бүтээх нь
- Гүйцэтгэлийн үнэлгээ ба гүйцэтгэлийн удирдлага
- Хэлцэл хийх чадварыг хөгжүүлэхүй
- Оролцогч талуудын зохистой удирдлага
- Бизнесийн болон гэрээний эрхзүй



№3 CEO TRAINING SERIES

ӨӨРЧЛӨЛТИЙН УДИРДЛАГА БА УДИРДЛАГЫН СЭТГЭЛЗҮЙ

- Өөрчлөлтийн удирдлага
- Асуудлыг шийдвэрлэх болон шийдвэр гаргах арга техникүүд
- Манлайллын ёс зүй
- Авьяасын удирдлага
- Өндөр гүйцэтгэлтэй багийг хөгжүүлэх нь
- Удирдлагын сэтгэлзүйн орчин үеийн чиг хандлага
- CEO ба байгууллага доторх эерэг харилцаа
- Мэдлэгийн менежмент



№4 CEO TRAINING SERIES

ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГА БА БРЭНД МАРКЕТИНГ

- Бизнес төлөвлөлт
- Гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоо: BSC, KPI
- Гомдлын менежмент
- Зөрчлийн менежмент
- Брэнд маркетинг
- Маркетингийн хөгжүүлэлт
- Санхүүгийн удирдлага ба мөнгөн урсгал
- Эрсдэлийн удирдлага
- Гэрээний эрхзүй





Аюуми Кониши: Шаардлагатай хөрөнгө оруулалтыг зогсоож болохгүй

О.Түвшин

Азийн хөгжлийн банкны Зүүн Азийн газрын захирал Аюуми Конишитэй ярилцлаа. Тэрбээр Азийн хөгжлийн банкны БНХАУ болон Монгол Улс дахь үйл ажиллагааг хариуцдаг бөгөөд өнгөрсөн наймдугаар сарын 24-28-ны хооронд Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн (CAREC) үндэсний гол цэг хуралд оролцохын зэрэгцээ Монголын өндөр түвшний албан тушаалтнуудтай уулзахаар манай улсад ирсэн билээ. Түүнчлэн өнгөрсөн есдүгээр сард болж өндөрлөсөн Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн Сайд нарын бага хуралд оролцсон юм.

-Бараг хүн бүр л Азийн Хөгжлийн Банкны талаар мэддэг, харин олон хүмүүс "CAREC" гэж юу болохыг мэдэхгүй байх. Та "CAREC"-ийн талаар дэлгэрэнгүй ярьж өгөөч?

-CAREC-ийн хөтөлбөр буюу Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр нь Төв Азийн орнуудын гишүүдийн хамтын хөгжил

цэцэглэлтийн төлөө хамтран ажиллахад оршиж буй юм. Уг хөтөлбөр 1997 онд байгуулагдсан бөгөөд Монгол Улс 2003 онд гишүүнээр нэгдсэн. Төв Азийн орнуудаас гадна БНХАУ-ын Шинжан Уйгарын болон Өвөр Монголын өөртөө засах бүс нутаг CAREC-ийн гишүүд юм. CAREC-тай холбоотой хөрөнгө оруулалт болон 10 төслөөс Монгол Улс ойролцоогоор 530 сая ам.долларын туслалцаа авсан. Улаанбаатараас Замын-Үүд хүрэх авто замыг сайжруулсан гэх мэтээр хөтөлбөртэй холбоотой төслүүдээс жишээ дурьдаж болно.

Хөтөлбөрийн хүрээнд бид Хятад болон Орос улстай холбож буй Ховд, Баян-Өлгийг дамжин өнгөрөх баруун бүс нутгийн авто замыг хөгжүүлэх ажлыг хэрэгжүүлж байна. Бид авто замын дэд бүтцийг сайжруулснаар Монгол Улс бүс нутгийн бусад улс хоорондын харилцаа холбоог улам нэмэгдүүлнэ гэж найдаж байна. Энэ нь дэд бүтцийн хувьд ярьж буй асуудал. Харин бодлогын хэмжээнд авч үзвэл хөтөлбөрийн хүрээнд гаалийн үйл явц, хилийн боомтын зохион

байгуулалтыг уялдуулан зохицуулах, илүү хялбар болгох зэрэг санаачлага хэрэгжүүлж байгаа. Хятад, Монголын замын хөтөлбөр нь хамтарсан гаалийн хяналтын туршилт бөгөөд Тянжиний боомтоос Хятадын ачааны тэргүүд Улаанбаатар хот хүртэл шууд хүрэх, харин Монголын тээврийн хэрэгслүүд Улаанбаатараас Хятадын газар нутаг руу шууд нэвтрэх хэлэлцээр хийсэн.

-Уг хурлын гол сэдвийн нэг хөдөө аж ахуйн болон мах, махан бүтээгдэхүүний зохицуулалт. Гишүүн 10 орон үүнээс гадна юуг онцлон авч хэлэлцэж буй вэ?

-Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр нь дөрвөн ажлын хэсэгтэй. Үүнд тээвэр, эрчим хүч, худалдааны хөнгөлөлт болон худалдааны бодлого багтана. Ажлын хэсэг салбаруудын цаашдын төлөвлөгөөг танилцуулах юм. Ийм ч учраас дээрхийг батлах шийдвэр гаргах нь Сайд нарын бага хурлын ач холбогдол оршиж буй юм. Тээврийн салбарын хувьд, сайжруулсан замын аюулгүй байдлын асуудал нь чухал сэдэв. Худалдааг хөнгөвчлөх,

худалдааны бодлогын хэсгийн хувьд SPS (ариун цэвэр,эрүүл ахуйн)стандарт болон хүнсний худалдааны эрүүл ахуйн шаардлагын асуудлыг чухалчлах хэрэгтэй. Харин эрчим хүчний салбарын хувьд эрчим хүчний шинэчилсэн бодлого, түүний дотор сэргээгдэх эрчим хүчний хөгжлийг голчлон авч үзэх учиртай. Үүний нэг тод жишээ бол БНХАУ-ын “Нэг бүс, Нэг зам”-ын санаачлага юм. Хятадын Засгийн газар бүс нутгийн болон дэд бүтцийн холбоог сайжруулахад их хэмжээний хөрөнгө зарахад бэлэн байгаагаа илэрхийлсэн.

Зөвхөн Хятад улс ийм байр суурьтай байгаа хэрэг биш. БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын-Хе энэ талаар ярьсаар буй. Үүнийг зохицлоох илүү сайн харилцаа холбоог хайхаар эрмэлзэж байна. Японы Ерөнхий сайд Шинзо Абэ дэд бүтцийн чанартай хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай талаар ярьж байна.

Азийн дэд бүтцийн хөгжлийн банк болон БРИКС-ийн орнуудын Хөгжлийн банк зэрэг нь бүс нутгийн дэд бүтцийг сайжруулах шаардлагад анхаарлаа хандуулж байна. Энэ утгаараа Сайд нарын бага хурал CAREC-ийг гишүүн орнууд өөрсдийн үзэл бодлоо хуваалцаж,холбогдох орнуудын хөрөнгө оруулах сонирхлыг ашиглах давуу талыг бүрэн бүрдүүлж өгч буй үр дүнтэй хөтөлбөр болж байгаа юм. Хятадын “Нэг бүс, Нэг зам” санаачлага,Азийн хөгжлийн банк Япон болон БНСУ зэрэг бүс нутгийн дэд бүтцэд хөрөнгө оруулах сонирхолтой улсуудыг баяртайгаар хүлээн авах болно.

Гэсэн ч “Нэг бүс,Нэг зам” санаачлага нь зөвхөн БНХАУ-ын санаачлага хэвээр байна. Ийм санаачлагыг хэрэгжүүлэхийн тулд холбогдох бүх улс орон Хятад, БНСУ болон Япон улстай санаачлагаа нэгтгэх хэрэгтэй. Бодол санаа нэгдсэн цагт төсөл хэрэгжиж эхлэнэ шүү дээ. Хэрэв CAREC холбогдох улс орнуудын санаачлагаа нэгтгэх тавцан болж чадаж байгаа бол энэ нь маш ач холбогдолтой гэсэн үг.

-Таны хэлснээр “Нэг бүс,Нэг зам”-ын бодлого нь БНХАУ-ын санаачлага. Гэхдээ энэ нь бүс нутгийн хэмжээнд маш том нөлөөтэй. Энэхүү бодлогод Монгол Улс ямар байр суурь эзлэх вэ?

-Хоёр талтай. Нэгдүгээрт,Хятад улс бусад орны дэд бүтцийн харилцаа

холбоог сайжруулж хөгжүүлэх тал дээр туслахад бэлэн байгаа. Хоёрдугаар, Хятад дотроо өөрсдийн муж нутгуудаа илүү сайн харилцаа холбоог ашиглан бусад улстай харилцаагаа сайжруулахыг дэмжиж байна. Үүнд Шинжан болон Өвөр Монголын өөртөө засах бүс нутаг багтаж байгаа. БНХАУ зөвхөн дотоодын зах зээлдээ анхаараад зогсохгүй бусад оронтой харилцах стратегийг чухалчилж байгаа юм. Иймээс Монгол Улсад энэ давуу талыг ашиглах боломж бий гэсэн үг.

Дараагийн алхам бол Монгол Улс өөрийн гэсэн алсын харааг бий болгож зөвхөн Хятад гэлтгүй Төв Азийн бусад оронтой өөрсдийн үзэл бодол алсын хараагаа хуваалцах юм. Тэгэхээр энэ нь зөвхөн Хятад-Монголын асуудал биш юм.

Миний бодлоор Монгол Улс бусад улстай харилцаа холбоогоо сайжруулснаар ямар үр дүнд хүрэх вэ гэдгээ сайн бодох ёстой. БНХАУ-ын “Нэг бүс,Нэг зам”-ын санаачлага нь Монгол Улсын хувьд давуу талыг ашиглаж болох чухал боломж байх магадлалтай.

-Азийн хөрөнгө оруулалтын талаар ярь. Монгол Улс хөрөнгө оруулалтад суурилсан эдийн засагтай. Хөрөнгө оруулалт буурахад тэр нь эдийн засагт ихээхэн нөлөөлдөг. Азийн орнуудаас,тэр дундаа CAREC-ийн гишүүн орнуудаас ямар төрлийн хөрөнгө оруулалт ирж байна вэ. Аль салбар эдгээр хөрөнгө оруулалт түлхүү хүртэж байна вэ?

-Яг энэ мөчид АХБ-ны эдийн засгийн судалгааны хэлтэс дүн шилжилгээгээ хийж байгаа учраас дүгнэлт хийх боломжгүй. Одоогийн нөхцөл байдлаас харахад дэлхийн эдийн засгийн өсөлт бидний зургаан сарын өмнө таамаглаж байснаас арай өөр болсныг харж байна. Дэлхийн нийт эдийн засгийн хувьд АНУ болон Японы эдийн засгийн сэргэлт тооцоолж байснаас их хугацаа шаардаж байна. Хятадын эдийн засгийн өсөлт удааширлаа. Гэхдээ би үүнийг саарч байна гэж хэлэхгүй. Учир нь хэрвээ тэд долоон хувийн өсөлтөд хүрч чадвал хангалттай сайн үзүүлэлт байх болно.

Гэтэл зарим хөгжингүй орны эдийн засгийг аваад үзвэл тэд долоон хувийн өсөлтөд хүрнэ гэж найдахгүй байна шүү дээ. Хятад улс дунджаас дээгүүр түвшний

орон болж байгаа бөгөөд тэдний өсөлтийн хурд хоёр оронтой тооноос долоон хувь болж байна. Миний бодлоор энэ нь зайлшгүй өөрчлөлт гэж бодож байна. Ийм учраас бид БНХАУ-ын дарга Си Жиньпиний “Энэ нь шинэ норм” гэж хэлснийг маш их үнэлж байна. Хятадын эдийн засаг Азийн эдийн засгийн томоохон хэсэг учир энэ ухралт олон оронд нөлөөлж байгаа. Хятад улс нь ашигт малтмалын томоохон импортлогч. Зөвхөн Монгол гэлтгүй Австрали зэрэг Хятадын экспорт хийдэг олон оронд Хятадын хөрөнгө оруулалт болон экспортын удаашралт нөлөөлж байгаа. Үүнийг ойлгож хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Энэ утгаараа бүс нутгийн харилцаа холбоо болон хамтын ажиллагаанд хөрөнгө оруулж,цаашид нэмэгдүүлэх сонирхол нэмэгдсэн болов уу. Өөр санаачлагууд ч хэрэгжиж байна. Жишээ нь, АСЕАН-ы эдийн засгийн хамтын ажиллагааны нийгэмлэгийг бий болгох,Транс-Номхон далайн орнуудыг сайжруулах замаар өсөлтийн шинэ эх үүсвэр бий болгох гэж оролдож байна. Миний хувьд бүс нутгийн интеграцийг буюу глобальчлалыг сайжруулах хөрөнгө оруулалт илүү байх болов уу гэж үздэг. Энэ нь заавал дэд бүтцийн хөрөнгө оруулалт гэсэн үг биш. Харин бодлогын талаас эдийн засгийн интеграци болон хамтын ажиллагааг сайжруулахыг хэлж байгаа юм. Дүрэм журмыг уялдуулахад илүү их нөөц бололцоо шаардлагатай.

Хэдийгээр Монгол Улсад тийм ч хамааралгүй боловч хөгжингүй орнууд мөн Хятад гэх мэт улсуудын нийгэм хөгширч байна. Тэдний эрэлт хэрэгцээний хэв маяг өөрчлөгдөх болно. Хятадын талаар нэмж хэлэхэд, тус улсын цалингийн түвшин маш хурдан өсч байна.

Ингэснээр БНХАУ хямд өртөгтэй үйлдвэрлэлийн орон гэх давуу талаа эдийн засгийн өрсөлдөөнд ашиглах боломжгүй болно гэсэн үг. Энэ нь тэдгээр үйлдвэрүүд өөр улс руу шилжиж, өөр хөдөлмөрийн зардал багатай улсад хөрөнгө оруулалт хайна гэсэн үг юм. Харин Хятад улсын хувьд хөрөнгө оруулалтаа,аж үйлдвэрийн эдийн засгаа илүү үйлчилгээ,хэрэглээ дамагйлсан эдийн засагт шинэчлэн шилжүүлэх болно.

-CAREC-ийн гол зорилго нь бусад олон улсын байгууллагатай адил бүс нутгийн интеграцид чиглэсэн байх нь. Хамтран зохицуулсан гаалийн болон худалдааны бодлогод хүрэхийн тулд Монгол Улс өөрийн зүгээс юу хийх ёстой вэ. Дугагдал нь юунд оршиж байна вэ. Дэд бүтэц үү эсвэл хууль эрх зүйн орчин үү?

-Аль аль нь. Гэвч зөвхөн Монгол ийм байдалд байгаа биш юм. Юун түрүүнд Монгол Улсыг энэ жил CAREC-ийн үйл ажиллагааг нутагтаа зохион байгуулж буйд гишүүн орнууд талархаж байгааг дурьдах нь зүйтэй. CAREC-ийн хүрээнд бүс нутгийн хамтын ажиллагааг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэж байна. Бид юун түрүүнд дөрвөн гол чиглэл болох зам тээвэр, эрчим хүч, худалдааны хөнгөлөлт болон худалдааны бодлогын талаар ярьсан.

Чиглэл дор бүрнээ дэд бүтцийн болон бодлогын асуудалтай байгаа. Монголын баруун бүс нутгийн замын ажлыг хийсээр байна. Замыг сайжруулж дууссаны дараагаар хилийн байгууламжийг сайжруулах талаар илүү ойлголттой болно. Дараа нь хилийн зохицуулалтаа уялдуулахад илүү хялбар болох юм.

Жишээлбэл, Оросоос Хятад руу зорчих тээврийн хэрэгсэл дөрвөн зогсолт хийхийн оронд хоёр зогсдог болвол үйл ажиллагаа хурдсах болно шүү дээ. Мөн бид Монгол Улсыг Хятадаар дамжин Төв Азийн бусад оронтой худалдаа хийхийг хүсэж байна. Бид дөнгөж эхэлж байна. Гэхдээ бидний урд хийх олон зүйл байна. Бодлого, ажил зэрэг явах ёстой.

-Монголчуудын дийлэнх нь ойрын ирээдүй болон чиг хандлагын талаар сөрөг бодолтой байна. Дундаж монгол иргэн эдийн засгийн хувьд улс байтугай өөрийн ирээдүйдээ санаа зовох хандлагатай болсон байна. Энэ гутранги байдал хэр үндэслэлтэй гэж бодож байна вэ?

-Гутрах үндэслэлгүй гэж бодож байна. Эдийн засгийн хувьд хөдөө аж ахуйн салбар ган тохиосны улмаас тодорхой асуудлуудтай нүүр тулж байгаа. Энэ нь бидэнд илүү хүнд хэдий ч богино хугацааны эдийн засгийн төлөвийг зураглахад хүргэж болох.

Зарим хүн зөвхөн уул уурхайн салбарыг харж байна. Уул уурхайн

салбар уналт, сэргэлтийн мөчлөгтэй. Олон улсын зах зээлийн байдлаас үүдэн энэ салбар маш тогтворгүй байгаа. Түүнчлэн дундаж иргэдийн амьдралд анхаарлаа хандуулвал Монгол Улс эдийн засгаа төрөлжүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, шинэ боломжуудыг нээх зэрэг оролдлого хийж байна. Миний бодлоор бүтээгдэхүүнээ төрөлжүүлж бусад өсөж буй зах зээлд худалдах олон боломж бий.

Монгол Улс Хятад руу экспортлох ашиг малтмалд гол анхаарлаа хандуулсаар ирсэн. Хятад улс үйлдвэрлэлийн эдийн засгаас илүү хэрэглээ, үйлчилгээ давамгайлсан өсөлт рүү шилжиж байна. Хэрвээ Монгол Улс Хятадын худалдан авагчдад анхаарлаа түлхүү хандуулвал боломжууд байна. Япон болон Азийн бусад эдийн засаг сайжрахын хэрээр боломжууд нэмэгдэх болно.

Гутранги хандлагыг зөвтгөхгүй байх хоёр үндэслэл байна. Нэгдүгээрт, дан ганц уул уурхайн салбарт анхаарлаа төвлөрүүлэхээс гадна илүү өргөн хүрээнд харж эдийн засгаа төрөлжүүлэх. Уул уурхайн салбар таг зогсчихоогүй байна. Оюутолгойн хоёрдугаар шатны хэлэлцээр шийдэгдсэн. Бидэнд хэлэлцээрийн талаар тодорхой санал хэлэх эрх байхгүй. Гэхдээ Засгийн газар зарим маргаан, асуудлыг зохицуулж хэлэлцээрт хүрч байна. Мөн Монголын уул уурхайн салбар эдийн засагт оруулах хувь нэмрээ дээшлүүлэх бүрэн боломжтой.

-Макро эдийн засгийн удирдлагын хувьд Монгол Улсын өрийн хэмжээ нэмэгдсэн. "Чингис" бондын эхний ээлжийн эргэн төлөлт болох хагас тэрбум ам.долларыг төлөх хугацаа дөхөж байна. Монгол Улс Грек шиг нөхцөл байдалд хүрэх эрсдэл бий юу?

-Би тэгж бодохгүй байна. Монголын нийт өрийн хэмжээг Монголын нийт ашигт малтмалын ордтой харьцуулвал өрийн хэмжээ олон улсын стандартын хувьд тийм ч их биш. "Чингис" бондын эргэн төлөх хугацаа ойртож байгаа учир хамгийн гол нь үр дүнтэй өрийн удирдлага болон макро эдийн засгийн удирдлагыг ирэх 2-3 жилд явуулах хэрэгтэй. Үүний дараагаар өрөө төлөх эсвэл сунгах талаар ярих нь зүйтэй. Бэрхшээл мэдээж тулгарна. Гэхдээ Монгол Улсын эдийн засаг боломжийн

түвшинд өсч байна гэж харж байна.

Ойрын гурван жилийн хувьд макро эдийн засгийн удирдлагын хувьд хүндхэн жилүүд байх болно. Хэдий тийм ч Монгол Улс зайлшгүй шаардлагатай дэд бүтэцдээ хөрөнгө оруулах хэрэгтэй. Иргэдийнхээ аж амьдрал, боловсрол, эрүүл мэндийг сайжруулахад шаардлагатай хөрөнгө оруулалтаа зогсоох ёсгүй. Ирээдүйн хөгжил цэцэглэлтэд хувь нэмрээ оруулах ямар хөрөнгө оруулалт байна гэх мэтээр хөрөнгө оруулалтын өгөөжид анхаарлаа хандуулах ёстой. Нөхцөл байдал хүнд харагдаж байна гээд зээлээ зогсоох ёстой гэж бодохгүй байна.

Бид Монгол Улсын нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг дэмжих 150 сая ам.долларын зээлийг батлах гэж байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн таван хувийн босгод хүрэхийн тулд шаардлагатай мөнгийг олоход хэцүү байх болно. Иймд дээрх зээлийг авахгүй гэвэл нийгэмд маш том хохирол учрах болно.

Нийгмийн болоод иргэдийн аж амьдралыг тогтвортой байлгах үүднээс АХБ-ны 150 сая ам.долларын зээлийг авах нь зүйтэй бөгөөд бүрэн үндэслэлтэй юм.

Монгол Улсын хувьд хэвийн хурдад орж эхлэхэд зээлийг эргэн төлөлт илүү хялбар болно. Зээлийн нөхцөл, зарцуулалтад анхаарлаа хандуулах нь маш чухал. АХБ-ны үг зээл хямд бөгөөд 15 жилийн хугацаанд эргэн төлөх юм. Тиймээс орлогын урсгал их хэмжээгээр орж ирэх хэрээр зээлийн эргэн төлөлт илүү хялбар байх болно. Хүмүүс энэ бүхнийг ойлгоосой гэж хүсэж байна.

-Манай уншигчдад хандаж хэлэх зүйл тань юу вэ?

-Бид гэрэлт ирээдүйг төсөөлж байна. Хүмүүс бага зэрэг тэвчээртэй хандахын зэрэгцээ дунд хугацааны үр дүнг хараасай. Богино хугацааны үр дүнд гутрах хэрэггүй.

Хүмүүс 10, 20 жилийн дараах ирээдүйгээ харж зовхи нь өөдөө байгаасай гэж хүсч байна. Бид үр бүтээлтэй хөрөнгө оруулалтыг үргэлжлүүлж, ард иргэдэд хөрөнгө оруулж, мөн мэдээж хэрэг АХБ Монгол Улсын итгэмжлэгдсэн түнш байсаар байх болно хэмээн итгэж байна. ■

Сайн засаглалтай "Баянгол" ХК

Товч танилцуулга

"Баянгол" ХК нь анх 1964 онд байгуулагдан 1992 оны нэгдүгээр сарын 27-нд Монголын хөрөнгийн биржид бүртгэгджээ. Тус компани нь 423,065 ширхэг энгийн хувьцаа гаргасан ба компанийн зах зээлийн үнэлгээ 20,7 тэрбум төгрөгт хүрсэн. /2015 оны 09.11 байдлаар/. Тус компани нь МХБ-ийн шилдэг хувьцаат компаниудын нэг төдийгүй компанийн засаглалыг бодитоор хэрэгжүүлдэг хамт олон. 2009 оны гуравдугаар сарын 15-нд Санхүүгийн Зохицуулах Хороо, СЭЗДС-аас зохион байгуулсан "Компанийн засаглалын хөтөлбөр" сургалтад хамрагдсан анхны гишүүн байгууллага юм.

"Баянгол" ХК нь олон улсад баримталдаг компанийн засаглалын үндсэн зарчмуудыг бодитоор хэрэгжүүлж буй үлгэр жишээ сайн засаглалтай компанийн тоонд зүй ёсоор ордог.

Хувьцаа эзэмшигчдийн хурал, Ногдол ашиг тараасан байдал

"Компанийн тухай" хууль болон "Компанийн засаглалын кодекс"-д заасны дагуу жил бүр Хувьцаа Эзэмшигчдийн хурлаа зарлаж, тухайн жилийн борлуулалтын ашиг, эдийн засаг, санхүүгийн тайлант мэдээгээ хувьцаа эзэмшигчиддээ танилцуулж тайлагнаж хэвшсэн байгууллага юм.

Баянгол хувьцаат компани нь МХБ-д бүртгэгдсэнээс хойш 20 удаа нийт 2.4 орчим тэрбум төгрөгийн ногдол ашгийг тараасан байна. Энэ хугацаанд нэг хувьцааны ногдол ашиг 119-355 төгрөгийн хооронд хэлбэлзэж байсан байна. Дэлгэрэнгүйг хүснэгтээс харна уу.

Төлөөлөн удирдах зөвлөл


Тус компани нь "Компанийн засаглалын кодекс"-ын

тавдугаар бүлэгт заасны дагуу "ТҮЗ-ийн гишүүдийг ХЭХ-аар сонгосон ба нийт есөн гишүүний гурав нь хараат бус гишүүд байна. ТҮЗ нь улиралд хоёр удаа хуралдаж бизнес төлөвлөгөөг батлах, стратеги, бодлогыг тодорхойлон батлах зэрэг дотоод томоохон асуудлыг ТҮЗ-ийн гишүүдийн хамтын хүчээр удирдаж, хувь нийлүүлэгчид болон бусад оролцогч талуудын зохистой ашиг сонирхлыг хамгаалж, гүйцэтгэх удирдлагын багийг удирдлагаар ханган чиглүүлж хувьцаа эзэмшигчдийн өмнө үйл ажиллагаагаа бүрэн дүүрэн тайлагнадаг.

Санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдал

Тус компани нь "Компанийн засаглалын кодекс"-ын долоодугаар бүлгийн холбогдох зүйл заалтуудыг тогтмол дагаж мөрддөг төдийгүй сүүлийн гурван жилийн санхүүгийн тайлангаа "ФИСКАЛ АУДИТ" ХХК-иар хянуулж, тайлангаа хуулийн хугацаанд нь Монголын Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороо, Татварын Ерөнхий газар, Нийгмийн даатгалын хэлтэс зэрэг байгууллагад ирүүлдэг. Мөн тухайн жилийн балансын мэдээ мэдээллийг өдөр тутмын сонинд тавьж, олон нийтэд танилцуулдаг уламжлалтайгаас гадна компанийн албан ёсны цахим хуудсыг ажиллуулж түүгээр дамжуулан санхүүгийн болон бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ мэдээллийг тогтмол олон нийтэд түгээдэг.

"Үнэт цаасны зах зээлийн тухай" хууль, "Компанийн засаглалын кодекс" зэрэг эрх зүйн актууд шинэчлэгдэн батлагдсантай уялдуулан 2012 онд "Компанийн дүрэм" болон холбогдох бусад дүрэм журамд хувьцаа эзэмшигчдийн эрх, хувьцаа эзэмшигчдийн хурал, ногдол ашгийн бодлого зэрэгтэй холбоотой нэмэлт өөрчлөлтийг оруулсан байна. ■



Э.Уранбилэг: Тэтгэврийн сангийн сул талыг нөхнө

“Ард Актив”-ын гүйцэтгэх захирал Э.Уранбилэгтэй ярилцлаа.

-Та байгууллагынхаа талаар товч танилцуулаач?

“Ард Актив” нь хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагааг дагнан эрхэлж буй хамт олны хувьд салбартаа анхдагч болох “Монголын Тэтгэврийн Нэрийн Данс” (МТНД) ХХК-ийг үүсгэн байгуулж, таван жилийн туршид 1700 гаруй ажилчдын тэтгэврийн сангийн удирдлагыг хэрэгжүүлэн ажиллаж байсан. 2012 онд 1.7 тэрбум төгрөгийн ашигтайгаар тэтгэврийн хадгаламжийг эргүүлэн олгож байсан туршлагатай. Бид “Хувийн Тэтгэврийн Сан”-гийн үйл ажиллагааг өргөжүүлэн, жигдрүүлэх, дэлхийн жишигт нийцсэн тогтолцоог эх орондоо уялдуулан нутагшуулах зорилго тавин ажиллаж байна.

-Сүүлийн үед хувь хүмүүс болон бизнесийн байгууллагууд хувийн тэтгэврийн сангийн талаар сонирхох болсон. Тиймээс та энэ талаар тодорхой мэдээлэл өгөөч?

Хувийн тэтгэврийн сан нь иргэд болоод ажилчдыг нэмэлт орлого, тэтгэврээр хангаж, хэвийн амьдрах баталгааг олгодог нэг төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн юм. Өөрөөр хэлбэл, үүнийг улсын тэтгэврийн сангийн бодлого, тогтолцооны сул талыг нөхөхөөр гарч ирсэн үйлчилгээ гэж ойлгож болно.

Хувийн тэтгэврийн санд хамрагдсан ажилчин бүр тэтгэврийн нэрийн данстай байх болж юм. Тус дансанд сар бүр ажилчин, ажил олгогч хоёр ижил хэмжээний мөнгө хийн хуримтлуулж, энэхүү хуримтлалыг “Хувийн тэтгэврийн сан” ажилчны өмнөөс өсгөж, гэрээт хугацаа дууссаны дараа тухайн нэрийн дансанд хуримтлагдсан мөнгийг ажилтанд эргүүлэн олгох зарчмаар ажилладаг. Манай улсын хувьд энэ нь харьцангуй шинэ бүтээгдэхүүн хэдий ч бусад хөгжингүй болон хөгжиж буй

орондхувийн тэтгэврийн санг өөрсдийн улсын онцлогт тохируулан хөгжүүлж, үр ашгийг нь хүртсээр ирсэн. Тухайлбал, Швед, Норвеги, Австрали, Голланд зэрэг улсын ажиллагсдын 90 хувь, Герман, АНУ зэрэг орны ажиллагсдын 50 гаруй хувь нь хувийн тэтгэврийн санд хамрагдсан байдаг.

-Улсын тэтгэврийн сангийн сул талыг нөхөх гэдэг дээр та нэмэлт тайлбар өгөөч?

Тэтгэврийн нэрийн дансанд ажил олгогч болон ажилчин гээд хоёр талаас нийлэн хуримтлал үүсгэж байгаа ч тухайн хуримтлал нь бүхэлдээ ажилтны хувийн өмч байдаг. Өөрөөр хэлбэл, ажилтан тодорхой хугацааны эцэст тухайн мөнгийг ганцаар захиран зарцуулах бүрэн эрхтэй.

Тиймээс өөрийн нэрийн данс дээрх хуримтлалын тодорхой хувийг ашиглаж байгаад тухайн хүн нас барахад үлдсэн мөнгөө өөрийн үр хүүхэд, хань, гэр бүлдээ өвлүүлэн үлдээх боломжтойгоороо улсын тэтгэврийн сангийн дутагдалтай талыг нөхөж байгаа юм. Үүнээс гадна тухайн хуримтлалаа сар бүр тодорхой хэмжээгээр хэрэглэлгүйгээр нэг дор бүх мөнгөө авах боломжийг ч олгодог.

-Ер нь арилжааны банкуудын хугацаатай хадгаламжийн үйлчилгээтэй ижил зарчмаар ажилладаг гэж ойлголоо?

Хуримтлал татаж, тухайн мөнгийг хадгалуулагчийн өмнөөс өсгөж өгдгөөрөө ижил ч хувийн тэтгэврийн сан илүү өндөр өсөлт амладаг. Энэ нь ажил олгогч байгууллагатай тохиролцсоны дүнд ажилтны данс руу нэмэлт хуримтлал татдагтай холбоотой.

Ажилтны зүгээс харах юм бол хуримтлал үүсгэсэн эхний сардаа л өөрийнхөө мөнгийг нэг дахин нэмэгдүүлчихэж байгаа юм. Тухайлбал, би энэ сард нэрийн дансандаа 10 мянган төгрөг хийхэд миний ажилладаг байгууллагаас мөн ийм хэмжээний мөнгийг миний нэрийн



данс руу шилжүүлж нийт 20 мянган төгрөгтэй болно. Мөн үүн дээр сар бүрхүүгийн орлого нэмэгдэж бодогдоно. Тэгэхээр тухайн ажилтанд тун ашигтай хадгаламж гэсэн үг.

-Тэгвэл ажил олгогч байгууллагуудад энэхүү үйлчилгээг сонгосноор ямар нэг давуу тал бий болох уу?

Бизнесийн байгууллагууд давхар нийгмийн даатгалын шимтгэл төлдөг шүү дээ. Хувийн тэтгэврийн санг байгууллагадаа нэвтрүүлснээр ажилчдынхаа ирээдүйг харсан, хүний нөөцийн урамшууллын системээ дэмжиж буй нэг хэлбэр. Энэ нь хүний нөөцийн бодлого, системдээ ихээхэн анхаарах шаардлагатай болсон өнөө үед том давуу талыг байгууллагуудад бий болгоно. Мөн хуримтлалын тодорхой хэмжээг байгууллагаас төлж байгаа учир тухайн ажилтан хуримтлал үүсгэснээс хойш хэр урт хугацаанд ажилласныг харгалзан үзээд байгууллагын төлсөн мөнгөний хэдэн хувийг тухайн ажилтанд олгохыг тохиролцож болдог.

Ингэснээр тухайн байгууллагын ажилчид тогтвор суурьшилтай ажиллах нэгэн шалтгаан болж, тогтвортой ажилчдын тоо нэмэгддэг. Өөр нэг давуу тал нь хувийн тэтгэврийн сан тухайн байгууллагад найдвартай эрсдэлийн санг бий болгодог. Тухайлбал, ажилтан байгууллагад хохирол учруулчихаад

ажлаасаа гарсан нөхцөлд тухайн хохирлыг ажилчны хуримтлалаас суутган авах боломжтой. Эдгээрээс гадна тэтгэврийн санд хамрагдсан байгууллага нэмэлт санхүүгийн эх үүсвэртэй болж, тухайн тэтгэврийн санг удирдаж буй санхүүгийн байгууллагаас зээл авах боломж нээгддэг зэрэг давуу тал бий.

-Цаашид энэхүү санхүүгийн

бүтээгдэхүүний зах зээл хэр өргөжиж бол. Бусад улс оронд үүнийг амжилттай хэрэгжүүлсэн шиг бид эх орондоо хувийн тэтгэврийн санг нутагшуулж чадах болов уу. Энэ талаар та юу гэж бодож байна?

-Мэдээж боломжтой. Өмнө таны дурьдсанчлан ажилчид болоод хувь хүмүүс үүнийг ихээр сонирхох болсон. Өөрөөр хэлбэл, зах зээлд энэхүү

бүтээгдэхүүний эрэлт байна гэсэн үг. Гол нь үүнийг ахисан түвшинд нэвтрүүлэхэд үйл ажиллагааг дэмжсэн хууль эрх зүйн бодлого, орчин хэрэгтэй. 2015 онд Хувийн тэтгэврийн сангийн тухай хууль батлагдахаар хэлэлцэгдэж байна.

Энэхүү хууль батлагдсанаар "Тэтгэврийн Нэрийн Данс"-ыг хөгжүүлэх үйл ажиллагаа шинэ түвшинд гарна гэсэн хүлээлттэй байна. ■

Монголын анхны кастодиан банк



Голомт банк кастодиан банкны системийг амжилттай нэвтрүүлсэн болохоо өнгөрсөн сарын 24-нд зарлалаа.

Санхүүгийн Зохицуулах Хороо өнгөрсөн оны наймдугаар сард Монголд анх удаа үнэт цаасны зах зээлд кастодиан банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон. Тусгай зөвшөөрөл авсан Голомт банк NRI-ийн санхүүгийн шийдлийн системийг нэвтрүүлснээр бүрэн шийдэл бүхий кастодиан үйлчилгээг үзүүлэх боломжтой болж байгаа аж.

Консалтинг болон системийн шийдлийн салбарт тэргүүлэгч Nomura Research Institute (NRI) бүс нутгийн санхүүгийн салбарын хөгжлийг түргэсгэхэд хувь нэмрээ оруулсаар ирсэн.

Голомт банкны Кастодиан банкны газрын захирал Г.Зориг "Бид маш нарийн судалгаа хийсний эцэст системийн шийдэл санал болгож байсан олон компаниудаас шилж NRI-ийн санхүүгийн шийдлийн системийг сонгосон" гэв. Тэрээр нэмж хэлэхдээ "Бид NRI-ийн систем бат бөх, өргөтгөх боломжтой, уян хатан мөн ирээдүй рүү чиглэсэн бүтэцтэй төдийгүй хөрөнгө хадгалах. Мөн үнэт цаасны төлбөр тооцоо, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, үйлчлүүлэгчийн харилцаа холбоо, бэлэн мөнгөний болон сангийн удирдлага зэрэг шалтгаан нь бидний сонголтод нөлөөлсөн. Бид NRI Financial Technologies India-ийн туршлагатай IT инженерүүд болон домэйний мэргэжилтнүүдэд үнэхээр сэтгэл хангалуун байна. Тэд Голомт банктай нягт хамтран ажилласны үндсэнд ердөө гурван сарын дотор системийн шийдлийг нэвтрүүлж чадлаа" гэсэн юм.

NRI-ийн санхүүгийн шийдлийн систем нь хөгжсөн зах зээлд шаардлагатай функц болон дизайныг шинээр гарч ирж буй зах зээлд шаардлагатай уян хатан үйлдэлтэй хослуулсан

нь Монголын зах зээлд нэн тохиромжтой аж. Зарим гол онцлогоос дурьдвал: Түргэн шуурхай худалдааны бүртгэл, төлбөр тооцооны төв, хадгаламж болон тооцооны банктай бодит цагын горимоор төлбөр тооцоохийх, Real-time balance updates бодит цагын балансын мэдээ, авто тохиргоо болон мэдэгдэл. Мөн SWIFT, XML, XLS болон бусад олон форматанд тохирдог, өндөр чанартай тайлан гаргалт, аж ахуйн нэгжийн баримт бичиг болон шилжүүлгийн алдааны мэдэгдэл, лавлагаа мэдээлэл, гүйлгээний мэдээллийг тохируулах олон түвшний зөвшөөрөл болон уян хатан, өргөтгөх боломжтой систем.

NRO Financial Technologies India-ийн ерөнхийлөгч Тору Ватанабе "NRI нь хөгжиж буй зах зээлд технологийн нарийн шийдлийг нэвтрүүлж улмаар уян хатан, өргөтгөх боломжтой системээр хангаж дэлхийн түвшний мэдээллийн технологийн дэд бүтцийг бий болгодог. Мөн хөрөнгө оруулагчдын итгэл, зах зээлийн өсөлтийг дэмжих зорилготой" гэв.

NRI-ийн тухай: Nomura Research Institute, Ltd. ("NRI", TYO: 4307) нь 1965 онд байгуулагдсан, мэдээлэл технологийн шийдэл болон консалтинг үйлчилгээг үзүүлдэг бөгөөд өнгөрсөн оны гуравдугаар сард дууссан санхүүгийн жилийн байдлаар 405.9 тэрбум иений жилийн борлуулалт хийсэн. NRI нь хэзээд инновацийг хийж ирсэн нь тэднийг олон улсын зах зээлийн итгэлтэй тэргүүлэгч болгосон аж.

NRI өөрийн бизнесийн консалтингийн давуу талаа ашиглан шинэлэг мэдээлэл технологийн шийдлээр хөрөнгө оруулалтын банк, хөрөнгийн менежер, банк болон даатгалын байгууллагуудыг хангадаг юм. Илүү мэдээлэл авахыг хүсвэл: www.nri.com сайтаар зочилно уу. ■

ТАНИЛЦУУЛГА

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан “Сэрэлт” ХХК нь “Сэрэлттакс ТМЗ” ХХК-ийг үүсгэн байгуулж Сангийн сайдын 2015 оны хоёрдугаар сарын 16-ны өдрийн 37 тоот тушаалын тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Харилцагчиддаа татвараа хуулийн дагуу үнэн зөв тодорхойлоход нь туслах үндсэн үүрэгтэй манай хамт олон татварын эрх зүйн орчныг тасралтгүй судалж шинжлэн, харилцагчдынхаа үйл ажиллагаанд учирч болох татварын аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, татварын эрсдэлгүй ажиллуулах үндсэн зорилт тавин ажиллаж байна.

Бид харилцагчдаа шаардлагатай мэдээлэл, зөвлөмжөөр цаг тухайд нь бүрэн хангах, аливаа эрсдлийг богино хугацаанд арилгах, заавар зөвлөмжийг хууль тогтоомжын хүрээнд хамгийн энгийн ойлгомжтой хувилбараар хүргэхийг зорьж, татварын хуулиудын өөрчлөлт, шинэчлэлүүдийг анхааралтай судалж мэдээллэн ажиллаж байна.

- Нягтлан бодох бүртгэлийн аутсорсинг үйлчилгээ
- Татварын зөвлөх үйлчилгээ
- Бусад зөвлөх үйлчилгээ

Хаяг: Чингэлтэй дүүрэг 1-р хороо
Энхтайваны гудамж, Denver оффис, 304 тоот
Утас/Факс: 99093541, 88002321